



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-37
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	38-126

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	38-82
3.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	82-125
3.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	125-126

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 11-ний өдөр /Лхагва гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 82 гишүүн хүрэлцэн ирж, 65.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 05 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Дэлгэрсайхан, Р.Эрдэнэбүрэн;

Чөлөөтэй: Ч.Анар, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баттулга, С.Ганбаатар, Д.Ганбат, С.Лүндэг, Э.Одбаяр, Г.Уянгахишиг;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-15 минут, Н.Алтаншагай-07 минут, С.Амарсайхан-36 минут, Т.Аубакир-26 минут, Ж.Батжаргал-05 минут, Б.Батцэцэг-2 цаг 12 минут, Ж.Бат-Эрдэнэ-05 минут, Ж.Баярмаа-26 минут, Ш.Бямбасүрэн-03 минут, Ж.Галбадрах-02 минут, Л.Гантөмөр-02 минут, Х.Ганхуяг-47 минут, Т.Доржханд-41 минут, Б.Жавхлан-15 минут, Х.Жангабыл-26 минут, Б.Жаргалан-16 минут, Б.Заяабал-45 минут, С.Зулпхар-02 минут, М.Мандхай-16 минут, Л.Мөнхбаатар-41 минут, Ц.Мөнхбат-49 минут, Ч.Номин-02 минут, О.Номинчимэг-17 минут, С.Одонтуяа-26 минут, Д.Рэгдэл-01 минут, Ц.Туваан-33 минут, Б.Тулга-02 минут, Б.Түвшин-20 минут, Г.Тэмүүлэн-10 минут, Д.Үүрийнтуяа-32 минут, Б.Хэрлэн-04 минут, Б.Энхбаяр-10 минут, Ж.Энхбаяр-44 минут, Д.Энхтүвшин-28 минут.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Бахүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, П.Сайнзориг, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал

Нэг.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Т.Аубакир, Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ, Ж.Баярмаа, Д.Ганмаа, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан, Б.Заяабал, Ж.Золжаргал, М.Мандхай, Ц.Мөнхбат, П.Мөнхтулга, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд, Р.Сэддорж, Б.Түвшин, Г.Уянгахишиг, С.Цэнгүүн, Б.Энхбаяр, Д.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 22.5.22 дахь заалтын “Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 11.1.1-д заасны дагуу Улсын Их Хурлаас баталсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 38

Бүгд: 109

65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, Б.Бейсен, Б.Жаргалан, Д.Батбаяр, С.Замира, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Ж.Алдаржавхлан, С.Зулпхар, Д.Үүрийнтуяа, С.Эрдэнэбат нарыг дэмжсэнээр тооцож, 75.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 22.14 дэх хэсгийн “үйл ажиллагааны орлогод үзүүлэх бусад” гэснийг “үйл ажиллагааны орлогын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 90

Татгалзсан: 21

Бүгд: 111
81.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтад доор дурдсан агуулгатай 22.15 дахь хэсэг нэмэх:

“22.15.Энэ хуулийн 22.5.22-т заасан импортыг орлох, экспортыг дэмжих салбар, үйл ажиллагаа, төслийн жагсаалтыг Улсын Их Хурал батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 90
Татгалзсан: 22
Бүгд: 112
80.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 27.11 дэх хэсгийн “холбогдох олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжид үндэслэн тооцож, зөвлөмжийн хамтаар” гэснийг “Монголбанкнаас зарласан тухайн татварын жилийн дунджаар тооцож дараагийн татварын жилийн 1 дүгээр сард багтаан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 90
Татгалзсан: 22
Бүгд: 112
80.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 92
Татгалзсан: 32
Бүгд: 114
82.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 38.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.4.Газар тариалангийн болон боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн иж бүрдэл, трактор, комбайныг импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 90
Татгалзсан: 24
Бүгд: 114

79.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 38.7 дахь хэсэг нэмэх:

“38.7.Энэ хуулийн 38.4-т заасан татварын хөнгөлөлтөд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.1-д заасны дагуу баталсан Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, түүний тодорхойлолтыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 95

Татгалзсан: 18

Бүгд: 113

84.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 97

Татгалзсан: 16

Бүгд: 113

85.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн “Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 60

Бүгд: 114

47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Н.Учрал, П.Сайнзориг нар үг хэлэв.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 41
Бүгд: 114
64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 86
Татгалзсан: 28
Бүгд: 114
75.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 93
Татгалзсан: 21
Бүгд: 114
81.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “батлагдсан өдрөөс” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 93
Татгалзсан: 21
Бүгд: 114
81.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн тэмдэглэх хэсэгт Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7 дахь заалт нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 94

Татгалзсан: 20
Бүгд: 114
82.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “, цаашид өөрчлөгдөхгүй байх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 96
Татгалзсан: 18
Бүгд: 114
84.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Төсвийн ил тод, үр ашигтай байдал, санхүүгийн хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 93
Татгалзсан: 21
Бүгд: 114
81.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гаргасан, “1/бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” гэсэн тухайн төрийн байгууллагын өөрсдөө хийх боломжгүй, тусгай мэргэшил, ур чадвар шаардагдах, гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээг тухайн ажлын төрөл, цар хүрээ, мэргэжлийн ур чадвар, зах зээлийн үнэлгээнд үндэслэн Засгийн газрын санхүүгийн статистик гаргах аргачлал, загварт нийцүүлж, зардлын эдийн засгийн зүйл болон зориулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний ангиллаар нарийвчлан тодорхойлох, цаашид жилийн төсвийн тухай хуульд тооцооллын хавсралтад нэмэлтээр тусгах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 92
Татгалзсан: 22
Бүгд: 114
80.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гаргасан, “2/төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн ерөнхийлөн захирагчид “бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” болон “бусад зардал” гэсэн зардлын ангиллаар төсөв зарцуулах болсон зайлшгүй шаардлага, гарах үр дүн, үр ашгийг тооцох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 95
Татгалзсан: 19
Бүгд: 114
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гаргасан, “3/олон улсын сайн туршлагад үндэслэн гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээнд хуулиар хязгаарлалт тогтоох, уг зардалд тавих шаардлагыг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгах, аудитын тайлангаар баталгаажуулах, олон нийтэд нээлттэй мэдээлэх зэрэг холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 92
Татгалзсан: 22
Бүгд: 114
80.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дэх заалт нэмэх:

“4.Төрийн байгууллагуудын мэдээллийн системүүд, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын программ хангамж, тоног төхөөрөмжүүдийн худалдан авалт, ашиглалтыг сайжруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, салбар хоорондын цахимжилтыг нэгдсэн удирдлагаар хангах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/төрийн байгууллагуудад ашиглаж байгаа мэдээллийн систем, программ хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын өнөөгийн байдал болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдалд аудит хийж тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 93
Татгалзсан: 21
Бүгд: 114
81.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмэх:

“5.Нийслэл Улаанбаатар хотоос шилжин байрших боломжтой төрийн байгууллагуудыг орон нутаг дахь төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжид нүүлгэх, нийслэл Улаанбаатар хотод чөлөөлөгдөх барилга байгууламжийн тоо байршил, зориулалтыг судалж, жагсаалтыг гаргаж 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж, холбогдох шийдвэр гарсны дараа худалдах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 94
Татгалзсан: 20
Бүгд: 114
82.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмэх:

“6.Төсвийн зардлыг шууд нэмэгдүүлж, төсвийн тэнцэлд сөргөөр нөлөөлөх Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудын талаар нэгтгэн судалж, 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 88
Татгалзсан: 26
Бүгд: 114
77.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дахь заалт нэмэх:

“7.Төсвөөс олгож буй бүх төрлийн татаас, урамшууллын эдийн засагт үзүүлж буй нөлөөлөлд судалгаа, шинжилгээ хийж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих болон төсвийн ачааллыг бууруулах зорилтуудыг уялдуулах санал боловсруулж 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 82
Татгалзсан: 32
Бүгд: 114
71.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 8 дахь заалт нэмэх:

“8.Цэвэр эрчим хүч, хогноос эрчим хүч гаргах асуудлыг зохицуулах, дэмжих, ногоон эрчим хүч, ногоон эдийн засгийн тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 84
Татгалзсан: 30
Бүгд: 114
73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 9 дэх заалт нэмэх:

“9.Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 81
Татгалзсан: 33
Бүгд: 114
71.1 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 88
Татгалзсан: 26
Бүгд: 114
77.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр. “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 88
Татгалзсан: 26
Бүгд: 114
77.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гаргасан, “2/Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн биелэлтэд үнэлгээ хийж, тусгай сан тус бүрийн зориулалт, төсөвлөлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийлгэж аудитын тайлан, Тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 86
Татгалзсан: 28
Бүгд: 114
75.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гаргасан, “3/гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийн эрэмбийг гаргаж, удаашралтай байгаа төслүүдийг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулан 2025 оны хоёрдугаар улиралд багтаан

Монгол Улсын Их Хуралд танилцуулах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 89
Татгалзсан: 25
Бүгд: 114
78.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гаргасан, “4/шинээр авах гадаад зээлийн санхүүжилтийг эдийн засгийн өсөлтийг дэмжих, Бүсчилсэн хөгжлийн бодлого, томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалтад чиглүүлж, цаашид хувийн хэвшил хийх боломжтой төслүүдийг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 82
Татгалзсан: 32
Бүгд: 114
71.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гаргасан, “5/төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд үүссэн өр, авлага, зээлийн асуудалд дүн шинжилгээ хийж, тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 90
Татгалзсан: 24
Бүгд: 114
78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гаргасан, “6/аудитын шалгалтаар илэрсэн аливаа зөрчлийн шинжтэй асуудал тус бүрийн хариуцлагын асуудлыг Төрийн аудитын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн хуульд нарийвчлан зохицуулах, холбогдох хууль хоорондын уялдааг хангах, хийдэл зөрчлийг арилгах хуулийн төслийг 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 87
Татгалзсан: 27
Бүгд: 114
76.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Г.Дамдинням нарын гаргасан, “7/Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор эмнэлгийн зориулалттай, шаардлага хангасан барилгыг хууль, тогтоомжид нийцүүлэн 5 жилийн дотор өөрийн өмчлөлд эцэслэн шилжүүлэн авах нөхцөлтэйгөөр санхүүгийн түрээсийн гэрээ байгуулж худалдан авах,” гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, П.Сайнзориг, Г.Тэмүүлэн нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан, “8/Америкийн Нэгдсэн Улстай байгуулсан агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу шууд нислэг хийх боломжийг бүрдүүлэх, үүнд шаардлагатай нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтыг нэвтрүүлэх зорилгоор навигацийн орлогоос шаардлагатай санхүүжилтийг 2025 оны төсвийн жилд зарцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 39
Бүгд: 114
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ц.Идэрбат, Ж.Чинбүрэн, О.Саранчулуун нарын гаргасан, “9/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа шинээр баригдах хөрөнгө батлагдаагүй нэн шаардлагатай зарим газар, байгууллагуудад түрээсийн барилга ашиглаж, үйл ажиллагаа явуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 49
Бүгд: 114
57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ц.Идэрбат, Ж.Чинбүрэн, О.Саранчулуун нарын гаргасан, “10/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа газар, байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээсийн зарчмаар хангах эрхийг төсвийн ерөнхийлөн захирагчид олгох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 81
Бүгд: 114
28.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Б.Энхбаяр, Л.Энх-Амгалан, Б.Жавхлан нар үг хэлэв.

2.Ажлын хэсгийн гаргасан, “Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/-нд даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 42
Бүгд: 114
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, “Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79
Татгалзсан: 35
Бүгд: 114
69.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 42
Бүгд: 114
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал

1.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Үндэсний зөвлөл” гэсний өмнө “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 44
Бүгд: 114
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.9 дэх заалт нэмэх:

“15.1.9.байгууллагын төсвөөр түүхэн үйл явдлын ой, салбарын зарим ажил, мэргэжлийн ажилтны тэмдэглэлт өдөр, бусад тэмдэглэх өдрийг тэмдэглэх” гэж нэмэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 47
Бүгд: 114
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Төслийн 1 дэх заалтад Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хүрээнд

Боловсролын зээлийн сангийн 2024 оны зарцуулаагүй үлдэгдлийг 2025 оны төсвийн эх үүсвэрт зарцуулах гэж нэмэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 57
Бүгд: 114
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Сангийн сайд Б.Жавхлан нэмэлт тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 47
Бүгд: 114

58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам саналаа татаж авсан тул дахин санал хураалт явуулаагүй болно.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир Төслийн 1 дэх заалтад Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хүрээнд Кино урлагийн сангийн 2024 оны зарцуулаагүй үлдэгдлийг 2025 оны төсвийн эх үүсвэрт зарцуулах гэж нэмэх гэсэн саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа “Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “а” заалтаас “Боловсролын салбарын нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар санхүүжих арга хэмжээ, сургууль, цэцэрлэг дотуур байрны хоолны материал худалдаж авах” гэснийг хасаж “Гадаад, дотоодын их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургуулийн сурагчид тэтгэлэг олгох, төрийн өмчийн их, дээд сургуулиудын тогтмол зардлыг төлөх, боловсролын салбарын ажилтнуудыг чадавхжуулах, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгох, олимпиад зохион байгуулах” гэж өөрчлөх гэсэн саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Боловсролын салбарт зарцуулах төсвийг нэмэгдүүлэх, Нэгдсэн Үндэсний Байгууллагаас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Боловсрол 2030, Инчоны тунхаглалын зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангамжийг сайжруулах, багш, ажилтны хөдөлмөрийн нөхцөлийг шинэчлэн тогтоох, цалин, хөлсийг тооцох шинэ аргачлал нэвтрүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/2026 оны төсвийн жилээс эхлэн Боловсролын салбарын төсвийн нийт зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 6 хувиас багагүй, эсвэл Улсын төсвийн нийт зардлын 18 хувиас багагүй байхаар тооцон боловсруулж, өргөн барих.

2/Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн зардлыг холбогдох хуулийн дагуу дараа жилийн төсөвт суулгаж өгөх.” гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 64
Бүгд: 114
43.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 62
Бүгд: 114
45.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

3.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/2025 оны Улсын төсөвт тусгагдсан бүх барилга байгууламжийн ажлын төсөвт өртөг, түүний магадлал үнэн зөв хийгдсэн эсэх, төсөвт өртгийг тооцож, магадлал хийх эрх бүхий этгээдүүдийн үйл ажиллагаа холбогдох хуулийн хүрээнд шударга явж байгаа эсэхийг хараат бусаар нягтлан шалгах ажлыг зохион байгуулж, үр дүнг 2025 оны эхний хагас жилд багтааж Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 60
Бүгд: 114
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлж, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа саналаа тайлбарлаж үг хэлэв.

2.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 7 дахь дэд заалт нэмэх:

“7/Хууль тогтоомжид зааснаас бусад яамдын чиг үүрэгтэй давхацсан зөвлөл, хороо, комисс, төв гэх мэт байгууллагуудыг татан буулгаж, чиг үүргийг холбогдох яамдад шилжүүлэх;” гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 63
Бүгд: 114
44.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг саналаа тайлбарлаж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нар нэмэлт тайлбар хийв.

4.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дэх заалтын “-Ургамал хамгааллын газар” гэсний дараа “, Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” хэсэгт “-Төмөр замын газар” гэж нэмэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 78
Татгалзсан: 36
Бүгд: 114
67.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар саналаа тайлбарлаж, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ж.Бат-Эрдэнэ, Б.Пүрэвдорж нар нэмэлт тайлбар хийв.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүүнийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро

эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн саналуудыг холбогдох хуулийн шаардлага хангасан эсэх талаарх дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар танилцуулав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал

Нэг.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр зохицуулалт хийх санал:

1.Урсгал зардал бууруулах санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Золжаргал, Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Т.Аубакир, Б.Бат-Эрдэнэ, Ж.Батжаргал, Ж.Баярмаа, Д.Ганмаа, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан, Б.Заяабал, М.Мандхай, Ц.Мөнхбат, Л.Мөнхтулга, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд, Б.Түвшин, Г.Уянгахишиг, С.Цэнгүүн, Б.Энхбаяр, Д.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан,

1.1.Дараах байгууллагын 2025 оны төсвийн жилд нэмэгдэхээр тооцсон шинэ орон тоог тодорхой хувиар бууруулахтай холбоотойгоор тухайн байгууллагуудын урсгал зардлыг доор дурдсан хэмжээгээр бууруулах. Үүнд:

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 23 орон тоог хасаж, урсгал зардлыг **1,484.1 сая** төгрөгөөр;

- Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 277 орон тоог хасаж, урсгал зардлыг **7,738.1 сая** төгрөгөөр;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 224 орон тоог хасаж, урсгал зардлыг **5,901.9 сая** төгрөгөөр;
- Дотоодын цэргийн байгууллагын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 245 орон тоог хасаж, урсгал зардлыг **5,899.9 сая** төгрөгөөр;
- Дотоод хэргийн их сургуулийн 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 107 орон тоог хасаж, урсгал зардлыг **2,720.5 сая** төгрөгөөр;
- Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 17 орон тоог хасаж, урсгал зардлыг **1,238.1 сая** төгрөгөөр;
- Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 29 орон тоог хасаж, урсгал зардлыг **1,603.5 сая** төгрөгөөр;
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 185 орон тоог хасаж, урсгал зардлын ангилал дахь цалин хөлс, шимтгэлийн зардлыг **8,250.1 сая** төгрөгөөр, тавилга, багаж, техник хэрэгслийн зардлыг **948.8 сая** төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг **650.0 сая** төгрөгөөр, нийт **9,848.9 сая** төгрөгөөр;
- Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 29 орон тоог хасаж, урсгал зардлыг **1,095.2 сая** төгрөгөөр;
- МОНЦАМЭ агентлагийн 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 3 орон тоог хасаж, урсгал зардлыг **82.9 сая** төгрөгөөр;
- Улсын Их Хурлын Тамгын газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 25 орон тоог хасаж, урсгал зардлыг **2,142.3 сая** төгрөгөөр;
- Шүүхийн сахилгын хорооны даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 9 орон тоог хасаж, урсгал зардлыг **309.4 сая** төгрөгөөр, нийт **40,064.7 сая** төгрөгөөр бууруулах.

1.2. Дараах байгууллагын 2025 оны төсвийн жилд зарим урсгал зардлыг доор дурдсан хэмжээгээр бууруулах. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь татаасыг **3,000.0 сая** төгрөгөөр;
- “Эрчим хүчний реформын үндэсний хороо”-ны мэдээлэл, сурталчилгааны зардлыг **9,000.0 сая** төгрөгөөр;
- Бүх төсөвт байгууллагын түлш халаалтын зардлыг **11,500.0 сая** төгрөгөөр;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцад тусгагдсан Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх хөтөлбөрийн зардлыг **2,000.0 сая** төгрөгөөр тус тус бууруулах.

1.3.Засгийн газрын тусгай сангийн зардал бууруулах санал:

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад тусгагдсан Архидан согтууруулахтай тэмцэх сангийн санхүүжилтийг **6,900.0 сая** төгрөгөөр бууруулах;
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцад тусгагдсан Байгаль орчин, уур амьсгалын сангийн санхүүжилтийг **698.5 сая** төгрөгөөр тус тус бууруулах.

2.Зардал нэмэгдүүлэх санал.

2.1.Хавдрын эмнэлгийн зориулалтаар ашиглах объектыг лизингээр авах эхний удаагийн төлбөрт **17,000.0 сая** төгрөг, тус эмнэлгийн тоног төхөөрөмжийн зардалд **6,881.7 сая** төгрөг, нийт **23,881.7 сая** төгрөгөөр Эрүүл мэндийн сайдын төсвийн зардлыг нэмэгдүүлэх;

2.2.Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд зориулж **31,400.0 сая** төгрөгөөр Боловсролын сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх;

2.3.Цэцэрлэг, 3 ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн байрны түрээсийн зардалд зориулж **10,000.0 сая** төгрөгөөр Боловсролын сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх;

2.4.Төслийн 2 дугаар хавсралтын ХХII.2.3.Хавдар судлалын үндэсний төвийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 5,762.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,881.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **2,881.4 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.5.Эрчим хүчний бодлогын шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх зориулалтаар Засгийн газрын Хэрэг эрхлэх сайдын төсвийн багцад **5,000.0 сая** төгрөг нэмж тусгах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 82
Татгалзсан: 32
Бүгд: 114
71.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Хоёр.Засгийн газрын тусгай сангийн нийт зардлыг нэмэгдүүлэхгүйгээр зохицуулалт хийх санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Боловсролын сайдын төсвийн багцад тусгагдсан Боловсролын зээлийн сангийн өмнө олгосон зээлийн эргэн төлөлтийг 33,604.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, тус сангийн нийт зардлыг нэмэгдүүлэлгүйгээр сангаас олгох зээл, тэтгэлгийн зардлыг зээлийн эргэн төлөлтөөс төвлөрүүлсэн дүнгээр санхүүжүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 90
Татгалзсан: 24
Бүгд: 114
78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцад тусгагдсан Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн өмнө олгосон зээлийн эргэн төлөлтийг 40,700.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 86
Татгалзсан: 28
Бүгд: 114
75.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулах санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XII.1.2.1.Батлан хамгаалах салбарын их засвар /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 27,975.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 5,938.2 сая төгрөгөөр бууруулж, Батлан хамгаалах салбарын тоног төхөөрөмжийн зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 91
Татгалзсан: 23
Бүгд: 114
79.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцад тусгагдсан Ойжуулалт хөтөлбөрийн зардлыг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, мөн сайдын их засварын зардлыг **1,500.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 81
Татгалзсан: 33
Бүгд: 114
71.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.52.Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 46,659.1 сая төгрөг, санхүүжих дүн 8,909.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,260.7 сая төгрөгөөр бууруулж, XVI.1.1.22.Баруун тойруугийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Увс, Улаангом сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 3,599.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,257.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг

1,260.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 83
Татгалзсан: 31
Бүгд: 114
72.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөрийг дэмжсэнээр тооцож, 73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.7.Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62.56 км /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 118,449.5 сая төгрөг, санхүүжих дүн 33,534.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,940.2 сая төгрөгөөр, XVI.1.1.5.Баруунбүрэн-Амарбаясгалант хийд чиглэлийн хатуу хучилттай авто зам, 33.4 км /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 41,089.4 сая төгрөг, санхүүжих дүн 16,435.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, энэ эх үүсвэрээр “Хушаат сумын улсын чанартай авто замтай холбох хатуу хучилттай авто замын дуусгал /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 13,880.4 сая төгрөг, санхүүжих дүн 6,940.2 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 81
Татгалзсан: 33
Бүгд: 114
71.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.130.Цэцэрлэгийн барилга худалдан авах, 300 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 24 дүгээр хороо/, хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 4,800.0 сая төгрөг, санхүүжих дүн 2,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Цэцэрлэгийн барилга, 300 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 5,969.6 сая төгрөг, санхүүжих дүн 2,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 88
Татгалзсан: 26
Бүгд: 114
77.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр өөрчлөх санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XXIV.3.2.Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 165.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Шүүхийн сургалт судалгаа, мэдээллийн академийн тоног төхөөрөмж” гэж өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 87
Татгалзсан: 27
Бүгд: 114
76.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 6.1.1.1 дэх дэд заалтын “Шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой өргөдөл мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн хувь” гэснийг “Шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой өргөдөл мэдээллийг шалгаж хуулийн хугацаанд шийдвэрлэсэн хувь” гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 80
Татгалзсан: 34
Бүгд: 114
70.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 7.1.8 дахь заалтын “Зөвлөмжийн хэрэгжилт” гэснийг “Зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан” гэж өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 41
Бүгд: 114
64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 11.1.1.1 дэх дэд заалтын “суурь он 2022” гэснийг “суурь он 2023” гэж өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 80
Татгалзсан: 34
Бүгд: 114
70.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVIII.1.31.“Сервис центр-2” дэд бүтцийн төв /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг 14, 16, 18 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 6,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 3,039.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, XVIII.1.19. Ногоон гудамж, дэд бүтэц /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 2,898.3 сая төгрөг, санхүүжих дүн 898.3 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 80
Татгалзсан: 34
Бүгд: 114
70.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVII.1.1.3.Соёлын төвийн барилга /Архангай, Өгийнуур сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 4,231.9 сая төгрөг, санхүүжих дүн 1,481.2 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 481.2 сая төгрөгөөр бууруулж, Таравчамбуулин хийдийн Авга дуганыг сэргээн засварлах /Архангай, Батцэнгэл сум/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 1,845.0 сая төгрөг, санхүүжих дүн 481.2 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 50
Бүгд: 114
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга саналаа тайлбарлаж үг хэлэв.

6.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVIII.1.1.Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 213,199.2 сая төгрөг, санхүүжих дүн 52,959.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 9,816.6 сая төгрөгөөр бууруулж, Сургуулийн барилга 960 суудал /Өмнөговь, Цогтцэций сум/, хэрэгжих хугацаа 2019-2025 он, төсөвт өртөг 6,713.6 сая төгрөг болон санхүүжих дүнг 9,816.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 82
Бүгд: 114
28.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зургаа.Бусад Байнгын хорооны санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцад “22.6.2.4-т тусгасан “Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлого боловсруулж, хэрэгжүүлэх” гэж, хэмжих нэгжийг “тоо” гэж, Суурь оныг “2023” гэж, Суурь түвшнийг “0” гэж, Зорилтот түвшнийг “1” гэсэн арга хэмжээ нэмэх гэсэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодын дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 42
Бүгд: 114

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц саналаа тайлбарлав.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.1.1 дэх дэд заалтын 2025 оны зорилтот түвшин “5” гэснийг “3” гэж өөрчлөх гэсэн Нийгмийн бодлогын болон Төсвийн байнгын хороодын дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 51

Бүгд: 114

55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар саналаа тайлбарлаж үг хэлэв.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.1.2 дахь дэд заалтын 2025 оны зорилтот түвшин “16” гэснийг “12” гэж өөрчлөх гэсэн Нийгмийн бодлогын болон Төсвийн байнгын хороодын дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 44

Бүгд: 114

61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.2.1 дэх дэд заалтын суурь түвшин “9386” гэснийг “1126” гэж, 2025 оны зорилтот түвшин “10500” гэснийг “1200” гэж тус тус өөрчлөх гэсэн Нийгмийн бодлогын болон Төсвийн байнгын хороодын дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 44

Бүгд: 114

61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.3.2 дахь дэд заалтын суурь түвшин “36” гэснийг “16.7” гэж, 2025 оны зорилтот түвшин “40” гэснийг “20” гэж тус тус өөрчлөх гэсэн Нийгмийн бодлогын болон Төсвийн байнгын хороодын дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 54

Бүгд: 114

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XXI.1.8.Налайх Дулааны шинэ эх үүсвэр 79МВт-ын эхний ээлжийн ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг/, төсөвт өртөг 56,354.9 сая төгрөг, санхүүжих дүн

16,906.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Нэгдсэн эмнэлгийн барилга /Улаанбаатар, Налайх дүүрэг” гэж өөрчлөх гэсэн Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 64
Бүгд: 114
43.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 65
Бүгд: 114
43.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 38.1.2 дахь дэд заалтад “зам тээврийн осолд өртсөн хүүхдийн тоог бууруулах” гэсэн агуулгатай 38.1.2.3 дахь дэд заалт шинээр нэмж, Хэмжих нэгж “тоо” гэж, Суурь он “2023” гэж, Суурь түвшин “780” гэж, Зорилтот түвшин “300” гэсэн арга хэмжээг нэмэх гэсэн Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороодын дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 48
Бүгд: 114
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 17.1.1 дэх дэд заалтад “төрийн өмчит компаниудын хөрөнгийн өгөөжийн дундаж үзүүлэлт” гэсэн агуулгатай 17.1.1.3 дахь дэд заалт шинээр нэмж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь он “2023” гэж, Суурь түвшин “-” гэж, Зорилтот түвшин “20” гэсэн арга хэмжээг нэмэх гэсэн Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороодын дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 59
Бүгд: 114
48.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц саналаа тайлбарлав.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал

Нэг.Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 7.1.5.1 дэх дэд заалтын “Хууль тогтоомжийн хэрэгжилт” гэснийг “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан” гэж өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 86
Бүгд: 114
24.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар саналаа тайлбарлаж үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 64
Бүгд: 114
43.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.4.1.Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй, био технологийн сургуулийг Дархан, Сэлэнгийн бүс рүү нүүлгэхтэй холбоотой зураг төсөв /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 800.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг болон XIV.1.4.2.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик, тээврийн сургуулийг Хөшигийн хөндий рүү нүүлгэхтэй холбоотой зураг төсөв /Хөшигийн хөндий/ хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 800.0 сая төгрөг гэсэн 2 төсөл, арга хэмжээг хасаж төслийн XIV.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг 32,474.5 сая төгрөг, санхүүжих дүн 31,474.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 57
Бүгд: 114
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар саналаа тайлбарлаж үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 48
Бүгд: 114
57.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 46
Бүгд: 114
59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.2.Мандал сумын Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр хүртэлх хатуу хучилттай авто зам /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 52,425.4 сая төгрөг, санхүүжих дүн 15,727.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр, XVI.1.1.7.Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62.56 км /Төвийн бүс/ хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 118,449.5 сая төгрөг, санхүүжих дүн 33,534.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 7,950.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, Налайх-Чойр чиглэлийн авто замаас Баянцагаан сум хүртэлх хатуу хучилттай 64.4 км авто замын эхлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 33,017.9 сая төгрөг, санхүүжих дүн 9,950.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 43
Бүгд: 114
62.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.75.Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 124.5 км /Дорнод/, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг 185,514.9 сая төгрөг, санхүүжих дүн 45,632.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын Биеийн тамир, спортын хөтөлбөр, арга хэмжээний Үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 72
Бүгд: 114
36.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа саналаа тайлбарлаж үг хэлэв.

5.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.7.Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62.56 км /Төвийн бүс/ хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 118,449.5 сая төгрөг, санхүүжих дүн 33,534.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 33,533.9 сая төгрөгөөр бууруулж, Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай автозамын дуусгал /Говийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 160,140.6 сая төгрөг, санхүүжих 33,533.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 45
Бүгд: 114
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Бусад Байнгын хорооны санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XIX.1.2.Дархан арьс ширний цогцолбор"-ын бүтээн байгуулалтын арьс ширний үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Дархан-Уул, Хонгор сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 23,814.7 сая төгрөг, санхүүжих дүн 7,144.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Төвийн бүсийн хөнгөн хүнсний үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц /Дархан-Уул, Хонгор сум/” гэж өөрчлөх гэсэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон, Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 68
Бүгд: 114
40.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцын 22.6.1.1 дэх дэд заалтыг “Монгол Улсын бүх хот суурин буюу хүн ам төвлөрсөн газруудад озон, PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл, хүхрийн давхар исэл, азотын давхар исэл зэрэг агаар дахь түгээмэл тархалттай үндсэн бохирдуулах бодис тус бүрийн хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг хэмжих” гэж, суурь оныг “2023” гэж тус тус өөрчлөх гэсэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 57
Бүгд: 114
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцын “22.6.1.2. дахь дэд заалтыг “Улаанбаатар хот болон 21 аймгийн төвүүдэд агаарын чанарын иж бүрэн автомат суурин харуул суурилуулах” гэж өөрчлөх гэсэн Байгаль

орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон, Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 53
Бүгд: 114
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын “30.8.1.2.Санхүүжилт авсан хоршоодын орлогын өсөлтийн хувь” гэж, хэмжих нэгжийг “хувь” гэж, суурь оныг “-” гэж, Суурь түвшинг “-” гэж, Зорилтот түвшинг “10” гэсэн арга хэмжээг нэмэх гэсэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 64
Бүгд: 114
43.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор Улаанбаатар хотод байрлаж байгаа хувийн сургуулиудын хувьсах зардлыг 38,500.0 сая төгрөгөөр бууруулж, Хөдөө орон нутгийн дотуур байрны хангамжийг сайжруулах, нийслэл дэх сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг 38,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын болон Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналаа татсан тул санал хураалт явуулаагүй болно.

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн нэмэлт тайлбарлаж үг хэлэв.

6.Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийн 13.1.4 дэх заалтад “Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн”-гийн нэршлийг “Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарсан маргааныг хянан шийдвэрлэнэ” гэж өөрчлөх гэсэн Ёс зүй, дэгийн байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 69
Бүгд: 114
39.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн саналаа тайлбарлаж үг хэлэв.

7.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Цахим, хөгжил инновац, харилцаа холбооны сайдын багцын урсгал зардал дахь Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн Бусдаар гүйцэтгүүлэх үйлчилгээний зардлыг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын сайдын урсгал зардал дахь сургуулийн өмнөх боловсролын гүйцэтгэл үр дүнгээр олгох санхүүжилтийг 1,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 68
Бүгд: 114
40.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам саналаа тайлбарлаж, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нар нэмэлт тайлбар хийж үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 77
Татгалзсан: 37
Бүгд: 114
67.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 80
Татгалзсан: 34
Бүгд: 114
70.2 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 31.4.4.2 дахь дэд заалтын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдаж ажилтай болсон хүнсний тусламж, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг иргэн” гэснийг “Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо” гэж, суурь түвшин “35281” гэснийг “172963” гэж, 2025 оны зорилтот түвшин “35633” гэснийг “183778” гэж өөрчлөх гэсэн Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 60
Бүгд: 114
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар саналаа тайлбарлав.

9.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 31.6.1.1 дэх дэд заалтын Шалгуур үзүүлэлт “Нийт гэр бүлд гэрлэлт цуцлалтын эзлэх хувь хэмжээ” гэснийг “Нийт гэр бүлд гэр бүлийн талаарх сургалтад

тэнхим, цахимаар хамрагдсан гэр бүлийн эзлэх хувь”, суурь түвшин “2.2” гэснийг “0” гэж, 2025 оны зорилтот түвшин “<2.2 буурна” гэснийг “20” гэж өөрчлөх гэсэн Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 82
Бүгд: 114
28.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар саналаа тайлбарлаж үг хэлэв.

10.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төрийн албан хаагчийн цалинг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 6 хувиар нэмэгдүүлж, холбогдох санхүүжилтийг хэмнэсэн 219.0 тэрбум төгрөгийг Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх дараах мега төслийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд зарцуулах. Үүнд:

1/Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл
2/Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл
3/Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх төсөл
4/Улаанбаатар хотын төвийн дулаан хангамжийн төсөл
5/Улаанбаатар хотын ногоон орон сууц төсөл гэсэн Нийгмийн бодлогын болон Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 84
Татгалзсан: 30
Бүгд: 114
73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг саналаа тайлбарлаж, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн нэмэлт тайлбар хийж үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдыг дэмжсэнээр тооцож, 74.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 31.4.4.1 дэх дэд заалтын Шалгуур үзүүлэлт “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан иргэдээс 3 ба түүнээс дээш сарын хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэн” гэснийг “Байнгын ажлын байранд зуучлагдсан хүний тоо” гэж, 2025 оны зорилтот түвшин “14564” гэснийг “15154” гэж өөрчлөх гэсэн Нийгмийн бодлогын байнгын хороо болон Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 64
Бүгд: 114
43.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар саналаа тайлбарлаж үг хэлэв.

12.Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн гаргасан, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Дотоод хэргийн их сургуулийн 2025 онд шинээр нэмэгдэх орон тоог 30 хувиар бууруулж, буурсан орон тоотой холбоотой урсгал зардлыг бууруулах замаар Төслийн 2 дугаар хавсралтын XI.1.Барилга байгууламж, XI.2., XI.3, XI.4, XI.5, XI.6 дахь хэсгийн “тоног төхөөрөмж”-ийн төсөвт өртөг болон санхүүжих дүнг нийт 21,200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 38
Бүгд: 114
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын хөрөнгө оруулалт, их засварын зардлыг 9,800.0 сая төгрөгөөр бууруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны норматив зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналаа татсан тул санал хураалт явуулаагүй болно.

14.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтийг 991.0 сая төгрөгөөр бууруулж, Авлигатай тэмцэх газрын даргын томилолтын зардлыг 533.2 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 112.6 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 345.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 89
Татгалзсан: 26
Бүгд: 114
78.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал саналаа тайлбарлаж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү нэмэлт тайлбар хийж үг хэлэв.

15.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтийг 620.5 сая төгрөгөөр бууруулж, Монгол Улсын Ерөнхий Прокурорын томилолт, зочны зардлыг 420.5 сая төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 200.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

16.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Сангийн сайдын төсвийн багцын Сангийн яамны хөрөнгө оруулалт, их засварын зардлыг 5,065.0 сая төгрөгөөр бууруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын урсгал зардлыг доор дурдсан дүнгээр нэмэгдүүлэх. Үүнд:

1.Цагдаагийн ерөнхий газрын томилолт, бичиг хэргийн зардлыг 2,900.0 сая төгрөгөөр;

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын томилолт, бичиг хэргийн зардлыг 245.0 сая төгрөгөөр;

3.Хил хамгаалах ерөнхий газрын байр ашиглалтын зардал 1,000.0 сая төгрөгөөр;

4.Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн татаас санхүүжилтийг 920.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх гэсэн Хууль зүйн болон Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 78

Татгалзсан: 36

Бүгд: 114

68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд саналаа тайлбарлаж, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Сангийн сайд Б.Жавхлан нар нэмэлт тайлбар хийж үг хэлэв.

17.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын Хөрөнгө оруулалт, их засварын зардлыг 4,055.0 сая төгрөгөөр бууруулж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хөрөнгө оруулалтын зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн Хууль зүйн болон Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 83

Татгалзсан: 31

Бүгд: 114

72.8 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.25.Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай авто зам, 54.18 км /Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 66,766.5 сая төгрөг, санхүүжих дүн 20,302.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр бууруулж, Дулааны цахилгаан станцын 2 дугаар хэлхээний гадна шугам сүлжээ /Баянхонгор/, санхүүжих дүн 3,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 65

Бүгд: 114

43.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар саналаа тайлбарлаж үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 59

Бүгд: 114

48.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

19.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 18.1.1.1 дэх дэд заалтын “бодлого, төлөвлөлтийн баримт бичиг” гэснийг “дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах” гэж өөрчлөх гэсэн Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 60

Бүгд: 114

47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц саналаа тайлбарлаж үг хэлэв.

20.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 38.1.2 дахь дэд заалтад “замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай урьдчилан сэргийлэх сургалтыг ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулах” гэсэн агуулга бүхий 38.1.2.2 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын харгалзах мөрөнд Хэмжих нэгж: Тоо гэж, Суурь он: 2023 гэж, Суурь түвшин: - гэж, Зорилтот түвшин: 200 гэж тус тус нэмэх гэсэн Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 73

Бүгд: 114

35.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

21.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Төслийн 13 дугаар хавсралтын Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багц дахь Эрчим хүчний реформын үндэсний хорооны төсвийг 400.0 сая төгрөгөөр бууруулж, цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд цохиулахаас урьдчилан сэргийлэх стандартыг шинэчлэх, хичээлийн хөтөлбөр боловсруулах, сургагч багш нарыг бэлтгэх, сургах, стандартыг ашиглаж хэвшүүлэх, бодит байдал нь стандартын дагуу байгаа эсэхэд үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгох төсөлд 400.0 сая төгрөгөөр Эрчим хүчний сайдын урсгал зардалд нэмж тусгах гэсэн Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 44

Бүгд: 114

61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг саналаа тайлбарлаж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал нэмэлт тайлбар хийж үг хэлэв.

22.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл нарын гаргасан, Төслийн 13 дугаар хавсралтын Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багц дахь Эрчим хүчний реформын үндэсний хорооны төсвийн 11,986.1 сая төгрөгийг 9,000.0 сая төгрөгөөр бууруулах гэсэн Эдийн засгийн болон Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 85
Татгалзсан: 29
Бүгд: 114
74.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “батлагдсан өдрөөс” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 88
Татгалзсан: 26
Бүгд: 114
77.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогыг **1,556.7 сая** төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 89
Татгалзсан: 25
Бүгд: 114
78.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “батлагдсан өдрөөс” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 84
Татгалзсан: 30
Бүгд: 114
73.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогыг **694.0 сая** төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 89
Татгалзсан: 25
Бүгд: 114
78.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёололд нийцүүлэн хуулийн төсөлд өөрчлөлт оруулах санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах зардалд өөрчлөлт оруулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, ангилал, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнтэй уялдуулж төсөвт өртгийг өөрчлөх, мөн төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томьёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 85
Татгалзсан: 29
Бүгд: 114
74.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын

дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 20 цаг 15 минутад хэлэлцэж дуусав

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 10 минут үргэлжилж, 126 гишүүнээс 116 гишүүн хүрэлцэн ирж, 92.0 хувийн ирцтэйгээр 20 цаг 15 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 15 цаг 05 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа. Төсвийн ажлын хэсэг, Төсвийн байнгын хороо бусад Байнгын хороод бас хуралдаж төсвийн төслийн талаар бас өргөн хүрээний хэлэлцүүлэг өнгөрсөн өдрүүдэд бас зохион байгуулагдаж байна. Ингээд өнөөдөр бас Улсын Их Хурлын ээлжит чуулганыг хуралдуулж төсвийн 2 дугаар хэлэлцүүлгийг явуулахаар байгаа. Мөн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулахаар байгаа. Ингээд Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал байна.

Нэгдүгээрт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хоёрдугаарт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хийнэ.

Гуравдугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл танилцуулна аа. Индэрт урьж байна.

Б.Мөнхсоёл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар явуулж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон холбогдох Байнгын хороодод шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 10, 11-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж

байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын даргын 2024 оны 303 дугаар захирамжаар Монгол Улсын Их Хурлын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэнгээр ахлуулан Улсын Их Хурлын 26 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулсан.

Уг ажлын хэсэг нь хөрөнгө оруулалт, урсгал зардал, Засгийн газрын тусгай сан төрийн өмчит аж ахуйн нэгж, гадаад зээл тусламж болон төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн талаар судалж дүгнэлт гаргах үүрэг бүхий дэд ажлын хэсгүүдэд хуваагдан ажиллаж, дэд ажлын хэсэг бүрийн гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн олонхын саналаар шийдвэрлэж, дэмжигдсэн саналуудыг Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулсан.

Дээрх ажлын хэсгээс ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд бүтээн байгуулалтын салбар, үйл ажиллагаа, төслийн жагсаалтыг Улсын Их Хурал батлахаар Гаалийн татвар, тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд гаалийн татварын хөнгөлөлт эдлэх салбарт газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэх, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг Засгийн газар сонгон шалгаруулахаар зохицуулсныг хасах, Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид буцаах, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хэрэгжих хугацааг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болгож өөрчилсөн саналуудыг гаргасан, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд төсвийн ил тод үр ашигтай санхүүгийн хариуцлагыг сайжруулах зорилгоор бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр, хураамж, зардлын эдийн засгийн ангиллын төсвийн ерөнхийлөн захирагч болон зориулалт, арга хэмжээний нэр, төрлөөр жилийн төсвийн тухай хуулийн тооцооллын хавсралтад тусгаж байх, гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнд хуулиар хязгаарлалт тогтоох, уг зардалд тавих шаардлагыг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны стратеги, төлөвлөгөөнд тусгах, аудитын тайлангаар баталгаажуулах, олон нийтэд нээлттэй мэдээлэх зэрэг холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох саналуудыг гарган ирүүлсэн.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар төсөвт багтаан шийдвэрлэх, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх, Тусгай сан тус бүрийн төсөвлөлт, зарцуулалт, зориулалтын асуудлаар гүйцэтгэлийн аудит эс үгүй бол олон улсын итгэмжлэгдсэн аудитын байгууллагаар аудит хийлгэж аудитын дүгнэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулах, Гадаад зээлийн

хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийн эрэмбийг гаргаж удаашралтай байгаа төслүүдийг шийдвэрлэх талаар санал боловсруулан 2025 оны 2 дугаар улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд үүссэн өр, авлага, зээлийн асуудалд дүн шинжилгээ хийж тайланг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах үүргийг Засгийн газарт өгөхөөр саналыг ажлын хэсгээс гаргасан байна. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг бүх Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 9, 10-ны өдрүүдийн хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр хуулийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан ажлын хэсэг бусад Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тус тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Засгийн газрын үнэт цаас гарах эрх олгох тухай, Засгийн газарт чиглэл өгөх тухай Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Дэлэгийн Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Ядамын Самбууням Монгол Улсын ерөнхий аудиторовын орлогч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний Аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мичиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга,

Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүү бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа.

Дамдины Цогтбаатар гишүүн асуулт асууна. Алга байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууна, мөн алга байна. Загджавын Мэндсайхан гишүүн асуултаа асууя.

3.Мэндсайхан: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. 2025 оны төсвийн төслөө бид нар хэлэлцэж байна. Тэгэхээр би нэг зүйлийг бас сануулах ёстой юм байна даа. Бид энэ талаар ер нь ярихгүй бол болохгүй нь ээ гэж үзэж байгаа юм. Засгийн газар маань нэлээн зардлаа өсгөсөн байна, орлогоосоо давсан төлөвлөлт хийжээ гэж бид нар Ерөнхийлөгчид тавьсан хоригийг хүлээж авсан. Тавхан сарын өмнө Монгол Улсын Засгийн газрын гишүүд энэ танхимд тангаргаа өргөсөн. Өргөхдөө энэ салбарыг би Их Хурал Засгийн газрын өмнө хариуцна, Ерөнхий сайдынхаа өмнө хариуцна гэдэг тангараг өргөсөн. Тэгээд энэ сайд нар өнөөдөр ажлаа хийж чадахаа байсан юм байна гэдэг ойлголтыг би аваад байгаа юм. Засгийн газар бүтэц, бүрэлдэхүүн зардлыг хэт их тэлж байна гэдэг нь агентлаг байгуулаад яваад байгаа асуудал огт биш байна аа. Энэ салбар хоорондын үе үйл ажиллагааг зохицуулах Үндэсний хороо гэдэг нэг ийм байгууллагыг бий болгоод ажлын албыг нь тэнд бий болгочихсон. Энэ намаржингаа Доржханд гэдэг хүн эрчим хүчний реформ гэдэг асуудлыг ярилаа.

Хийсэн ажил нь цахилгаан дулааны үнэ нэмсэн. Энэ ажлыг хийдэг хүн энэ салбар дотор байгаа л даа. Эрчим хүчний зохицуулах хороо гээд. Өнөөдрийг хүртэлх хугацаанд эрчим хүчний салбарын үнэ тариф яагаад хөдлөхгүй байсан гэхээр эрчим хүчний зохицуулах хороо буюу энэ үнэ тарифт өөрчлөлт хийдэг тооцоолол хийдэг байгууллага маань үе үеийн Ерөнхий сайдын шууд мэдэлд байгаад ирсэн юм. Тэгээд энэ асуудлыг сая ингээд реформ гээд ярингуут Зохицуулах хороо л хийчихнэ лээ л дээ. Эрчим хүчний салбар алдагдалгүй байхад зүйтэй. Энэ үндэсний хороо гэж яг юу хийгээд байна гэдэг асуудал байгаа юм. Нэг л их олон сар шинэчлэл хийх гэж байна. Урт хугацаандаа үр дүн гарна. Одоохондоо жоохон өвдөөдөх өө гээд л байсан. Энэ салбарын сайд жишээ нь Чойжилсүрэн сайд ажлаа хийж чадахгүй Доржханд хийгээд байгаа юм байна гэж би ойлгож байгаа. Тэгээд яагаад ийм байна гэхээр өчигдөр Байнгын хорооны хуралдаан дээр надад хариулж байна лээ л дээ. Эрчим хүчний салбарт энэ ажлыг хийчих хүмүүс байхгүй учраас би ийм бүтэц гаргаад явж байгаа юм гэж. Ингэж тэр мэргэжлийн инженер техникийн салбар ажилчдаас бүрдсэн салбарыг хэн нэгэн сайд доромжилж болохгүй ээ. Энд 20 хэдэн мянган инженер техникийн ажилчид байгаа. Тэнд энэ ажлыг хийх чадвар бүхий бүтцүүд нь байж байгаа. Эрчим хүчний хөгжлийн төв гэж 100 гаруй хүнтэй бүтэц байж байгаа эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн гэж мэргэжлийн эрдэмтэд инженерүүдээс бүрдсэн хүрээлэн байж байгаа. Эрчим хүчний салбар бодлогогүй байна, төлөвлөлтгүй байна гэдэг юм яриад байгаа юм. Энэ

асуудлыг аль хэдийн эрчим хүчний дунд хугацааны хөтөлбөр гээд батлаад тэр Доржхандын яриад байгаа асуудлууд чинь бүгд суучихсан байгаа.

Энэ дунд хугацааны хөтөлбөрийг ч сөхөж хараагүй байж байж энэ салбарыг төлөөлөөд энэ салбарын мэргэжлийн инженер техникийн ажилчдыг үгүйсгээд ингээд яваад байдаг энэ бүтцүүдийг больё. Засгийн газар энэ үндэсний хороо гэдэг асуудлуудыг эргэж хараач ээ гэж. Нийтдээ 14 үндэсний хороо ажлын хэсэгтэй байна.

Хуулиар тусгачихсан Үндэсний хорооноос бусад тэр үндэсний хороогоо яагаад татаж буулгахгүй байна. Ийм зардлын тэлэлт явуулдгаа болио. Тэгээд шаардлагатай газраа боловсон хүчнийхээ тоог нэмж чадахгүй ийм хийдлийг гаргаад салбар дундын уялдаа холбоог хангана гээд яваад байгаа юм. Тэгээд одоо тэр уялдаа холбоогоо хангадаг үндэсний хорооныхоо ажлын хэсгийг уялдаа холбоог хангадаг ажлын хэсэг байгуулах л дутуу байх шиг байна. Засгийн газар Энэ данхайсан бүтцээ эргэж хараач гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Мэндсайхан гишүүн хэллээ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууна алга байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Би нэг асуулт байна, нэг санал байгаа. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль өргөн барьсан. Тэр хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно. Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийлгэх хуулийн этгээдийн сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно гэсэн. Энийгээ бид нар Үндэсний аудиттай ерөнхийдөө хольж хутгаад байна аа. Нэг талдаа үндэсний аудит гэдэг бол энэ дотоодын одоо этгээд байгаа. Ерөнхийдөө ямар салбар дээр ямар сэдвийн хүрээнд тухайн жилдээ аудит хийх гэдгээ тогтдог. Энийгээ өөрөө хийх үү эсвэл бусад Үндэсний аудитын газарт бүртгэлтэй байгаа буюу жагсаалтад орсон компаниудаар хийлгэх үү үгүй юу гэдгийг шийдэж байгаа байхгүй юу. Гэтэл энэ төрийн өмчийн реформыг хийхийн тулд олон улсын аудит хийлгэх буюу Засгийн газар энэ ТӨК-удын хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлж байгаагийн хувьд бас давхар хийлгэж болох ёстой юм аа. Энийг ингэж хольж хутгаад цаашдаа энэ ТӨК-удын реформыг хийхгүй гэж байгаа юм шиг ийм зүйл ярьж болохгүй ээ. Энэ үндэсний аудитаас хийж байгаа аудит олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн аудитаар хийлгэх гэж байгаа 2 чинь шал өөр юм шүү. Сая ажлын хэсэг энийг давхцаж байна гээд хасагдаад байгаа байхгүй юу. Энэ Үндэсний аудитын байгууллагаас тухайн жилд Төсвийн байнгын хорооноос баталж өгсөн сэдэв жагсаалтад орсон тэр аудитын байгууллагаар хийлгэж байгаагаас өөр. Ийм горимоор явдаг зарим салбарууд байгаа. Жишээ нь манай банкны салбар байгаа. Банкн дээр угаасаа одоо тухайн салбарт банк бол жилд аудитын байгууллагаас хийх сэдэв болон жагсаалтад орсон эсэхээс хамаарч заавал олон улсын нэр хүндтэй байгууллагаар аудит хийлгэж явах ёстой. Хувьцаат компаниуд яг энийг хийх ёстой. Тэгэхээр бид хэд энэ үндэсний аудитын байгууллагаас хийх гэж байгаа аудиттайгаа хольж хутгаж энэ зүйлийг хасах гэж байгааг ерөөсөө би дэмжихгүй байгаа юм аа. Ажлын хэсэг энийгээ яг бодсон юм уу? Тэгэхээр энэ дээр бас анхаараач ээ гэж хүсэж байгаа юм.

Би 2 дугаарт бас Мэндсайхан гишүүнд баярлалаа. Сая Төсвийн байнгын хороон дээр энэ хуулиар чиг үүрэг нь байхгүй энэ Үндэсний хороо, комисс, төв

нэртэй энэ байгууллагуудыг татан буулгая гэдэг саналыг ороод холбогдох чиг үүргийг нь яамдууд шилжүүлье гэсэн саналыг унагаасан. Дэмжихгүй байна. Хэмнэе гэгчхээд ийм зүйлээсээ хэмнэж чадахгүй учраас бид нар үнэндээ хэлэхэд одоо яг олон нийтэд юу гэж мэдээлэл өгөхөө мэдэхгүй байна. Төрийн байгууллагууд хуульд заасан чиг үүргийг л хэрэгжүүлэх ёстой шүү. Гэтэл хуульд заасан бодлого боловсруулах эрхүүд нь, чиг үүрэг нь, үүрэг нь яамдуудад байж байхад зэрэгцүүлээд бодлого боловсруулна гээд ингээд явж байна. Тэр байгууллагууд ямар хуулиар хүлээсэн үүргүүдийг байгуулах гэж байгаа юм бэ. Харин салбарын уялдаа холбоог хангая гэвэл Ерөнхий сайдын захирамжаар ч гэдэг юм уу нэг удаагийн ажлын хэсгээ гаргаад шийдэж болно.

Асуудлуудыг шийдэх зөндөө арга механизм байж байхад ерөөсөө энэ төрийн босго давдаггүй хүмүүсийн цуглуулга боллоо. 2 дугаарт энэ Төрийн албаны хуулийг бас эргэж харах шаардлага эндээс харагдаж байгаа юм. Ер нь зүгээр НҮБ түүний төрөлжсөн байгууллага ч юм уу байнгын орон тоон дээр ирж ажиллаж байгаа залуучуудыг төрийн албанд урьж ажиллуулдаг энэ механизмыг нээгээд өгчих л дөө. Тэр өндөр ур чадвартай залуучуудыг. Энийг ерөнхийдөө бас өмнөх парламент дээр оруулж ирээд унагааж байсан байхгүй юу. Яг энэний гороор энэ хүмүүс энэ төрд бас шингэх ажиллах бололцоо байхгүй учраас төрийн албаны босгоос зайлуулаад дахиад ийм Үндэсний хороо, комисс, зөвлөл, төв нэртэй ийм зүйлүүдийг байгуулж байна аа. Ингээд төр өөрөө данхайдаг, үргүй зардал гаргадаг, сүүлдээ бодлого боловсруулах институц энийг хэн Засгийн газрын өмнө хариуцах Засгийн газар Улсын Их Хурлын өмнө ажлаа хариуцахад ингээд уялдаагүй болж эхэлж байна.

Өнөөдөр орон сууцын бодлогыг хэн хийж байгаа юм бүү мэд. 3, 4 сайд зэрэгцээд хийж байна. Хурдасгуур төв нь хийж байгаа юм билээ. Эрчим хүчний реформыг хийж байна. Яам нь байна. Доржханд гишүүн өөрөө бас хийж байгаа гэж байгаа. Тэгснээ дахиад зөвлөл гарч ирнэ.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Аудит. ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал хариулт өгье.

Н.Учрал: Энэ Төрийн өмчийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийг дагалдуулаад нээлттэй ил тод байдлыг хангах чиглэлээр төрийн өмчийн компаниуд ямар мэдээллээ ил болгох вэ? Ил болгосны үндсэн дээр олон улсын аудитыг оруулаад нэгтгэх үү, нийлүүлэх үү татан буулгах уу? 3 жил санхүүгийн алдагдалтай ажилласан бол татан буулгах уу гэдэг асуудлыг шийдвэрлэхээр оруулж ирсэн. Тэгэхээр Үндэсний аудитын байгууллага буюу энэ парламентат үйл ажиллагаагаа бас тайлагнаж байгаа энэ санхүүгийн аудит хийж байгаа тогтолцоо бол энэ олон улсын аудитаас өөр агуулга. Манай уул уурхайн ТӨК-уд 2 л компани өнгөрсөн хугацаанд хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын аудитыг оруулсан юм байна лээ. Бусад компани огт хийлгээгүй. Тэгчхээд Их Хурлын тогтоолоор IPO гарга хөрөнгө босго гэж тогтоол гаргаад байдаг. Олон улсын аудит оруулаагүй нөхцөл байдлыг нь тодорхойлоогүй компани олон улсад листэд болох тийм бололцоо байхгүй шүү дээ бирж дээр.

Тэгэхээр олон улсын аудит оруулахын ач холбогдол бол бодитой нөхцөл байдлаа тодорхойлоод олон улсын аудитын байгууллага бол ямар зөвлөмж өгч байгаа вэ гэхээр тухайн компанийг татан буулгах уу, өөрчлөх үү өөрөөр зохион байгуулах уу эсвэл хөрөнгө мөнгө босгох шаардлагатай юу үгүй юу гэдэг дээр хөндлөнгийн аудит хийдэг. Тэгэхээр алдагдалтай ажиллаж байгаа компаниуд

өнөөдөр олон улсын аудит хийлгэх зардал чирэгдэл нь ч хүртэл байдаггүй. Тэгээд л ингээд л нэг өдөр өдөр аргацаагаад л яваад байна гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр төрийн өмчийн нийт компаниуд чинь охин компанитайгаа нийлээд 122 хүрчээд байна. Үүнээс чинь 22 нь алдагдалтай ажиллаад байна аа. Тэгэхээр бид цаашдаа олон улсын аудит оруулж ирж нөхцөл байдлыг нь бодитоор үнэлэх хэрэгтэй байна шүү дээ. Тэгэхээр олон улсын аудит оруулъя гэхээр л ингээд л тал бүрд сандарчихдаг. Тэгээд янз бүрийн мэдээ мэдээлэл гаргаад л ингээд л олон улсын аудитаас зайлсхийдэг ийм болчхоод байна шүү дээ. Олон улсын аудит оруулж байгаагийн шалтгаан бол тэр олон улсын аудит чинь янз бүрийн ах дүү, амраг садан, найз нөхөд байхгүй ээ. Танил тал байхгүй ээ. Бодитоор нь үнэл. Тэгсэн цагт бид нар энэ төрийн өмчийн компанийг ашигтай ажиллуулах шаардлагатай татан буулгах асуудлуудыг ярихаас биш ингээд дотооддоо болж байна гээд ингээд суугаад байх цаашдаа бололцоогүй болж байна шүү дээ.

Тэгэхээр энэ төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн компанийн хууль батлагдсаны дараа бол төрийн өмчийн компаниудын бүх мэдээлэл ил болно. Дараа нь 3 жилд санхүүгийн алдагдлаа бууруулаагүй байх юм бол татан буулгах өөрчлөн зохион байгуулах арга хэмжээг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа утгаараа Засгийн газар авч хэрэгжүүлнэ. Үүнийг хийхийн тулд баримжаагаар биш асуудалд бодитойгоор хандахын тулд олон улсын аудит оруулъя л гэсэн. Тэгэхээр энэ олон улсын аудит оруулах энэ заалтыг авч хаях гээд байгаагийн цаад шалтгааныг бол бас төдийлөн ойлгохгүй байна аа.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Хариулт өгөх маань харин Учрал сайд мөн байсан уу? Би ер нь Учрал сайдын бодлогыг дэмжээд байгаа байхгүй юу. Энэ төрийн өмчийн реформ засаглалыг нээлттэй болгох публик компани болгож IPO гаргах энэ алдаа оноогоо засах асуудал чинь Үндэсний аудитын байгууллага түүний сэдэв болон тухайн жилд хийж байгаа аудитаас өөр юм. Энэ ингээд зүйлүүдийг ороод ирье. Яг энэ төрийн өмчийн компанийн реформ явах юм байна гээд бас энэ зөв зүйл байна гэнгүүт нь ажлын хэсгээс хасах гээд байгааг би ерөөсөө ойлгохгүй байгаа юм аа. Ямар үндэслэлээр хасаж байгаа юм. Энэ төрийн өмчийн реформуудыг явуулахгүй ээ гэж байгаа юм уу, энэ ямар үндэслэлээр хасав гэдэг зүйлийг л би ажлын хэсгээс тодруулаад байгаа юм. Учрал сайдтай бол санал нэг байна дэмжээд байгаа байхгүй юу би. Яагаад асуув гэдгийг л ажлын хэсгээс асуугаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн. Тэмүүлэн гишүүн хариулах уу? Ажлын хэсгийн дарга Тэмүүлэн гишүүн хариулт өгье.

Г.Тэмүүлэн: Их Хурлын гишүүд та бүхэндээ бас энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Тэгээд ажлын хэсгийн зүгээс өнгөрсөн 5 дахь өдөр шинэ өргөн баригдсан төсвийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэхийг нь шийдсэний дараагаар ингээд өнгөрсөн 4 хоногийн хугацаанд бас нэлээн өндөр ачаалалтай ажиллалаа. Тэгээд тэр дотроо одоо энэ төсөв дагасан хууль тогтоомжууд болоод тогтоолуудын талаар бас тодорхой ажиллаж ерөнхий энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуультай нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудлуудаар тодорхой бас өөрсдийнхөө байр суурийг нэгтгэсэн байгаад байгаа. Энэ дотор нэг талдаа энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль дээр тусгагдсан энэ 12 дугаар заалт 12 дугаар зүйл байгаад байгаа. Энд 2 агуулгыг бол нэгтгэж оруулсан байна гэдэг

асуудлыг харсан байгаад байгаа юм. Нэгд бол жишээ нь юу гэдэг юм тэр төрийн өмчийн компани ОУБ-аар аудит хийх эрхийг нь нээж өгч байгаа юм. Гэтэл нөгөө талдаа.

Д.Амарбаясгалан: Тэмүүлэн гишүүн гүйцээж хариулах уу? Нэмж минут өгье.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр энд бид нар бас 2 өөр агуулга, аудит хийх эрхийг нээж өгч байна. Нөгөө талдаа аудит хийлгэх тэр төрийн өмчийн компаниудынх нь жагсаалт болоод энэ ямар компани аудит хийх, хэн тэрийг нь сонгон шалгаруулах ингээд ямар жагсаалтаар юу гэдэг юм тогтоох ч гэдэг юм уу энэ асуудалд бол тухайлж энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль дээр оруулах шаардлагагүй ээ. Угаасаа хууль дээр байгаа зохицуулалт гэж харж байгаа.

Нөгөө талдаа энэ төрийн өмчийн компани байна уу, хувийн өмчийн компани байна уу бүгд л угаасаа ТУЗ-тэй. ТУЗ-ийнхөө хүрээнд ямар компаниар хийлгүүлэх тодорхой юу гэдэг юм хэзээ хийлгүүлэх энэ асуудлуудаа өөрсдийнхөө бүрэн эрхийнхээ хүрээнд ингээд шийдээд явах бол зохицуулалттай асуудлууд байгаад байгаа юм.

Тэгэхээр мэдээж аудит хийлгэх ёстой. Энийг компанийнх нь засаглалыг нь сайжруулж хийх болохоос биш дээрээс нь илүү их оролцож илүү нэг юу гэдэг юм нөлөөлөх гэдэг зарчмын хувьд бас өрөөсгөл асуудал байна л гэж бас үзсэн байгаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууна.

П.Сайнзориг: Уг нь сая Учрал сайд маш том ач холбогдлыг нь хэлээд байгаа юм аа. Энийг зүгээр ойлгоогүй бол би зүгээр ганцхан л юм хэлж байгаа юм. Энэ унагасан саналаа босгочооч ээ. Энэ явж байх ёстой байхгүй юу. Засгийн газар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байж энэ аль компани дээр олон улсын аудит хийлгэх хэлэхгүйгээ шийдэхгүй тийм сонин юм гэж юу байдаг юм бэ? Яг энэ хууль дээр бол тодорхой биш байгаа шүү Тэмүүлэн дарга аа. Та бол зүгээр сая ам дагуулаад хэлчихлээ. Тэгээд ийм юу гэдэг юм засаглалыг сайжруулах юм орж ирж байхад энэний эсрэг төрийн өмчийн компанийн реформыг хийлгэхгүй гэсэн сэдлээр явж байна энийгээ больчхооч ээ. Энэ унагаасан санал дээрээ битгий кнопнд хүрээч ээ дэмжээд явчхаач ээ л гэж хүсэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд нэмж гүйцээж хариулъя.

Төрийн өмчийн компаниуд дээр Засгийн газар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлдэг. Хувьцаа эзэмшигчийн хувиар алдагдалтай ажиллаад байгаа асуудалтай байгаа компаниуд дээр нь олон улсын аудит оруулъя гээд хувьцаа эзэмшихийг шийдэхгүй өөр хэн шийдэх юм. Гэтэл алдагдалтай ажиллаж байгаа компаниуд өөрийнхөө ТУЗ-өөр намайг олон улсын аудитаар шалгаад өгөөч ээ гэж шийдвэр гаргах юм уу. Тэгээд мөнгө гаргаад олон улсын аудит өөр дээрээ оруулах юм уу. Тэгээд бид муу байгаа юм гээд олон нийтэд зарлах юм уу. Энэ чинь логикийн алдаатай байгаа биз дээ. Тэгэхээр Засгийн газар шийдээд хувьцаа эзэмшигчийн хувиар өмч хөрөнгөдөө эзэн болоод энэ компани асуудалтай байна шалгаад өг гээд зөвшөөрөгдсөн олон улсын аудит оруулахад хэн энэ дээр тэвдэж сандраад байгаа юм гэдэг чинь эргэлзээ.

Тийм учраас нэг дэх өдөр бол энэ хууль батлагдчихвал төрийн өмчийн компаниудын цалин хөлс, урамшуулал, тендер, худалдан авалт бүгдийг нь ил болгоноо. Энэ дээр хүний өөрийн хэн ард нь урд нь байдаг нь энд бол хайр байхгүй. Тэгэхээр та бүхэн дэмжих хэрэгтэй.

Д.Амарбаясгалан: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

Ж.Чинбүрэн: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Их Хурлын дарга аа энэ төсөвтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн юун дээр би анхны хэлэлцүүлэг дээр хариултаа авчихсан учраас асуух зүйлгүй боллоо.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Да.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе ээ. Бид нар бол одоо ингээд халамжийн улс болчихоод байгаа. Тэгээд баялаг бүтээдэг хэсгээ дэмжих юу ч байхгүй байна уу? гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Улс өнөөдрийн байдлаар халамжийн улс болчихсон гэж хэлэхэд болохоор болчихоод байгаа юм. Баялаг бүтээдэг хэсгээ дэмжиж байгаа тийм бодлого гэх юм уу байхгүй болчихоод байгаа юм. Халамж тэтгэмж олгоод бүх иргэдээ энэ залхуу дэглэм рүү оруулаад энийг л өөрчлөх шаардлагатай байна гэж харах гээд байгаа ш дээ. Энэ жишээг нь хэлье. 142 тэрбум төгрөг ажилгүйдлийн тэтгэмж гээд явж байгаа юм. Энийг дотор нь хувийн хэвшлээс ажлаас халагдаад ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа хүмүүс нь хэд, төрийн албан байгууллагыг удирдаж байгаа этгээдүүдийн буруутай шийдвэр гаргаад хэд нь энэ 142 тэрбумын ажилгүйдлийн тэтгэмжийг олгогдож байгаа вэ гэдгийг судалж үзсэн ийм судалгаа байх болов уу Энх-Амгалан сайд.

Тэгээд дээрээс нь дахиад нэг ийм зарчмын асуудал гэх юм бол Цалинтай ээж хөтөлбөр гээд нэг хөтөлбөр байгаа юм. Цалин гэж ярих юм бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ энэ чинь 660 мянга. Тэтгэмж гэж ярих юм бол энэ чинь цалинтай ээж гэдэг нэртэй. Тэгэхээр энэнийхээ тэтгэмж юм уу, цалин юм уу гэдгийг нь тодорхой болгож өгөхгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 660 мянга тэтгэмж нь 50 мянга. Ингээд зөрүүтэй асуудал яваад байгаа юм. Энийг тодруулж өгөөч ээ гэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Хэн хариулах вэ? Сангийн сайд Жавхлан сайд хаана байна? Саяын Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгнө. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Энх-Амгалан сайд хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя аа.

Тэгэхээр бид нар 4 том даатгал албан журмын даатгал байгаа. Энэ даатгалын нэг нь бол энэ ажилгүйдлийн даатгал. Тэгэхдээ бусад даатгалуудыг бодох юм бол хамгийн их энэ ажлаас халагдсан хүмүүсийнхээ эрсдэлд орсон санхүүгийн эрсдэлд орсон хүмүүсийнхээ эрсдэлийг хаадаг даатгал бол энэ ажилгүйдлийн даатгал юм байна лээ. Ажилгүйдлийн даатгал гэхдээ ямар ч байсан авч байгаа хураамжийнхаа шимтгэлийнхээ хүрээнээс илүү их тийм даатгалын эрсдэлүүд их гардаг. Ер нь яг өнгөрсөн хугацаанд ингээд тантай би санал нэг байна. Өнгөрсөн хугацаанд ингээд энэ ажилгүйдлийн даатгалаас авч байгаа даатгал яг ямар цаг үед илүү их энэ даатгалын зардлуудыг их гараад байна вэ гэхээр сонгуулийн дараа л гараад байдаг нэг ийм хандлагууд байгаа юм байна лээ.

Цогтбаатар гишүүн. Би энэ дээр тооцоо судалгаанууд бас хийгдэж байна. Тэгээд өнгөрсөн 3 сонгуулийн дараа шинэ Засгийн газар байгуулагдахад бас төрийн албанаас үндэслэлгүйгээр халагдаж даатгалын сангаас даатгал авч байгаа нэг ийм ерөнхий нэг чиг хандлагууд бас байгаад байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ дээр бас нэлээн бодлогын болон тогтолцооны шинэчлэл хийх ийм зайлшгүй шаардлага бас үүссэн байна гэж харж байна.

Тийм учраас одоо бид нар удахгүй энэ тэтгэврийн шинэчлэлтэй уялдуулж энэ үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын асуудлууд тэтгэмжийн даатгал, ингээд энэ ажилгүйдлийн даатгалынхаа тогтолцоог бид нар бас нэлээн тогтолцооны шинэчлэл хийхээр бас ажиллаж байгаа гэдгийг бас би хэлье гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн тодруулж асууя.

Да.Цогтбаатар: Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хөдөлмөрийн тухай хууль дээр чинь буруутай этгээдээр тэр ажилгүйдлийн тэтгэмж буцааж олгогдож байгаа тохиолдолд буруутай этгээдээр төлүүлэх гээд хуулийн заалт нь байгаад байгаа юм. Тэгээд энэ 142 тэрбумд одоо энэ жишээлэхэд 2025 онд тавьж өгч байгаа санал нь өмнөх энийг 24 гэдэг юм уу, 23 гэдэг юм уу магадгүй сая Энх-Амгалан сайдын ярьсан сонгуулийн жилийн мөчлөгтэй уялдуулаад шалгаад үзэх юм бол бид нар зүгээр л өргүй зардал гаргаад хэн нэгэн буруутай даргын гаргасан шийдвэрийн хүрээнд улсын төсвөөс зардал гаргаад яваад байгаа. Энийг буцааж олж авах ажил хийх шаардлагатай байгаа учраас л энийг тодруулаад байгаа юм.

Тэгэхээр энийг эргээд эсвэл энэ Засгийн газарт тогтоолоор чиглэл өгөөд эсвэл Энх-Амгалан сайд буцаагаад Улсын Их Хуралд нэг тайлагнах боломж байх уу?

Д.Амарбаясгалан: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд гүйцээж хариулъя.

Л.Энх-Амгалан: Яах вэ бид нар энэ нийгмийн даатгалын даатгалуудынхаа сангийн тайланг чинь бид нар яг өөрийнхөө Нийгмийн бодлогын байнгын хороон дээр жилд 2-оос доошгүй удаа тайлан тавьдаг юм шүү дээ Цогтбаатар гишүүн ээ. Тийм учраас дараагийн удаа манай Энхнасан дарга маань сууж байна. Тэгээд бид нар Нийгмийн бодлогын байнгын хороон дээр энэ даатгалын сангууд болон дагасан даатгалын сангуудын тайлан дээр та бас орж ирж энэ мэдээллүүдийг сонсож болно.

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан сайд гүйцээж хариулах уу? Нэмэлт минут өгье.

Л.Энх-Амгалан: Би таны хэлж байгаа саналтай санал нэг байна аа. Энэ одоо яг төрийн албан хаагчдын тэр тусмаа удирдах албан хаагчдын удирдах албан тушаалд байгаа хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас үүсэж даатгалын сан дээр ирж байгаа эрсдэлүүд мөн хөдөлмөрийн хууль зөрчигдөж эрх ашиг нь зөрчигдөж байгаа хүмүүс дээр тодорхой энэ хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах ёстой гэдэг дээр би санал нэг байна. Тэгээд энэ чиглэл рүү бид нар манай яамны Хяналт шинжилгээ мониторингийн газар гэж байгаа. Тэгээд энэ чиглэл рүү бас тодорхой хяналт шалгалтуудыг хийж ингээд танд бас тодорхой хариултуудыг өгье.

Д.Амарбаясгалан: Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй нийт 40 санал байгаа.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж түүнийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно гэж Дэгийн тухай хуулиар зохицуулсан байгаа.

Тэгэхээр зарчмын зөрүүтэй санал тус бүр дээр асуудлыг ярих боломжтой. Ингээд зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд танилцуулъя. Санал хураалт явагдах гэж байгаа гишүүдэд мэдээлэл өгсөн байгаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор Төсвийн байнгын хороо төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана.

Гаргасан саналтай холбогдуулж гишүүд үг хэлж болно. Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгож зарласан. Үүнтэй холбоотойгоор бас 2025 оны төсөв дээр бас бүсчилсэн хөгжлийг дэмжих энэ бас татварын бодлого орж ирж байгаа. Ялангуяа Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах орон нутагт бас үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр. Өөрөөр хэлэх юм бол одоо энэ боловсруулах үйлдвэрүүдийг орон нутагт байгуулсан тохиолдолд татвараас хөнгөлөх чөлөөлөх асуудал. Гэхдээ энэ дээр бас манай Их Хурлын гишүүд урьд нь бас өргөн барьж Улсын Их Хурлаар батлуулсан бас асуудлууд байдаг. Зарим нь батлагдсан, зарим нь батлагдаагүй. Тухайлах юм бол 2017 онд бид нар бас Хүн амын орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулаад санаачлаад Их Хурлын төсөв яг яригдаж байх үед. Улаанбаатараас 500-аас дээш алслагдсан аймгуудад ААНОАТ-ыг 5 хувь болгосон, 2 дахин бууруулсан, Улаанбаатарынхнаас. Мянгаас дээш алслагдсан аймгуудад нэг хувь болгож Улаанбаатараас 10 дахин бууруулсан. Ийм байдлаар үндсэндээ алслагдсан бүс нутаг. Ер нь Улаанбаатараас алслагдах тусмаа бараа бүтээгдэхүүний үнэ өсөж байдаг. Бензин шатахуун өндөр үнэтэй, тог цахилгаан өндөр үнэтэй. Гурил, будаа, өндөр үнэтэй даавуу, даалин бүр өндөр үнэтэй болдог. Нөгөө талдаа нөгөө малын гаралтай түүхий эд арьс шир, ноос ноолуур, мах, төмс, хүнсний ногоо нь хямдхан орлого багатай зардал өндөртэй байдаг.

Тэгэхээр Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах 1 дүгээрт.

Хоёрдугаарт нь тэр өндөр үнэтэй, өндөр зарлагатай, бага орлоготой амьдарч байгаа иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах бодлогын хүрээнд бид нар энэ татварын зохицуулалт хэрэгтэй байгаад байгаа юм аа. Тийм болохоор цаашдаа бас энэ хүн амын орлогын албан татварыг энэ бүсээс нь хамаараад алслагдах тусмаа бага байдаг. Энэ рүү шилжих ийм бас бодлогын алхмыг бас хиймээр байгаа юм. Энэ дээр 2024 онд миний хувьд бас хэд хэдэн гишүүдтэй нийлээд санаачилсан хууль байдаг. Хүн амын орлогын албан татварыг бас бүсчилж ээ. Улаанбаатараас 500-аас дээш алслагдсан 5 хувийн татвартай больё.

Мянгаас дээш алслагдсан бол нэг хувийн татвартай болгоё. Хүн амын орлогын албан татварыг. Ийм байдлаар ингэж бүсчилж бас татварыг тогтоох юм бол энэ Улаанбаатар хотын бас төвлөрөл саарах тэр алслагдсан бүс нутагт ажиллаж амьдарч байгаа ард иргэдийн орлого нэмэгдэх зардал буурах ийм давхар давхар нэг сумаар хэд хэдэн туулай буудсан ийм асуудал шийдэгдэх юм гэж хууль санаачилж өргөн барьсан байсан. Сая нөгөө шинэ Их Хурал байгуулагдаад үүнтэй холбоотой асуудал маань татагдчихсан байгаад байгаа.

Тэгээд Засгийн газрын гишүүний хувьд энэ хуулийг санаачлахад жоохон яг бланк дээрээ санаачлахад жоохон зохимжгүй байгаад байгаа. Манай Их Хурлын гишүүд бас хамтраад Их Хурлын гишүүдээс энэ хуулийг бас санаачлаад аваад яваач ээ. Би бас хамтраад оролцоод урьд нь санаачилсан хууль, холбогдох тооцоо, судалгаануудаа бас өгөөд явахад бэлэн байна. Ийм байдлаар бас Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг бас Улсын Их Хурлын бодлогын бичиг баримтыг бас хэрэгжүүлэхэд мөн бас Засгийн газрын бас бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгож зарласан энэ бас бодлогыг бас бодитой ажил болгоход мөн бид нар бас энэ Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах энэ утааны асуудал, түгжрэлийн асуудал, энэ нийгмийн бухимдал төрүүлж байгаа томоохон энэ тулгамдсан асуудлуудыг шийдэхэд орон нутагт ард иргэдээ аятай тухтай ажиллаж амьдрах энэ бас бололцоо боломжийг бүрдүүлэх энэ томоохон зорилтыг бас хэрэгжүүлэхэд энэ хууль нэлээн том дөхөм болно гэж үзэж байгаа. ААНОАТ-тай адилхан л үндсэндээ ингээд бүсчлээд бид нар алслагдах тусмаа илүү өндөр бага татвартай болох энийг шийдчих юмсан. Энэ дээр бас манай гишүүд бас нэг анхааралдаа аваач ээ тэгээд энийг бас бүгдээрээ хамтраад ирэх 2025 онд бас энэ хуулийг бас батлуулахын төлөө бас хамтарч ажиллая аа. Энэ бас бодитой алхам болох юм шүү л гэдгийг бас энд хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Бямбацогт гишүүн үг хэллээ.

Санал хураалт санал хураалт явуулъя.

71 гишүүн буюу 65.1 хувиар санал дэмжигдлээ. Дэмжсэнээр гишүүд микрофонд үг хэлэх ёстой байгаа. Жудгийн Баярмаа гишүүн гишүүний микрофоныг өгье.

Ж.Баярмаа: Төхөөрөмж гацсан тул дэмжсэнээр авч өгнө үү?

Д.Амарбаясгалан: Хурууныхаа хээг уншуулсан юм уу Баярмаа гишүүн. Тэгээд анхаарлаа төвлөрүүлж байгаад цөөхөн хэдэн санал хураалтдаа идэвхтэй оролцъё Баярмаа гишүүн дээр нэмэх нь Бейсен гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Далайн Батбаяр гишүүн, Замира гишүүн Ж.Бат-Эрдэнэ гишүүн, Б.Бат-Эрдэнэ гишүүн Жуковын Алдаржавхлан гишүүн, Зулпхар гишүүн, Үүрийнтуяа гишүүн С.Эрдэнэбат гишүүн нар дэмжсэнээр протокол тэмдэглүүлье гэж байна. Мөнхнасан гишүүн протоколд тэмдэглүүлэх юм байна дэмжсэнээр. Гишүүд анхааралтай байж төхөөрөмжтэйгөө харьцаж саналаа зөв өгөх ёстой шүү. Лодойсамбуу гишүүн бас олон нийтэд хандаж энэ төхөөрөмжтэйгөө харьцах тал дээр зөвлөгөө өгсөн байна лээ. Та бүхэн маань уншсан байх гэж бодож байна.

Одоо тэгээд анхаарлаа төвлөрүүлээд төхөөрөмжтэйгөө зөв харьцахад төхөөрөмж гацсан гэдэг ойлголт байхгүй ээ гэдгийг бас та бүхэн маань өөрсдөө хүлээн зөвшөөрөх ёстой шүү гэдгийг бас хэлье ээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 22.14 дэх хэсгийн “үйл ажиллагааны орлогод үзүүлэх бусад” гэснийг “үйл ажиллагааны орлогын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн дэмжиж, 81.1 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтад доор дурдсан агуулгатай 22.15 дахь хэсэг нэмэх.

“22.15.Энэ хуулийн 22.5.22-т заасан импортыг орлох, экспортыг дэмжих салбар, үйл ажиллагаа, төслийн жагсаалтыг Улсын Их Хурал батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн дэмжиж, 80.4 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 27.11 дэх хэсгийн “холбогдох олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжид үндэслэн тооцож, зөвлөмжийн хамтаар” гэснийг “Монголбанкнаас зарласан тухайн татварын жилийн дунджаар тооцож дараагийн татварын жилийн 1 дүгээр сард багтаан” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн дэмжиж, 80.4 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

92 гишүүн дэмжиж, 82.1 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 38.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.4.Газар тариалангийн болон боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн иж бүрдэл, трактор, комбайныг импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлнө.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн дэмжиж, 79.6 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 38.7 дахь хэсэг нэмэх.

“38.7.Энэ хуулийн 38.4-т заасан татварын хөнгөлөлтөд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.1-д заасны дагуу баталсан Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, түүний тодорхойлолтыг баримтална.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

95 гишүүн дэмжиж, 84.1 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

97 гишүүн дэмжиж, 85.8 хувиар санал дэмжигдлээ.

Гурав.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн “Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно.” гэснийг хасах.

Энэ Ням-Осорын Учрал ЗГХЭГ-ын дарга үг хэлнэ.

Н.Учрал: Энэ 122 төрийн өмчийн компани Их Хурлын гишүүн болгон л саналаа хэлж байгаа. Өмч эзэнгүйдэж байна, алдагдалтай ажиллаж байна, хяналт алга байна. Гэтэл олон улсын аудит оруулаад нөхцөл байдлыг нь бодитоор үнэлүүлье ээ гэхээр энэ заалтыг хасъя гээд байгааг би ойлгохгүй байгаа юм. Хэзээ ч алдагдалтай ажиллаж байгаа компани өөрийгөө шалгуулъя, өөрийгөө аудит оруулъя гэж өөрөө хүсэлт гаргаад аудитад оруулахгүй ээ.

Тийм учраас өнгөрсөн хугацаанд 122 компаниас Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс Тавантолгой, Төрийн банк, Хөгжлийн банк гэсэн дөрөвхөн байгууллага одоо энэ Ки

Пи Эм Жи, Мүүр Аудит гээд нэг ийм олон улсад зөвшөөрөгдсөн аудитыг оруулж байсан түүхтэй юм байна лээ. Бусад бусад төрийн өмчийн компани хэзээ ч оруулж байгаагүй. Яагаад вэ гэвэл алдагдалтай ажиллаж байгаа учраас. Олон улсын аудит оруулаад нөхцөл байдлыг нь тодорхойлчихоос эмээдэг. Харин Засгийн газар юмандаа эзэн болох ёстой. Хувийн компаниуд ч гэсэн өмчдөө эзэн болохын тулд олон улсын аудит оруулж байгаад нөхцөл байдлыг нь тодорхойлж байгаад дараагийн арга хэмжээг авдаг. Тэгэхээр бид энэ эрхийг Засгийн газарт өгөөд ирэх жил алдагдалтай ажиллаж байгаа компаниудыг нь жагсаалтыг нь гаргаж байгаад энэ энэ компани дээр заавал олон улсын аудит оруул, энэ аудитын дүгнэлтэд үндэслээд нэгтгэх үү, татан буулгах уу, шаардлагатай компанийг нь листэд болгох уу гэдгийг баримжаагаар биш асуудалд шинжлэх ухаанчаар хандах ёстой л гэдэг ийм зорилттой. Сая ОЕСТ-ийн зөвлөмж дээр төрийн өмчийн Монголын энэ төрийн өмчийн компаниуд дээр 3 чиглэлээр ийм зөвлөгөө өгсөн байсан. Нэгд ТӨК-уд дотроо системийн ач холбогдолтой ТӨК-уд олон нийтийн өндөр сонирхол бүхий байгууллагууд, санхүүгийн эрсдэлтэй байгууллагууд байх юм бол заавал олон улсын аудит оруулаарай гэдэг ийм зөвлөмж өгсөн.

Гэтэл манай төрийн өмчийн компаниуд байна шүү дээ. Энэ 3 ангилалд гурвуулд нь багтана. Зарим нь санхүүгийн алдагдалтай ажиллаж байгаа. Зарим компани нь олон нийтийн сонирхол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа юм. Зарим компаниуд нь системийн ач холбогдолтой төрийн өмчит ААН-үүд давамгайлж байна. Гэтэл олон улсын аудит нөгөө нөлөөлж болдоггүй, нөгөө ах дүү, амраг садан, найз нөхөд байдаггүй. Нөгөө набор чихэр бариад найрч болдоггүй учраас олон улсын аудит оруулахаасаа тэвдэж сандраад өнөөдөр энэ заалт дээр олон улсын аудит оруулж болно гэдэг нэг ийм хэнд ч хэрэггүй заалтыг нь үлдээчхэж байгаа байхгүй юу. Гол амин сүнс болсон энэ заалтыг нь хасаж байна. Тэгэхээр Засгийн газрын өргөн барьсан хувилбараараа дэмжиж өгөхийг бас гишүүдээс хүсье ээ.

Тэгэхээр энэ дээр дарахгүй байж өгөөч ээ л гэж.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлнэ.

П.Сайнзориг: Ажлын хэсгийн энэ саналыг дэмжихгүй байж өгөөч ээ гэж би гишүүддээ бас уриалж байгаа юм. Засгийн газар Энэ ТӨК-удын хувьцаа эзэмшигч эрхийг хэрэгжүүлж байгаа. Харин энэ заалт тодорхой ороод ирэх юм бол бид нар Засгийн газраасаа шаардана аа. Тухайн жилийн Төсвийн байнгын хорооноос хийж байгаа Үндэсний аудитын газраас хийх тэр жагсаалт сэдэв арай тусдаа асуудал байхгүй юу. Энэ бол бас илүү их хяналтыг сайжруулах, эргээд энэ ашиг алдагдалтай ажиллаж байгаа компаниудыг татвар төлөгчдийн мөнгөөр эрсдэлийг үүрдэг энэ байдлыг зогсоох, илүү их ил тод хариуцлагатай болгоход чухал болно. Энэ заалтаар бол зөвхөн юу гэдэг юм, төрийн өмчийн бодлого, зохицуулалт нь ч юм уу эсвэл аль нэг яам нь энэ ажлыг хий гэдэг зүйлийг л жагсааж өгөх гэж байна шүү дээ. Түүнээс биш Засгийн газар өөрөө сонгон шалгаруулалт хийх гээд байгаа юм ерөөсөө алга байна.

Тийм учраас гишүүддээ битгий ингэ санал дээр кнопдоо битгий хүрээч ээ. Оруулж ирсэн төслөөр нь дэмжээд энэ төрийн өмчийн компаниудын реформыг хийлгэвэл хийлгээд зарим нэг компаниудыг энэ публик компани болгох энэ эхлэлийг тавихад энэ заалт чухал заалт болно. Тэгээд энэ дээр битгий хүрээрэй л гэж хүсмээр байна даа.

Д.Амарбаясгалан: Дэмжсэн болон дэмжээгүй тус бүр 2 гишүүн үг хэлэх боломжтой байгаа. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн үг хэлье.

Л.Мөнхбаясгалан: Энэ их чухал санал хураалт болох гэж байна. Тэгэхээр саяын үг хэлсэн Учрал гишүүн Сайнзориг гишүүн 2 үнэн яриад байгаа юм уу, худлаа яриад байгаа юм уу гэдэг ажлын хэсгийн тайлбарыг сонсох саналтай байна.

Д.Амарбаясгалан: Биш ээ энэ асуудлаа дэмжиж хэлж байгаа юм уу, дэмжихгүй хэлж байгаа юм уу гэж?

Л.Мөнхбаясгалан: Харин сонсож байж. Ажлын хэсгээс төлөөлж. Түвшин гишүүн байна уу? Санал гаргасан гишүүн. Баттөмөрийн Энхбаяр гишүүн ажлын хэсгийг төлөөлж.

Б.Энхбаяр: Ажлын хэсэг дээр ийм байгаа юм Засгийн газар нь ТӨК-удаа олон улсын аудит хийгээд цэгцлэх гээд л Улсын Их Хурлын ажлын хэсэг нь болохоор тэр нэг юмыг нь эсэргүүцээд л. Ийм байгаа одоо улс төрийг Төсвийн байнгын хорооны дараа манай Засгийн газар өөрөө хийгээд байгаад би харамсаж байна. Энэ бол одоо Засгийн газар бол төсөв дээр наад попорлоо татчихмаар байна шуудхан хэлэхэд. Яагаад гэхээр энэ заалт хуульд байсан байгаагүй, Засгийн газар төрийн өмчийн компаниудын хувьцаа эзэмшигчийн хувьд олон улсын ч бай, дотоодын ч аудит ч бай хяналт шалгалт ч бай угаасаа хийдэг. Хийсээр ирсэн. Энэ заалттай заалтгүй хийх үүрэгтэй байхгүй юу даа. Энэ заалт л орж байж л нэг юм хянадаг болох гээд байгаа юм гэдэг өөрөө хууль зүйн үндэслэл байхгүй.

Хоёрдугаарт, олон улсын аудит өөрөө заавал өндөр үнэлгээтэй. Саяын үндэсний аудитын хийж байгаа шиг бүүр төсвийн дотор руу орсон аудит хийгддэггүй. Хэрвээ олон улсын аудит хийх гэж байгаа бол энэ аль компанид ямар хэмжээний өртөгтэй, үнэтэй, хөрөнгөтэй эх үүсвэртэй аудит хийгдэх гэж байгаа гэдэг улсын төсөв дээр мөнгө нь тавигдах ёстой. Жишээлбэл Эрдэнэт үйлдвэрт хийх гэж байгаа юм аа бид. Энэ дээр аудит хийгдэхэд бид нарт 1 сая доллар хэрэгтэй байна гэж байгаа бол тэр 1 сая долларынхоо төсвөө төсвийн хуульдаа оруулж ирэхгүй яасан юм. Нэг ч төгрөг оруулж ирээгүй шүү дээ олон улсын аудит хийлгэе гэж. Тэгчхээд ийм лоозогнолын маягтай заалт оруулж ирээд энүүгээрээ бид одоо нэг тийм юм хийх гээд л Их Хурал нэг хийлгэхгүй байгаа юм шиг энэ улс төрөө больчихмоор байна аа.

Тийм учраас энэ гарзгүй заалт, гарзгүй заалт. Байсан ч ялгаагүй байхгүй байсан ч ялгаагүй ийм заалт. Надад бол ерөөсөө ямар ч пад алга энэ бол.

Д.Амарбаясгалан: Одоо бас гишүүдийн хэлж байгаа шаардлага үнэн шүү. Өнгөрсөн 4, 5 өдөр амралтын өдөр өдөр шөнөгүй бас энэ ажлын хэсэг хуралдсан. Ажлын хэсгийн гишүүд маш өндөр ачаалалтай ажилласан. Аливаа асуудлыг бас нэлээн гүнд нь орж судалсан. Ингээд мэргэжлийн Байнгын хороогоор орж санал нь ороод дэмжигдээд гараад ирчихсэн байгаа гэдгийг бас манай Засгийн газрын гишүүд төсөл өргөн барьсан талаас бас энэ дээр анхаарч хандах нь зүйтэй байх гэж бодож байна. Нэгэнт ажлын хэсэг байнгын хорооны түвшинд энэ асуудал ингээд дэмжигдээд явсан бол бас нэг зарим талаараа зарчмаа бариад явах нь зөв болов уу гэсэн ийм байр суурь бас байна аа. Ингээд санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

54 гишүүн буюу 47.4 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

73 гишүүн буюу, 64 хувиар санал дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

86 гишүүн буюу 75.4 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдсанд тооцлоо.

Тав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

81.6 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг буцаах тогтоол батлагдсанд тооцлоо.

Зургаа.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

2.Төслийн 4 дүгээр зүйлийн “батлагдсан өдрөөс” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

93 гишүүн буюу 81.6 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын тогтоолын төсийн талаар

Нэг. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

1. Төслийн тэмдэглэх хэсэгт Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7 дахь заалт нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

94 гишүүн буюу 82.5 хувиар санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дэх заалтын “, цаашид өөрчлөгдөхгүй байх” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

96 гишүүн буюу 84.2 хувиар санал дэмжигдлээ.

3. Төслийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3. Төсвийн ил тод, үр ашигтай байдал, санхүүгийн хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

86 гишүүн буюу 75.4 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлнэ ээ.

С.Бямбацогт: Энэ төсөв дагасан хуулиудын анхны хэлэлцүүлэг хийж байгаа. Тэгээд энэ Улсын Их Хурлын тогтоол дээр энэ орж байгаа заалтыг дэмжиж байгаа. Төсвийн ил тод, үр ашигтай байдал, санхүүгийн хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээ авч холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт оруулъя гэж. Сая бас ярьж байна. Үндэсний хороодоос бас зөв үү, буруу юу гээд ярьж байгаа. Түүнтэй адилхан бид нарт бас төслийн нэгжүүд гээд асуудлууд байгаад байгаа. Одоо өмнө нь Эгийн голын УЦС-ын төслийн нэгж гээд дөчөөд тэрбум төгрөг Хөгжлийн банкнаас зээл аваад санхүүжүүлчихсэн баахан цаас үйлдвэрлэчихсэн. Одоо тэгээд баахан үр ашиггүй төсөв зарцуулагдчихсан ийм байж л байдаг. Одоо Улаанбаатар хотод Эмээлтийн аж үйлдвэрийн парк гээд хориод жил үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгсэн мөртөө нэг барилга байшин нэг тийм хийсэн ажил байхгүй тэгсэн баахан 20, 30 хүн ажилладаг тэгээд юу ч хийдэггүй нэг тийм байгууллага байж л байдаг гэх мэтийн олон төслийн нэгж байгаа. Чөлөөт бүсийн захиргаа, Баян-Өлгийн чөлөөт бүс гээд Алтанбулагийн чөлөөт бүс Замын-Үүдийн чөлөөт бүс гээд

бас нэг юу ч хийдэггүй хэдэн байгууллага нэг иймэрхүү юмнуудаа бас нэг цэгцэлмээр байгаад байгаа юм аа.

Энийг бас нэг цаашдаа бас холбогдох хууль тогтоомждоо өөрчлөлт оруулахдаа ямархуу байдлаар шийдэх юм бас анхааралдаа аваадхаач ээ гэдгийг хэлэх гэж байгаа юм.

Дараад нь бид нар бас томоохон төслүүд ярьж байгаа. Энэ төслүүдийн бас үр өгөөжийн асуудал. Одоо урьдчилсан байдлаар ТЭЗҮ урьдчилсан ТЭЗҮ судалгаа хийж байж үр ашиггүй байх юм бол бид нар зогсоомоор байгаа юм. Тэгэхгүй бол 40, 50 тэрбумаар, хэдэн тэрбум хэдэн 100 тэрбумаар нь баахан ТЭЗҮ хийчихдэг. Тэр нь дараад нь яг бариад байгуулаад бүтээн байгуулаад явъя гэдэг. Тэгтэл тэр нь үр ашиггүй. Ийм байх юм бол тэр гаргасан зураг төсөв ТЭЗҮ чинь бас л хоосон цаас болоод л үлдэнэ.

Эс үгүй бол тэр төслийг эхлүүлээд явдаг, төсөл явж байгаад тэгээд сүүлд нь зогсдог, царцдаг. Тэгээд бас тэр нь цемент болоод балгас болоод үлддэг. Ийм болчих вий. Тийм болохоор энэ бас хийх гэж байгаа томоохон төслүүд дээрээ бас нэг урьдчилсан байдлаар бас нэг ТЭЗҮ хийгээд үр ашигтай байна уу эдийн засгийн хувьд. Үнэхээр ач холбогдолтой байна уу үгүй юу гэдгийг нь судлаад шаардлагатай бол бага дээр нь бага мөнгө зарцуулаад, шаардлагагүй юм байна гэсэн дүгнэлтээ гаргаж зогсох хэрэгтэй байгаад байгаа юм. Тэгэхээр 1 иймэрхүү зүйлүүдийг бас нэг ямархуу байдлаар оруулах юм.

Хоёр дахь хэлэлцүүлэг дээр Улсын Их Хурлыг дагаж гаргаж Засгийн газарт өгөх тогтоол дотроо бас энийг бас нэг оруулаад өгөөч ээ. Иймэрхүү бас нэг зүйлүүд дээр анхаарахгүй бол хэт их үрэлгэн, хэт их цамаан хэт их мөнгө зарцуулсан сүүлд нь дуусгаж чаддаггүй эхлүүлчихсэн баахан төсөлтэй болчих вий эс үгүй бол юу ч хийгддэггүй баахан цаастай болчих вий. Баахан мөнгө зарцуулчихсан. Энийг бас нэг анхааралдаа аваадхаач л гэдгийг хэлэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Санал хураалт.

3 дахь асуудал байгаа тийм ээ.

Санал хураалт.

93 гишүүн буюу 81.6 хувиар санал дэмжигдлээ.

1/"бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж" гэсэн тухайн төрийн байгууллагын өөрсдөө хийх боломжгүй, тусгай мэргэшил, ур чадвар шаардагдах, гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээг тухайн ажлын төрөл, цар хүрээ, мэргэжлийн ур чадвар, зах зээлийн үнэлгээнд үндэслэн Засгийн газрын санхүүгийн статистик гаргах аргачлал, загварт нийцүүлж, зардлын эдийн засгийн зүйл болон зориулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний ангиллаар нарийвчлан тодорхойлох, цаашид жилийн төсвийн тухай хуулинд тооцооллын хавсралтад нэмэлтээр тусгах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

92 гишүүн буюу 80.7 хувиар санал дэмжигдлээ.

2/төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн ерөнхийлөн захирагчид “бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” болон “бусад зардал” гэсэн зардлын ангиллаар төсөв зарцуулах болсон зайлшгүй шаардлага, гарах үр дүн, үр ашгийг тооцох;

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

93 гишүүн буюу 83.7 хувиар санал дэмжигдлээ.

3/олон улсын сайн туршлагад үндэслэн гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээнд хуулиар хязгаарлалт тогтоох, уг зардалд тавих шаардлагыг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгах, аудитын тайлангаар баталгаажуулах, олон нийтэд нээлттэй мэдээлэх зэрэг холбогдох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

92 гишүүн буюу 80.7 хувиар санал дэмжигдлээ.

4.Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дэх заалт нэмэх:

4.Төрийн байгууллагуудын мэдээллийн системүүд, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдлын программ хангамж, тоног төхөөрөмжүүдийн худалдан авалт, ашиглалтыг сайжруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, салбар хоорондын цахимжилтыг нэгдсэн удирдлагаар хангах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/төрийн байгууллагуудад ашиглаж байгаа мэдээллийн систем, программ хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын өнөөгийн байдал болон кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдалд аудит хийж тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

93 гишүүн буюу 81.6 хувиар санал дэмжигдлээ.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дахь заалт нэмэх:

5.Нийслэл Улаанбаатар хотоос шилжин байрших боломжтой төрийн байгууллагуудыг орон нутаг дахь төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжид нүүлгэх, нийслэл Улаанбаатар хотод чөлөөлөгдөх барилга байгууламжийн тоо байршил, зориулалтыг судалж, жагсаалтыг гаргаж 2025 оны

хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж, холбогдох шийдвэр гарсны дараа худалдах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

94 гишүүн буюу 82.5 хувиар санал дэмжигдлээ.

6.Төсөлд доор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмэх:

6.Төсвийн зардлыг шууд нэмэгдүүлж, төсвийн тэнцэлд сөргөөр нөлөөлөх Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжуудын талаар нэгтгэн судалж, 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

88 гишүүн буюу 77.2 хувиар санал дэмжигдлээ.

7.Төсөлд доор дурдсан агуулгатай 7 дахь заалт нэмэх:

7.Төсвөөс олгож буй бүх төрлийн татаас, урамшууллын эдийн засагт үзүүлж буй нөлөөлөлд судалгаа, шинжилгээ хийж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих болон төсвийн ачааллыг бууруулах зорилтуудыг уялдуулах санал боловсруулж 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

82 гишүүн буюу 71.9 хувиар санал дэмжигдлээ.

8.Төсөлд доор дурдсан агуулгатай 8 дахь заалт нэмэх:

8.Цэвэр эрчим хүч, хогноос эрчим хүч гаргах асуудлыг зохицуулах, дэмжих, ногоон эрчим хүч, ногоон эдийн засгийн тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг.

Санал хураалт.

84 гишүүн буюу 73.7 хувиар санал дэмжигдлээ.

9.Төсөлд доор дурдсан агуулгатай 9 дэх заалт нэмэх:

9.Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

81 гишүүн буюу 71.1 хувиар санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

88 гишүүн буюу 77.2 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

1.Тогтоолын төслийг доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-г даалгасугай:

1/бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх;

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн буюу 78.9 хувиар санал дэмжигдлээ.

2/Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн биелэлтэд үнэлгээ хийж, тусгай сан тус бүрийн зориулалт, төсөвлөлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийлгэж аудитын тайлан, Тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

86 гишүүн буюу 75.4 хувиар санал дэмжигдлээ.

3/гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийн эрэмбийг гаргаж, удаашралтай байгаа төслүүдийг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулан 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах;

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

89 гишүүн буюу 78.1 хувиар санал дэмжигдлээ.

4/шинээр авах гадаад зээлийн санхүүжилтийг эдийн засгийн өсөлтийг дэмжих, Бүсчилсэн хөгжлийн бодлого, томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалтад чиглүүлж, цаашид хувийн хэвшил хийх боломжтой төслүүдийг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх;

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

82 гишүүн буюу 71.9 хувиар санал дэмжигдлээ.

5/төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд үүссэн өр, авлага, зээлийн асуудалд дүн шинжилгээ хийж, тайланг 2025 оны нэгдүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулах;

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн буюу 78.9 хувиар санал дэмжигдлээ.

Зөвшөөрсөн: 90

Татгалзсан: 24

Бүгд: 114

78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6/аудитын шалгалтаар илэрсэн аливаа зөрчлийн шинжтэй асуудал тус бүрийн хариуцлагын асуудлыг Төрийн аудитын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн хуульд нарийвчлан зохицуулах, холбогдох хууль хоорондын уялдааг хангах, хийдэл зөрчлийг арилгах хуулийн төслийг 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

87 гишүүн буюу 76.3 хувиар санал дэмжигдлээ.

7/Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор эмнэлгийн зориулалттай, шаардлага хангасан барилгыг хууль, тогтоомжид нийцүүлэн 5 жилийн дотор өөрийн өмчлөлд эцэслэн шилжүүлэн авах нөхцөлтэйгөөр санхүүгийн түрээсийн гэрээ байгуулж худалдан авах;

Санал гаргасан ажлын хэсэг.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн гишүүн үг хэлнэ.

Ж.Чинбүрэн: Энэ их тогтоолын төсөл сонсоход их сайхан таатай. Ялангуяа энэ өвчлөлтэй энэ үед Хавдар судлал үндэсний төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор эмнэлгийн зориулалттай ийм лизингийн гэрээгээр 5 жилийн хугацаанд авъя гэсэн ийм яриа хийж байгаа юм байна. Зүгээр энэний цаана бид яг хавдар 2 төсөл маань үргэлжлэх юм уу үүнийг орлуулах ийм барилга байгаад авах гээд байна уу? Бас их сонирхол татаж байна.

Тэгэхээр ажлын хэсэг дээр энийг юу гэж ярьсан юм бол. Жишээлбэл бид БЗД-т эмнэлэгтэй болох гээд бүтэн 4 жил хөөцөлдөөд арай чүү гэж нэг 40 тэрбум тавьсан. Хэвлэл мэдээллээр метр квадратыг нь 12 сая төгрөг авах гэж байна гэдэг худал мэдээлэл тараасаар байгаад тендерийн зардлуудаа чадахгүй байсаар байгаад зогсоочихсон. Тэр мөнгө нь энд 2025 оны 20 тэрбум болоод явж байгаа юм биш биз? Их эргэлзээ төрүүлж байна.

Тийм учраас би бүр зориуд энэ тайлбар авмаар байна. Яг ямар тооцоолол дээр ажлын хэсэг дээр та бүхэнд юу гэж танилцуулагдаад аль эмнэлгийг хэний эмнэлгийг ямар үнээр 5 жилд жил бүр хэдэн төгрөгийн лизинг төлөхөөр товлож төлөвлөж хийсэн юм бэ? Хавдар 2 төсөл үргэлжлэх юм уу? Түүнийг зогсоох юм уу? Эс үгүй бол түр зуур ачааллыг нь даахаар юу хийх гээд байна уу? Энэ их олон асуултууд байна. Энд хариулт авмаар байх юм. Их Хурлын дарга яах вэ?

Д.Амарбаясгалан: Хариулт өгөх боломжгүй л дээ. Түрүүн асуулт хариулт дээр асуугаагүй учраас.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлнэ.

П.Сайнзориг: Агуулгын хувьд яг Чинбүрэн гишүүний хэлж байгаатай санал нэг байна аа. Энэ яг ямар барилгыг шууд ингээд. Одоо сүүлдээ ингээд ер нь хууль гаргаад л Улсын Их Хурлын тогтоолоор чиглэл өгөөд л юмнуудыг л шийдээд байх нь л дээ. Тэгээд ядаж тэр нэг дурдагдаад байгаа байшин савны өмчлөлийн асуудлыг нь Хөгжлийн банк энэ тэр дээр нэг мөсөн шийдэгддэг л дээ. Тэгчхээд дараа нь ингэхгүй. Одоо ингээд л тогтоолоор чиглэл өгөөд 5 жилийн хугацаанд ав. Энэ одоо хэний лобби орж ирээд байгаа юм бэ? Ажлын хэсэг яахлаараа ийм юм оруулж ирээд ингээд байх ёстой байдаг юм бэ? Харин тийм. Тийм учраас ийм зүйл байж болохгүй ээ. Энийгээ зүгээр ажлын хэсэг татаад авчхаач ээ. Ийм зориулалтын бус барилга дээр анхнаас нь тэр тоног төхөөрөмжүүд нь суурилагдаагүй бол наад тэр авах гээд байгаа яригдаад байгаа зүйл чинь ашиглаж болохгүй ээ. Тэгэхээр зүгээр л том зүйл рүүгээ урагшаа явмаар байна. Тэр сая Пүрэвдорж гишүүн тэндээс хэлж байна шүү

дээ. Тэр барина гэсэн тэр эмнэлгээ бариад л явъя л даа. Заавал энэ дээр нь би ямар учир явдлаар ийм бэлэн байшин орж ирээд байгаа юм бэ?

Д.Амарбаясгалан: 2 гишүүн дэмжээгүй байр сууриа илэрхийлж хэллээ. Ажлын хэсгийг төлөөлж санал гаргасан ажлын хэсгийг төлөөлж Ганзоригийн Тэмүүлэн гишүүн ажлын хэсгийн ахлагч.

Г.Тэмүүлэн: Энэ ажлын хэсэг энэ сая Байнгын хороон дээрээс орж ирэхдээ бас санал гаргасан гэдэг дээр бас техникийн алдаа гаргасан байх шиг байна. Ажлын хэсэг гэсэн байгаад байгаа. Яг санал гаргасан нь бол бас Дамдинням гишүүн бид 2 гаргасан. Энэ яагаад гаргасан бэ гэхээр сая Төсвийн байнгын хорооны 2 дугаар хэлэлцүүлэг дээр бас тодорхой бид нар төсвийн төслийг хэлэлцэж байх үед нийгэмд бас хамгийн гол бүх тулгамдаад байгаа асуудал болсон эрүүл мэндийн салбарт тэр дундаа хорт хавдартай холбоотой асуудлууд дээр нэн яаралтай одоо энэ эмнэлгийн хүртээмж энэ орны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр бас тодорхой чиглэлийг хийх ёстой байна гээд. Манай ажлын хэсгээс тодорхой санхүүжилт хөрөнгийг бол шийдвэрлэсэн байгаад байгаа. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс.

Харин одоо гишүүд маань тэр нөгөө бодлогыг төсөв дээр суусан санхүүжилт юмыг бол бас үзэж хараагүй байгаад байгаа учраас тогтоолд бас эргэлзэж байж магадгүй. Засгийн газрын зүгээс хэрэв төсөв дээр ийм асуудлыг оруулж ирж байгаа бол тогтоол дээрээ нарийвчилсан заалтыг бол хуульчилж ингэж оруулж өгье гэсэн. Энэний дагуу бол оруулсан байгаад байгаа юм аа. Ер нь бол ажлын хэсэг дээр бид нар судалж үзсэн. Иргэдээс энэ асуудлуудаар бас нэлээн саналууд гаргасан. Одоогийн мэдээж байгаа хавдрын эмнэлэг байгаад байгаа.

Дээрээс нь ирэх оны төсөв дээр зас Засгийн газрын зүгээс төсөв дээр оруулж ирснээр бол хавдар 2 дугаар эмнэлгийг барихаар ирэх 4-өөс 5 жилийн хугацаанд энэ зураг төсвийг нь хийгээд санхүүжилтийг нь батлах асуудлуудыг бол оруулж ирсэн байгаад байгаа. Тэгэхдээ ямар ч бай хугацаа шаардагдана. Ойрын хугацаанд бол манайх Монгол Улс Улсын Их Хурлаас баталж байгаа төсөв болон Засгийн газрын явуулж байгаа бодлогын хүрээнд Хавдар 2 дугаар эмнэлгийг барина. Гэхдээ өнөөдөр жилдээ 16 мянга орчим хүн хорт хавдраар оношлогдож байна аа. Тэгэхээр бид нар төрийн зүгээс энэн дээр ямар нэг байдлаар чихэн дүлий нүдэн балай байгаад байж болохгүй байгаад байгаа юм. Ямар нэг байдлаар энэ орных нь хүртээмжийг нэмэгдүүлэх, өнөөдөр юу гэдэг юм энэ хавдрын эмнэлэг хүрэлцээгүй байгаад байгаа. Эргээд юу гэдэг юм иргэд эмчлүүлэх боломж бололцоо тааруу байгаад байгаа энэ асуудлуудаар дүн шинжилгээ хийж энэ орных нь нэмэгдлийг бий болгох. Магадгүй энэ эмнэлгийн байгууламжийг түрээсээр ашиглах ч гэдэг юм уу. Энэ зохицуулалтуудыг хийх эрхийг нь Засгийн газарт төсөв мөнгөнийх нь хүрээнд хийж өгч байгаа юм.

Өнөөдөр сая энэ тогтоол дээр бас орж ирсэн заалтын хүрээнд яах вэ та бүхэн бас гайхаж байж магадгүй. Энэ нэг талдаа санхүүгийн түрээсийн гэрээгээр гэдэг асуудлууд байгаа. Яах вэ өнөөдөр энэ манайд бас нэг хэрэгжиж байсан практик байхгүй байгаа. Гэхдээ Санхүүгийн түрээс буюу лизингийн тухай хууль гэж байдаг. Энэ тухайн автомашин болоод тийм хэмжээнд хийдэг энэ ямар байх нь тухайн Засгийн газар тухайн юу гэдэг юм ЭМЯ-аас төсвийн хэрэгжилтийг зохион байгуулалтаа хийгээд л өөрсдөө л гол нь бид нарын хүсэж байгаа зүйл. Эргээд өнөөдөр Хавдрын эмнэлэг дээр байгаа орны хүртээмжийг нэмэгдүүлэх л асуудлууд байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ шийдлийг бол гаргаж өгсөн гаргаж өгсөн байгаа гэдэг та бүхэнд бас хэлэх байна. Харин цаашдаа хүссэн хүсээгүй бид нар бол өнөөдрийн энэ байгаа нөхцөл байдал дээрээ нэн яаралтайгаар энэ эмнэлгийнхээ хүртээмжийн асуудлуудыг шуурхай.

Д.Амарбаясгалан: Бямбацогт гишүүн дэмжиж үг хэлэх юм уу? Ингэе Тэмүүлэн гишүүн ажлын хэсгийн дарга, Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн. Төсөв дээр энэ асуудал яригдана шүү дээ тийм ээ. Тэгэхээр энэ заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгчихье. Үгүй ээ үгүй яах вэ төсвөө хэлэлцээд эцэслээд асуудлаа шийдсэний дараа энэ заалтаа зөрчилгүйгээр дараачийн хэлэлцүүлэг дээрээ шийдээд л явчихъя. Маргаан байхгүй тэгэх үү? Тэгэхээр гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

8/Америкийн Нэгдсэн Улстай байгуулсан агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу шууд нислэг хийх боломжийг бүрдүүлэх, үүнд шаардлагатай нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтыг нэвтрүүлэх зорилгоор навигацийн орлогоос шаардлагатай санхүүжилтийг 2025 оны төсвийн жилд зарцуулах.

Санал гаргасан ажлын хэсэг. Энд техникийн алдаа гарсан юм байна. Санал гаргасан Хассуурийн Ганхуяг.

Санал хураалт.

75 гишүүн буюу 65.8 хувиар санал дэмжигдлээ.

9/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа шинээр баригдах хөрөнгө батлагдаагүй нэн шаардлагатай зарим газар, байгууллагуудад түрээсийн барилга ашиглаж, үйл ажиллагаа явуулах;

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ц.Идэрбат, Ж.Чинбүрэн, О.Саранчулуун.

Санал хураалт.

65 гишүүн буюу 57 хувиар санал дэмжигдлээ.

10/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа газар, байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээсийн зарчмаар хангах эрхийг төсвийн ерөнхийлөн захирагчид олгох.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ц.Идэрбат, Ж.Чинбүрэн, О.Саранчулуун.

Санал хураалт.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлье.

Б.Энхбаяр: Энэ бид нар төсвийн хуулийг дагасан Их Хурлын тогтоол ярьж байгаа. Төсөв дээр гол баримталдаг асуудал бол төсвийн хүрээний мэдэгдлийг бид

3 жилийн хугацаанд төлөвлөдөг. Үүнийхээ дагуу жил жилийнх нь төсвийг тухайн жилд нь баталж явдаг. Одоо бидний хураах гэж байгаа заалт бол тэрний дараагийн Улсын Их Хурлын дараагийн Улсын Их Хурлын шийдэх асуудлыг шийдэх үү үгүй юу мэдэгдэхгүй асуудлыг урьдчилж шийдэх гэж байна. Өөрөөр хэлбэл, жишээлбэл 10 тэрбум төгрөгөөр компьютер ав тэгэхдээ 3 жил хуваагаад төлчих өө энэ жилд нь 3 тэрбумыг нь төсөвт нь баталчихъя, ирэх жилүүдэд нь 6, 7 тэрбумыг нь өгчихье гэдэг эрхийг сайд нарт Улсын Их Хурал олгох гэж байна. Ер нь шууд хэлье. Санхүүгийн лизинг хувийн хэвшилд компанид байдаг болохоос биш жил болгон төсвөө баталж авдаг төрд байдаггүй. Нэг сайд дараа жилийн Улсын Их Хурлын төсвийн хууль дээр байх эсэх нь мэдэгдэхгүй төсвийн өмнөөс жилийн өмнө батлан даалт өгч амлалт өгөхгүй.

Тийм учраас энэ бол өөрөө зарчмын асуудал байна. Тийм учраас санхүүгийн түрээсийн зарчмаар хангах эрх олгох гэдэг бол шууд ийм ийм томъёолол энэ төсвийн хуультай нийцэхгүй. Жавхлан сайд та нэг хэлээч. Санхүүгийн лизингүүдийг ер нь зөвшөөрч байгаа юм уу? Ер нь Сангийн яам, Төсвийн хуульд ийм эрх байгаа юм уу Санжаа дарга аа.

Д.Амарбаясгалан: Дэмжихгүй байр сууринаас хэллээ. Дэмжсэн байр сууринаас Л.Энх-Амгалан сайд үг хэлье. Үг хэлэх тийм горимтой.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр ийм байгаа юм гишүүд ээ.

Бид нар төрийг аль болохоор цомхон ингээд төрийн хөрөнгө оруулалтыг аль болохоор үр ашигтай байлгах зарчим гэж ингэж ярьж байгаа, 1 дүгээрт.

Хоёрдугаарт, бол бид нар төсвөөс аль болохоор ингээд томоохон хөрөнгө оруулалтуудыг тэр тусмаа дэд бүтцийн хөнгөн зөөлөн дэд бүтцүүдийн хөрөнгө оруулалтуудыг хийхийг жаахан төр өөр дээрээсээ жаахан ачаалал бууруулъя аа. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль бид нар батлагдаж гарсан. Боловсролын салбарт ч гэсэн би боловсролын сайд байхдаа яг энийг Их Хурлын тогтоолыг ингэж батлуулж багш нарын компьютерын асуудлыг шийдсэн, хамгийн сайн жишиг өнөөдөр байгаа шүү дээ. Өнөөдөр төр жилд ингээд 200, 300 тэрбум төгрөгөөр компьютер серверүүд аваад байх юм уу. Ер нь цаашдаа бид нар энэ компьютер серверүүдийг яг мэргэжлийн байгууллагуудаас нь санхүүг нь төрөөс төлөөд ингээд явах нь төрд би хамгийн ашигтай хувилбар гэж би харж байгаа. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ингээд энэ бүх юмнууд нь нээлттэй байгаа.

Энэ бол цоо шинэ биш. 2024 оны улсын төсөв дагасан тогтоол бас ингэж батлагдаж, боловсролын салбар дээр яг энэ санхүүгийн түрээсээр олон ийм мэдээлэл технологийн асуудлуудыг ингэж шийдвэрлэж байсан ийм юу байгаа байхгүй юу. Тэрнээс биш одоо ингээд Их Хурал дээр хөрөнгө оруулалтууд батлагдахгүй одоо ингээд тэр тусмаа тоног төхөөрөмжүүд энэ бүх юмны чинь бүгдийг нь хасчихлаа шүү дээ. Одоо цаашдаа бид нар яаж энэ төрийн үйлчилгээг иргэдэд яг ямар аргаар бид нар хүргэх юм бэ?

Одоо та нар бүх тус бус бүх л улс оронд байдаг энэ компьютер серверийн асуудлуудыг төр өөрөө худалдаж аваад суугаад байх юм уу? Энэ зөв юм уу? Дэлхийн чиг хандлага руу бид нар алхахгүй юм уу? Ингэж байж Монголын төр нэг жаахан ийм цомхон Монголын төрөөс хийж байгаа энэ татвар төлөгчдийн хөрөнгүүдийн үр ашигтай зарцуулахгүй юм уу? Ийм зарчмын асуудлыг л бид нар

ярьж ингэж ярьж байна. Энэ чинь цоо шинэ зүйл биш шүү дээ. Улсын Их Хуал дээр гарсан төсөв дагасан 2, 3 жилийн тогтоол дээр гарч байсан ийм л юунууд шүү дээ жишгүүд шүү дээ.

Д.Амарбаясгалан: Дэмжсэн байр сууриас үг хэллээ. Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Яах вэ энэ практикт бол байдаг юм олон улсын юунд бол. Гэхдээ тухайн төсвийн жил дээр хязгаарлалт тавьж өгдөг юм. Тийм хязгаарлалт тавьж өгөөд энэ тэдэн хувиас хэтэрч болохгүй шүү. Ингээд хязгаарлалт тавихгүй бол яалт ч үгүй Энхбаярын санаа зовж байгаа бас зөв. Энэ чинь магадгүй бид нар дараагийн 10 жилд хэрэглэх юмаа бүгдийг нь ингээд л байгаа Засгийн газар нь хэрэглэчихвэл лизингээр авчихвал энэ чинь бүр нөгөө дараа дараагийн парламентын үүрэгт халдана гэсэн үг. Тэгээд энэ бол олон улсын практикт бол тухайн төсвийн жилийн тэдэн хувиас хэтэрч болохгүй шүү гэдэг л практикт байдаг. Тухайн хуваарь төлбөр нь дараагийн төсвийн жилийн тэдээс хэтэрч болохгүй ээ гэж байдаг.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан дэмжихгүй байр суурьтай үг хэлнэ гэж байна.

Б.Жавхлан: Тийм. Би санал хэлчих үү. Ийм юмаа одоо Засгийн газар төсвөө өргөн барьчхаад ардаас нь дахиад хэдүүлээ нэмж төсөв ингээд сайд нар маань яриад дэмий байх 1-д.

Хоёрт энд чинь одоо мөнгө төсөвлөөгүй учраас ийм заалт ороод ч хэрэгжихгүй. Энэ түрээсийн байр түрээслэх ийм төсөв нэмэлт төсөв байхгүй. Санхүүгийн түрээсээр техник тоног төхөөрөмж авч хэрэглэх төсөв байхгүй учраас энэ заалт тэртээ тэргүй хэрэгжихгүй. Тэгэхдээ энэ дээр нэг ийм юм болох гээд байна шүү гишүүд ээ. Тэр нөгөө сая тэр хавдрын эмнэлгийг энэ санхүүгийн түрээсийн тухай хуулиар худалдаж авах гэж байгаа юм. Тэгээд нэг ийм нэг аягүй ойлгомжгүй тодорхойгүй аягүй том үүд нээгдэх гээд байна шүү. Тийм учраас Засгийн газар болгоомжлоод энэ тогтоол дээр нь энэ саяын заалтыг дурдсан. Саяын нөгөө нэг яадгийг дахиж найруулга гэдэг тэр заалтыг оруулж өгч байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл энэ удаа онцгой нэг удаа л энэ эмнэлэгт зориулж нэг ийм боломж нээж байгаа юм. Дахиж энэ санхүүгийн түрээс гэдэг энэ хуулиар ийм том объектыг үнэ өртөг нь ч тодорхойгүй хаана ямар байшин байгаа нь ч тодорхойгүй ийм зүйлийг бид нар урьдчилж төлөвлөнө гэдэг аягүй тийм. бас буруу жишиг тогтоно. Яг тэр заалт ороод ирэнгүүт энэ 2 л дагаад л ороод ирлээ л дээ.

Тэгэхээр ингэж болохгүй. Тийм учраас нэгэнт төсөв нь байхгүй учраас энэ удаа бол энэ 2 заалт өөрөө хэрэгжихгүй. Цаашдаа хэрвээ санхүүгийн түрээсүүд тэр гэрээгээ хуулиа ашиглаад явъя гэвэл бид төсөвлөж байгаад түрээсийн мөнгө төсөвлөж байгаад ингээд явах ёстой. Эмнэлгийн чинь хувьд бол сая ингээд ажлын хэсэг дээр мөнгийг нь төсөвлөчхөж байгаа учраас энийгээ харин бид нар эрх зүйн хувьд ямар нэг зөрчилгүйгээр хэрэгжүүлэх нь чухал байгаа учраас Засгийн газар тэр тогтоолдоо энэ заалтыг оруулж өгөөч ээ гэж бид нар хүсэлт тавьсан юм. Ийм ялгаатай шүү. Нэг нь төсөвтэй нэг нь төсөвгүй.

Д.Амарбаясгалан: Санал хураалт явуулья.

33 гишүүн буюу 28.9 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/-нд даалгасугай.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

72 гишүүн буюу 63.2 хувиар санал дэмжигдлээ.

3.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

79 гишүүн буюу 69.3 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

72 гишүүн буюу 63.2 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалтууд явагдана аа.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал

1.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Үндэсний зөвлөл” гэсний өмнө “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 44

Бүгд: 114

61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.9 дэх заалт нэмэх:

“15.1.9.байгууллагын төсвөөр түүхэн үйл явдлын ой, салбарын зарим ажил, мэргэжлийн ажилтны тэмдэглэлт өдөр, бусад тэмдэглэх өдрийг тэмдэглэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 47
Бүгд: 114
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн нэг дэх заалтын 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн Үндэсний зөвлөл гэсний өмнө хуульд өөрөөр заагаагүй бол гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

70 гишүүн буюу 61.4 ийн саналаар Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.9 дэх заалт нэмэх:

15.1.9 Байгууллагын төсвөөр түүхэн үйл явдлын ой, салбарын зарим ажил, мэргэжлийн ажилтны тэмдэглэлт өдөр буцаж тэмдэглэх өдрийг тэмдэглэх гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ.

Санал хураалт.

67 гишүүн буюу 58.8 хувиар Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

2.”Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

1.Төслийн нэг дэх заалтад Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2024 оны зарцуулаагүй үлдэгдлийг 2025 оны төсвийн эх үүсвэрт зарцуулах гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

57 гишүүн буюу 50 хувиар дэмжээгүй гэсэндээ орно тиймээ.

Далайн Батбаяр гишүүн горимын санал.

Д.Батбаяр: Төхөөрөмж ажилласангүй. Тийм учраас миний саналыг дэмжсэнээр оруулж өгнө үү, протоколд тусгаж өгнө үү?

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Энэ Ундрэм гишүүн ээ та энэ заалтаа татаа.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайдаа горимын санал гаргах боломжтой.

Б.Жавхлан: Тэгвэл энэ чинь дэмжигдээгүй шүү дээ.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдэхгүй байна гэдэг чинь гаргасан санал боссон.

Б.Жавхлан: Энэ тэгэхдээ өөрөө энэ чинь хууль зөрчиж байгаа юм шүү. 2024 оны төсвийг 2025 оны төсөвтэй ингэж холино гэдэг чинь бүр замбараагүй юм болно шүү дээ. Энэ чинь ерөөсөө хэрэгжих ч боломж байхгүй байхгүй. 2024 оны төсөв 2024 ондоо дуусна. 2025 оны төсөв 2025 ондоо эхлээд явна. 2024 оноос үлдсэн болгоныг 2025 руу шилжүүлдэг.

Д.Амарбаясгалан: Ямар ч боломж байхгүй. Жавхлан сайд хурууныхаа хээг уншуулаарай. Бүртгэлд байхгүй байгаад байна шүү. Болохгүй. Далайн Батбаяр гишүүнд микрофон өгье.

Д.Батбаяр: Миний юу төхөөрөмж ажиллаагүй учраас горимын санал гаргаж байна. Тэгээд дахин санал хурааж түрүүний хураасан саналыг хүчингүй болгох санал хурааж өгнө үү гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Манай зарим гишүүдийн санал ч эгзэгтэй үед ажиллахаа байчихдаг л болчихоод болж өгөхгүй юм.

Горимын саналаар санал хураалт явуулъя аа. Далайн Батбаяр гишүүний гаргасан горимын саналаар саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт.

67 гишүүн буюу 58.8 хувиар санал хураалтыг хүчингүй болголоо.

Ахиж уншиж танилцуулъя.

1.Төслийн нэг дэх заалтад Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2024 оны зарцуулаагүй үлдэгдлийг 2025 оны төсвийн эх үүсвэрт зарцуулах гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм.

Ундрэм гишүүнд микрофон өгье.

Ч.Ундрэм: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Энэ манай Боловсролын байнгын хороотой холбоотой Боловсролын яамны санхүүжилт 2024 онтой харьцуулбал харьцангуй өссөн. Гэхдээ сая хориг тавиулсан төсөвтэйгөө харьцуулбал 159 тэрбум төгрөг хасагдчихсан байгаа юм. Тэгээд энэний нэг нь энэ боловсролын зээлийн сан 15.5 тэрбумаар дүн нь санхүүжилт нь хасагдсан. Одоо үлдэгдэл 11 тэрбум төгрөг байгаа юм. Тэгээд энэ сан нь өөрөө эргэлтийн сан. Эргэн төлөлт болгон төсвөөс санхүүждэг. Тийм учраас өнгөрсөн жилийн энэ үлдэгдэл нь он дамнаад дараа жилдээ зарцуулагдаад яваасай. Яагаад гэвэл энд одоо маш олон гадаадын хүүхдүүдээс гадна дотоодын оюутнууд эндээс зээл авч байгаа гэдэг утгаар энэ саналыг гаргасан юм. Гэхдээ маш их авлага өшөө бас байгаа юм байна. Маш их хэмжээний. Тэгэхээр боловсролын яаманд энийг он дамнуулж байхаар тэр авлага дээрээ маш сайн ажиллах ёстой гэдэг ийм байр суурь дээр очсон учраас энэ саналаа татъя.

Д.Амарбаясгалан: Санал татагдлаа.

2.Төслийн нэг дэх заалтад Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хүрээнд Кино урлагийн сангийн 2024 оны зарцуулаагүй үлдэгдлийг 2025 оны төсвийн эх үүсвэрт зарцуулах гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир. Яг адилхан асуудал байна тиймээ.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Өмнөх чуулган дээр Уянгахишиг гишүүн энэ кино урлагийн сангийнхны уран бүтээлчдийн тавиад байгаа асуудлыг ярьсныг та бүхэн санаж байгаа. Мөн тэр асуудлыг би бас давхардуулж яримаргүй байна аа. Энэ дээр энэ өмнөх жилийнх нь мөнгийг үргэлжлүүлээд тавиад өгчих өө гэдэг ийм зүйл ярьж байгаа. Ямар ямар ач холбогдолтой вэ гэхээр энэ бид нар эдийн засгаа солонгоруулъя гэж яриад байгаа. Соёлын салбараа эдийн засгийн эргэлтэд оруулмаар байгаа байхгүй юу даа уг нь бол.

Д.Амарбаясгалан: Бум-Очир гишүүн хэдүүлээ одоо элдэв долоон поп сэдэв хэрэггүй байх. Төсвийнхөө хуультай нийцэж байна уу, үгүй юу гэдгийгээ ярих нь зүйтэй. Сая Жавхлан сайд маш тодорхой тайлбар өгч байна шүү дээ. 2024 оны үлдэгдэл төсвийг 2025 онд ашиглах боломжгүй ээ хууль зөрчине өө гэж байна. Тэгэхээр энэ дээр одоо санал гаргасан гишүүн саналаа санал хураалтаар шийдэх юм уу, татах юм уу л гэдэг асуудлаар өөрт чинь микрофон өгч байна. Микрофон Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Саналаа татъя.

Д.Амарбаясгалан: Санал татагдлаа. Тэгэхдээ гишүүд маань мэдээж санал гаргах бүрэн эрхтэй. Байнгын хороон дээр гаргаж байгаа санал нь өөрөө хуульд

заавал нийцэж байх ёстой гэдэг дээрээ сайн анхаарч байгаарай. Холбогдох албан тушаалтнуудаас сайн тайлбарыг нь авч байгаарай гэдгийг бас хэлье ээ. санал татагдлаа.

3."Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн "а" заалтаас боловсролын салбарын нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлаар санхүүжих арга хэмжээ, сургууль, цэцэрлэг, дотуур байрны хоолны материал худалдаж авах гэснийг хасаж, гадаад, дотоодын их, дээд сургууль мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургуулийн сурагчид тэтгэлэг олгох, төрийн өмчийн их дээд сургуулиудын тогтмол зардлыг төлөх, боловсролын салбарын ажилтнуудын чадавхжуулах, сургалтын төлбөрийн төрийн буцалтгүй тусламж олгох, олимпиад зохион байгуулах гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяад микрофон өгье.

Ц.Мөнхтуяа: Энэ санал чинь нөгөө хүүхдийн хоолны мөнгийг буцаагаад оруулчихсан гэсэн шүү дээ тиймээ. 31 тэрбум төгрөг гээд түрүүн Дамдинням гишүүн тэгсэн биз дээ. Тэгэхээр энэ санал бол болчихсон гэсэн үг. Тэгэхээр би дараагийнхаа санал дээр ярьчихаж болох уу? Энийгээ татаад дараагийнхаа санал дээр дэмжиж өгөхийг хүсээд байгаа юм гишүүд ээ.

Д.Амарбаясгалан: 3 дахь санал татагдлаа.

4. Боловсролын салбарт зарцуулах төсвийг нэмэгдүүлэх, НҮБ-аас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Боловсрол 2030, Инчоны тунхаглалын зорилтыг хэрэгжүүлэх салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ, хангамжийг сайжруулах, багш, ажилтны хөдөлмөрийн нөхцөлийг шинэчлэн тогтоох цалин хөлсийг тооцох шинэ аргачлал нэвтрүүлэх нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

1/2026 оны төсвийн жилээс эхлэн боловсролын салбарын төсвийн нийт зардлыг ДНБ-ий 6 хувиас багагүй эсвэл улсын төсвийн нийт зардлын 18 хувиас багагүй байхаар тооцон боловсруулж өргөн барих.

2/Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн зардлыг холбогдох хуулийн дагуу дараа жилийн төсөвт суулгаж өгөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяад микрофон өгье.

Ц.Мөнхтуяа: Манай боловсролын салбарын төсөв бол ер нь их бага байгаа. Манай салбар өөрөө их том салбар шүү дээ. Ер гаруй мянган хүнтэй сая гаруй хүүхэд суралцдаг энэ том салбар байгаа. Би зүгээр нэг наад захын жишээ татаж хэлэхэд манай хүүхдийн хувьсах зардлыг та нар нэг сонсчхоо. Манай гишүүд сайн анхаараарай. Боловсролын салбарын асуудал учраас энэ бүх хүнд хамаатай гэж

ойлгож байгаа. Нэг хүүхдэд ноогдох хувьсах зардал 1-ээс 12 дугаар ангид бол ялгаатай.

1.6 саяас 2.3 сая төгрөг байгаа жилд. Энэ нь долларт ингээд шилжүүлэхээр 470-аас зургаан зуухан долларын хооронд нэг жилд хүүхдэдээ иймхэн мөнгө зарцуулж байгаа шүү. Энэ бол ичгэвтэр тоо шүү. Тэгээд цэцэрлэгийн нэг хүүхдэд 2 сая 475 мянга доллароор тооцвол долоон зуухан доллар. 1 жилд бүтэн жилд цэцэрлэгийн нэг хүүхдэд 700 доллар зарцуулж байна. Энэ үнэхээрийн ичгэвтэр тоо.

Тийм учраас би энэ ДНБ-ийг зургаа хувьд хүргэе ээ. Боловсролын салбар дээр гэдэг зарчмын зөрүүтэй санал оруулж байгаа юм тэгээд боловсролд хайртай манай ухаалаг гишүүд минь бүгд дэмжээд өгөөрэй баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энэ Засгийн газраас өргөн барьсан төсвийнхөө бодлоготой нийцэхгүй байгаад байгаа л зүйл мэргэжлийн байнгын хороо дэмжээгүй л санал байна л даа. Тэгээд энэ асуудлыг дэмжээд баталчихаар Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлсэнгүй гэдэг асуудал руу шууд оруулах нөхцөл бүрдэж байна шүү дээ. Гэтэл өргөн барьчихсан төсөв өөрөө 2025 оны гэж байна шүү дээ.

Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Би үг хэлэх хэрэг байна уу даа. Санал хураагаад л явчихъя. Энэ ямар ч боломжгүй шүү дээ Мөнхтуяа гишүүн ээ. Та боловсролын салбарын хамгийн хайртай хүн юм байна бүгд мэддэг болсон. Тэгэхдээ төсөв гэж ямар хэцүү юм байдгийг бас бүгдээрээ мэддэг болсон. Одоо та хар ДНБ-ий 6 хувь гэдэг чинь хэдэн төгрөгийн тоо гэж бодож байна. 6 их наяд одоо 4.4 их наяд буюу хамгийн том төсөвтэй салбар. Хамгийн том төсөвтэй нь. Тэгээд сүүлийн жилүүдэд бүр огцом өсөж байгаа. Ялангуяа боловсролын багц хууль шинэчлэгдсэнээсээ хойш бүр огцом өссөн. Энэ жил ингээд хэдүүлээ алдагдалгүй төсөв баталж байна. Хойтон алдагдалгүй байна. Ганцхан энэ салбар дээр 2 их наядаар нэмэгдэж орж ирэх нь байна шүү дээ. 50 хувиар. Одоо боловсролын салбар дээр 6 хувь гээд оруулчихъя. Шинжлэх ухааны салбар дээр 2 хувь гэж байгаа ДНБ-ий. Өөр ингээд хэд хэдэн салбарууд дээр батлан хамгаалах нэг хувь гэж байгаа. Энэ 3 нийлэхэд ингээд л ДНБ-ий 10 хувь буюу 10 их наяд. Нөгөө 30 их наядын чинь 3-ны 1 нь 3 салбар дээрээ ингээд явах нь байна шүү дээ. Тэгэхээр чинь хаана яаж ямар төсөв хийх вэ? Ямар алдагдалгүй төсөв батлах вэ? Яаж нөгөө бид нар зардлаа өсгөхгүй байх вэ? Яаж төсвөө тэлгүй байх вэ? Тэгэхээр хэдүүлээ төсвийнхөө боломждоо харин багтаагаад энэ боловсролынхоо салбар дээрээ хайртай л байгаа юм.

Тийм учраас мэргэжлийн Байнгын хороо нь дэмжээгүйг тэгээд л санал хураагаад л явъя.

Д.Амарбаясгалан: Санал хураалт.

43.9 хувиар Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Дамдинням горимын санал.

Г.Дамдинням: Даргаа энэ бас миний энэ нөгөө нэг хурууны юу нь бас болж өгөхгүй байгаад болсонгүй ээ. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна. Дахин санал хураалт явуулж өгөөч гэж.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдиннямын гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

45.6 хувиар санал дэмжигдсэнгүй.

3.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

3/2025 оны Улсын төсөвт тусгагдсан бүх барилга байгууламжийн ажлын төсөвт өртөг, түүний магадлал үнэн зөв хийгдсэн эсэх, төсөвт өртгийг тооцож, магадлал хийх эрх бүхий этгээдүүдийн үйл ажиллагаа холбогдох хуулийн хүрээнд шударга явж байгаа эсэхийг хараат бусаар нягтлан шалгах ажлыг зохион байгуулж, үр дүнг 2025 оны эхний хагас жилд багтааж Улсын Их Хуралд танилцуулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа.

Д.Үүрийнтуяа: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр энэ дээр бас Байнгын хороон дээр ойлголтын зөрүү үүсээд бас санал хураалт явагдаад дахин тайлбар өгөх боломж гараагүй. Яагаад энэ заалтыг оруулсан гэхээр одоо байгаа тогтоолын төсөлд 2025 оны төсөвт тодотголын юу гэдэг юм энэ нөгөө магадлалын дүнгээр нэмэгдэх дүн тусаагүй ээ гэж Сангийн яам хэлж байгаа юм. Тэгэхээр яг энэ 25 онд нэмэгдээгүй дүндээ магадлал хийх үүргийг энэ тогтоолоор өгөөд байгаа юм. Миний санаа бол 2025 оны төсөвт дамжиж шилжиж орж ирсэн тухайлах юм бол 21, 22, 23, 24 оны төсөв дээр магадлалаар нэмэгдээд ороод ирчихсэн энэ бүх ажлууд дээр Засгийн газрын яамдууд маань өөрсдөө энэ 3 магадлалыг хариуцаж байгаа 3 яамны сайд нар зохион байгуулалтаа хийгээд Засгийн газар бас зохион байгуулалтаа хийгээд өөрсдөө эхлээд дотооддоо хяналтаараа энэ магадлалаа үнэн зөв байна уу үгүй юу, үнэн зөв нэмэгдэж байна уу үгүй юу гэдэг юмаа шалгаач ээ гэж байгаа юм. Шалгаач ээ ингээд дүнгээ Улсын Их Хуралд танилцуулаач ээ. Хэрвээ энэ асуудал нь шийдэгдэж чадахгүй бол Улсын Их Хурал нь сонсгол хийе ээ. Тэрнээс засаг дотоод хяналтаа хийгээгүй юман дээр бид нар бас түрүүлж ороод байхгүй байдлаар зохицуулалт хийе ээ гэсэн саналаар л энэ чиглэлийг оруулж ирсэн юм байгаа юм. Тэгээд энэ саналыг дэмжиж та бүхэн маань бас кнопдоо хүрэхгүй байж өгөөч ээ гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: 2025 оны улсын төсөвт суучихсан хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ бол төсөвт өртөг нь нэмэгдсэн бол аудитаар дүгнэлт орчихсон ийм зүйлүүд.

Аудитаар ороогүйг нь энэ 2025 оны төсөвт оруулалгүй үлдээчихсэн. Түүнийгээ холбогдох магадлалаа нягтлаад дахиж аудит хийлгээд 2025 оны 1 дүгээр улиралд Улсын Их Хуралд оруулж ир гэдгийг “Засгийн газарт өгөх чиглэл өгөх тухай” тогтоол дотор орчихсон юм аа.

Тийм учраас энүүгээр би бол дэмжих боломжгүй байна гэж.

Д.Амарбаясгалан: Санал хураалт.

47.4 хувиар Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 7 дахь дэд заалт нэмэх:

“7/Хууль тогтоомжид зааснаас бусад яамдын чиг үүрэгтэй давхацсан зөвлөл, хороо, комисс, төв гэх мэт байгууллагуудыг татан буулгаж чиг үүргийг холбогдох яамдад шилжүүлэх;”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг. Сайнзориг гишүүний микрофон өгье.

П.Сайнзориг: Би гишүүдээсээ кнопдоо битгий хүрч өгөөч ээ хэдүүлээ төр данхайж байна аа. Төрийн байгууллагууд олширч байна хэмнэе ээ, цөөрүүлэе ээ гээд яриад байгаа мөртөө өнөөдөр яг энэ зүйлүүд дээр сая энэ санал маань Төсвийн байнгын хороон дээр уначихсан юм аа. Яах вэ гишүүдэд нэг талдаа мэдээллүүдээ өгч чадаагүй.

Хоёрдугаарт ерөнхийдөө энэ төрийн бодлого боловсруулах ажил яамд хариуцаж байгаа юм аа. Яамдын сайд буюу тухайлан бүр Эрчим хүчний сайд байгаад байхад Эрчим хүчний реформын зөвлөл ч гэх шиг тийм юм байгуулж байгаа юм. Орон сууцын яам байсаар байхад дахиад Орон сууцын зөвлөл байж байгаа юм. Тэгээд ер нь зүгээр яг энэ салбар дундаа зохицуулалт хийх уялдуулах асуудал байж болно оо. Үүнийгээ бид нар Засгийн газар дээрээ Ерөнхий сайдын захирамжаар ч юм уу ингээд шийдээд явчихдаг байхгүй юу. Гэтэл сүүлийн үед нэг төрийн албаны босго давдаггүй эргээд ийм хүмүүсийг цуглуулдаг, яамдын хийсэн ажлуудыг бичиг явуулж авдаг, авсан ажлыг нь зүгээр Пи Ар болгож хэлдэг. Иймд зөвлөл, хороо, комисс юу ч хурдлуулдаггүй хурдасгуур төв бүтээмжгүй бүтээмжийн төв ийм зүйлүүд байна аа. Энэ өөрөө эргээд төрийн албыг муухай харагдуулж байгаа шүү.

Дээрээс нь ерөөсөө энэ яамдыг ажлаа хийж чадахгүй байгаа ч юм шиг тэнд байгаа залуучуудын санал. Тэнд залуучууд ажиллаж ажиллачхаад ерөөсөө ийм зүйлүүдийг ярьж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид хэд хариуцлагатай байя аа. Яамдын чиг үүрэгтэй давхцаж байгаа. Би энэ хуулиар байгуулсан нийгмийн даатгалын зөвлөл энэ тэртэй юу ч ярихгүй. Энэ төрийн байгууллага гэдэг чинь хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг болохоос биш огтоосоо тэр байгууллагад хууль дээр ямар ч чиг үүрэг байхгүй байж байхад хий хоосон ингээд дахиад нэг машин унасан дарга дахиад нэг байрны түрээс. Би зүгээр одоо жишээ нь Энхбаяр сайд ХААЯ-аас гарсны дараа тэр байшинд нь бас ямар юмны хороо орсон гэлээ ерөөсөө л энэ. Тэгээд ерөөсөө ийм байдлаар хэдүүлээ ингээд олон нийтэд яг бодит байдал дээрээ наад захын ийм зүйлээс хэмнэхгүй байгаа шүү дээ. Тэгээд энийг одоо кнопдоо хүрэхгүй байж байгаад дэмжиж өгөөч ээ.

Цаашдаа энэ харин төрийн албаны хуулийг бас нэг жоохон сайжруулах асуудал байна. Үнэхээр ур чадвартай залуучуудыг төрд ажиллуулдаг тэр үүд хаалгыг нь жоохон нээж өгөх ёстой юм. Ажилласан жилээр чөдөрлөөд байж бас болохгүй. Би энийг 2 талтай гэдгийг ойлгож байгаа. Тэгэхдээ хуульд огтоосоо байхгүй энэ чиг хороодыг ер нь буулгачихъя. Тэгээд мэдээллүүдээ нуугаад байх юм. Баахан судалгаа хийж байгаа гээд танилцъя авъя гэхээр өгөхгүй. Тэгээд хэний төлөө юу хийдэг ямар байгууллага юм бүү мэд. Тэгэхээр энийгээ одоо зоригтой шийдье ээ. Сайд нар аа, та хэд маань бас больчих л доо. Яам нь яамаараа байя. Засгийн газар нь Засгийн газраараа хамтын шийдвэрээ гаргая. Үйл ажиллагаагаа уялдуулахдаа, Ерөнхий сайдынхаа захирамж Засгийн газрын тогтоолоороо асуудлаа шийдээд явъя. Яахлаараа ингээд 5-аас 50, 60 хүнтэй төрийн албанаас өндөр цалинтай ийм байгууллагуудыг байгуулах ёстой юм бэ? Больё энийг.

Д.Амарбаясгалан: Доржханд сайд.

Т.Доржханд: Баярлалаа.

Одоо би бас нэг ийм тов тодорхой бас байр сууриа хэлэхгүй бол болохгүй байна аа. Тухайлбал би Сайнзориг гишүүнийг аягүй их маш олон зүйл дээр санал нийлдэг ээ. Маш олон бодитой зарчмын зүйл дээр санал ярьдаг, санал нийлдэг. Харин энэ зүйл дээр бол нэг ийм ялгаатай юм байгаан гэдгийг ойлгоорой гэж хүсэж байгаа. Юу вэ гэхлээр ЭХЯ тухайлбал ингээд өөрийнхөө салбарын ажлыг хийж байна. Гэтэл ногоон шилжилт рүү хийе ээ гэдэг энэ зорилтоо бид нар тавьчихсан байхгүй юу 2030 он. 2040, 2050 он цэвэр эрчим хүчний эх үүсвэртэй болно гээд бид нар баталчихсан байхгүй юу. Ийшээгээ шилжихийн тулд энэ үндэсний хороо чинь ажиллаж байгаа юм Шадар сайдын доор. Тухайлбал ганцхан Эрчим хүний яам биш, Байгаль орчны яам. Тэгээд ногоон шилжилт рүүгээ хийе ээ гээд. Тэгээд ногоон шилжилт дээр чинь хөрөнгө оруулагчид орж ирээд байгаа байхгүй юу. Тэр хүмүүс юу хүсээд байна гэхээр стандарт хүсээд байгаа юм.

Одоо тухайлбал Ерөнхий сайд бид нар сая Араб руу айлчлаад ирж байгаа юм. Тэнд болохлоор бид нар маш бага үнэтэйгээр ногоон эрчим хүч тэгээд устөрөгчийн төсөл дээр чинь оръё оо. Тэгэхийн тулд та нар бодлогоо гаргаж ирээч ээ. Стандарт гэхэд тухайлбал акура гэдэг акура пауверынх болохоор 500 ийм хуудастай стандарт байгаа байхгүй юу. Англи хэл дээр. Зөвхөн санхүүгийн стандарт. Дараагийнх нь дараагийн стандартууд байгаа. Тэгээд банкнууд орж ирнэ. Энэ бүх юмыг чинь ингээд хийхийн тулд энэ Эрчим хүчний үндэсний хороо чинь ажиллаж байгаа юм аа. Түүнээс ингээд нэг Эрчим хүчний яамны урдуур ороод яамных нь салбарын ажилтай ноцолдоод байгаа юм огт байхгүй шүү. Тийм буруу мэдээлэл битгий өгөөрэй. Одоо бид нар энэ өнөөдөр тоггүй байна шүү дээ тийм байгаа биз дээ. Өчигдөр тогны хязгаарлалтад орчихсон. Чойжоо сайд үнэнээ хэлээд явж байгаа нь бодит байдал энэ шүү дээ. Гаднын хөрөнгө оруулалт байхгүй. Төсөв дээр чинь ингээд эх үүсвэр байхгүй. Тэгээд мөнгө хаашаа орох вэ гэхээр чинь ногоон дээр чинь орно гээд байна шүү дээ. Гэтэл бид нар ингээд ногооныгоо ингээд шилжилт нь тодорхойгүй бодлогын бичиг баримт нь байхгүй. Түүнийг хийдэг бүтэц нь байхгүй экспертүүд нь байхгүй ингээд байхад чинь үгүй ээ хуучнаараа явна энэ дээр ер нь байх ёстой, эд нар хийх ёстой гээд. Гэтэл энэ салбар чинь өөрөө өнөөдөр бодит байдал дээр гацчихаад байгаа нь өнөөдрийн бид нарын энэ реформ хийх үндсэн зорилго шүү.

Тэгээд тийм болохоор энийг ингээд буруу мэдээллийг нь өгдөг, тэгээд энэ хүн ажлаа хийж чадахгүй болохлоор энэ хүн хийгээд байна гэсэн ийм байдлаар биш шүү. Чойжоо сайд бол бодитойгоор сайн ажил хийж байгаа. Харин энэ эрчим хүчний шилжилт хийнэ ээ гэдэг бол энэ олон улсын стандартаар явах юм. Олон улсын стандарт яахын тулд энэ чинь зөвлөх үйлчилгээ хэрэгтэй. Дотоод гадаадын. Энэ дотоод гадаадын зөвлөх үйлчилгээг нь эрчим хүчний нөөц байхгүй ээ. ЭХЯ-ан дээр тийм хүний нөөц байхгүй. Манай Сангийн яаман дээр ч гэсэн дутагдалтай байдаг юм. Энийгээ бид нар энэ гадна дотнын нөөцийг бүрдүүлж байж энэ бичиг цаасаа стандартын дагуу бий болгоно. Энэ Засгийн газрын хувьд ямар нэгэн давхардал байхгүй үл ойлголцолд огт байхгүйгээр хийж байгаа салбар дундын зохицуулалтыг хийж байгаа ийм шилжилт юм байгаа шүү. Ердөө 10 тэрбум төгрөгийн зардлыг бид нар 800 тэрбум.

Д.Амарбаясгалан: Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлье.

Б.Энхбаяр: Энэ 3 сарын өмнөх Доржханд ол биш байгаад байна. Энэ өөр хүн ороод ирчихсэн юм шиг байна. Эсвэл өөрийгөө хувилчихсан юм уу энэ би танихгүй л хүн байгаад байна. Энэ Сайнзориг гишүүн их үндэслэлтэй юм яриад байгаа юм аа. Би бол анх удаа төсвийн ажлын хэсэгт сая их юм ярьсан учраас гээд л оруулчихсан юм шиг байгаа юм. Ажиллаж үзлээ л дээ. Ингэхдээ Энхтүвшин гишүүн, Баярмаа гишүүн, Түвшин гишүүн бид хэд нөгөө энэ орон тооны давхардал 90 нь ямар болчихсон юм бэ гэдгийг Сангийн яамны яг цалин хөлс авч байгаа байдал бүх байгууллага хороогоор нь танилцсан юм. Яг энэ асуудал бол ер нь Засгийн газар эндээ 1 дүгээрт маш том улс төрийн дүгнэлт өөрсдөө хийгээсэй гэж би хэлэх гэж байгаа протоколд. Хийхгүй бол энэ 2024 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх 2025 оны хаврын чуулган дээр энэ маш том асуудал болж босож ирэх юм байна лээ. Энэтэй холбоотой аягүй сонсгол хийгдэх юм шиг байна. Яагаад гэхээр энэ дээр хуульд байхгүй 40 гаруй хороо, зөвлөл түүгээрээ байгуулаад сарын дунджаар 4.5 сая төгрөгийн цалин олгоод төрийн албаны шалгалт өгөөгүй хүмүүсийг хяналтгүй ажиллуулаад хувь хувьсгалын янз бүрийн үнэтэй оффисуудад түрээсийн мөнгийг нь төлүүлээд ингэж байгаа ноцтой асуудал тэнд байгаа юм байна лээ. Ажлын давхардал ярих юм бол нэг ажил дээр 5 ажлын алба ч байгуулчихсан ч байх шиг. Энийгээ засаг өөрөө дотроо эхлээд яриад эмхлэх бололцоог олох үүднээс сая ажлын хэсэг тэнсэнгийн хугацаа өгсөн шүү. Тэрнээс биш одоо энэ дээр энэ одоо бол Сайнзориг гишүүний яриад байгааг яахгүй байлаа гэхэд энэ дараа нь өөрөө албан хүчээр энэ асуудал болох юм байна лээ, нэг.

Хоёрдугаарт, энэ үндэсний хороо, зөвлөл гэдэгт энэ Улсын Их Хурлын гишүүдийг хаалт дотор хэлж байгаа шүү. Авлига дах байдлаар оруулдгаа нэн даруй таслан зогсоо. Улсын Их Хурлын дарга ч гэсэн энэ дээр анхаарч Засгийн газрын түвшинд шийдвэрээр Засгийн газрын янз бүрийн Үндэсний хороонд оруулаад томилогдчихсон байгаа гишүүдийг буцаад татмаар байна. Яагаад гэхээр Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнийг хавсрахаас өөр бусад ажил үүрэгт ажил хийхийг хууль Үндсэн хуулиар хориглочихсон шүү. Энэ Үндсэн хууль зөрчиж байж гишүүд маань эгүүлэн татуулав.

Тийм учраас энэ ажлыг нэн даруй таслан зогсоох хэрэгтэй.

Д.Амарбаясгалан: Тийм Улсын Их Хурлын гишүүд яах вэ зөвшилцсөнөөр мэдээж Засгийн газраас болон магадгүй Ерөнхийлөгчөөс тодорхой чиглэл гарч

байгаа ажлын хэсгүүдэд орж ажиллах боломж байдаг. Гэхдээ олноороо бас энэ Засгийн газраас байгуулагдсан хороодод орж ажиллаж байгаа байдал нь бас зөрчилтэй байна гэдэг асуудал бас хөндөгдөх нь хөндөгдөж явж байгаа. Би өөрөө бас энэ асуудал дээр ер нь Улсын Их Хурлын гишүүн, Үндэсний хороо, зөвлөлд орж ажиллах нь зохимжгүй юм гэсэн энэ байр суурийг бас өмнө нь илэрхийлсэн.

Цаашдаа ч бас дэмий байгаа юм. Улсын Их Хурал нь Улсын Их Хурлынхаа ажлыг Засгийн газар нь Засгийн газрынхаа ажлыг хийж байх ёстой. Зүгээр энэ Сайнзориг гишүүний гаргасан санал дээрээс мэдээж яах вэ салбар чиглэл хариуцсан сайд нар давхар давхар Үндэсний хороо зөвлөл байгуулаад тухайн салбарын хөгжлийг хурдасгах зорилготой ажиллаж байгааг нэг их буруутгах гэдэг талаасаа илүүтэйгээр хандах нь зөв болов уу гэж бодож байгаа юм. Жишээ нь энэ тогтоол батлагдчихвал Сайнзориг гишүүн бидний баталчихсан өнөөдөр хэрэгжиж байгаа Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орох асуудал яригдана шүү дээ. 20 минутын хот Үндэсний хороо, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх үндэсний хороо, үгүй ээ энд маш тодорхой байна шүү дээ. Яамдын чиг үүрэгтэй давхцацсан зөвлөл, хороо, комисс гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр чинь жишээ нь БХБЯ-тай давхцаж байгаа 20 минутын хот Үндэсний хороо яах вэ. ЗТЯ-тай давхцаж байгаа хороо яах вэ гэдэг асуудал үүсэж болзошгүй байна аа. Энэ дээрээ бас бодолцох нь зөв байх гэж бодож байна. Учрал сайд. Санаачилгыг дэмжиж байгаа юм. Гэхдээ үүсэх эрсдэл тийм болчих вэ л гэдэг асуудал байна. Учрал сайд.

Н.Учрал: Энэ Сайнзориг гишүүний гаргаад байгаа саналыг зарчмын хувьд дэмжинэ ээ. Гэхдээ нэг ийм асуудал байгаа юм аа.

2019 онд бол тухайн үед энэ Цахим хөгжлийн яам гэж байгаагүй байхад Цахим хөгжлийн үндэсний хороо гэж байгуулаад дэвшил гарч байсан. Яагаад гэвэл салбар дундын асуудал. Түүн шиг одоо энэ удаагийн Засгийн газарт л нэг их Үндэсний хороо байгуулагдчихсан байгаа юм байхгүй. Үе үеийн Засгийн газарт энэ Үндэсний хороо, зөвлөл ажиллаж ирсэн. Ялангуяа ийм салбар дундын асуудлыг хариуцах ийм үндэсний хороодод зөвлөлүүд ажиллаж байж ажил урагшилдаг уу гэвэл бас урагшилдаг. Жишээ нь Үндэсний баялгийн сан, Орон сууцжуулалтын хороо гэхээр энэ чинь нэг талаасаа хөдөлмөр, нийгэм хамгааллын салбарын асуудал нөгөө талаасаа Хот байгуулалтын яамны асуудал. Энэ чинь нөгөө талаасаа тэр 20 минутын Үндэсний хороо гээд байгуулагдаад оролцоод явахаас өөр энд шийдэл гарахгүй. Жишээ нь шинэ хоршоо хөдөлгөөн дээр бид нар Үндэсний хороо байгуулж ажиллаж байж ХХАА-н салбар ч бай Шадар сайдын хэмжээний түвшинд авчирч байж энд бас ахиц дэвшил гарч байгаа. Тэгэхээр зайлшгүй ийм салбар дундын асуудлыг хариуцах сайд бол өнөөдөр Засгийн газарт яг ЗГХЭГ дээр л байдаг. Тэгэхээр бүх энэ салбар дундын уялдааг хариуцах ажлыг бүгдийг нь Хэрэг эрхлэх газар дээр авчраад явбал энэ угаасаа ачааллаа ч дийлэхгүй байхгүй юу.

Тэгэхээр ийм үндэсний хороод бол энэ удаа шинээр байгуулагдчихаад байгаа зүйл биш. Харин ч сая хамтарсан Засгийн газрын үед 31 Үндэсний хороо зөвлөлийг татан буулгаж байж энэ алсын хараа 2050 гэдэг энэ үндэсний хороог байгуулаад багасгасан. Цаашдаа бол бид нар энэ Үндэсний хороо, зөвлөл, комиссуудыг буулгах гээд байгаа энэ гишүүдийн санаачилгыг дэмжээд явах ёстой. Гэхдээ яг өнөөдрийн Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийг хуулиар бид та бид хамтдаа Хяналт үнэлгээний үндэсний хороог байгуулсан. Та бид хамтдаа 20 минутын үндэсний хороог байгуулсан. Боомтын сэргэлтийн үндэсний хороог байгуулсан.

Тэгэхээр эдгээр үндэсний хороод бол ажлын албатай байхаас өөр замгүй байдаг.

Хоёрт төрийн албаны шинэчлэлийг хийхгүй бол ялангуяа энэ үндэсний хороонд орж ажиллах салбарын мэргэжилтэн экспертүүдийг төрд оруулж ажиллуулъя гэхээр нөгөө Төрийн албаны хуулийн чинь босгыг давахгүй байна аа. Тийм учраас бол энэ хаврын чуулганд бол төрийн албаны хуулийг өргөн бариад энэ төрийн албанд бас нэг салхи оруулах бололцоог бүрдүүлэх ёстой. Хамтарсан Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа эрчим хүчний шилжилтийг хийхэд ХҮН намын боловсруулсан мөрийн хөтөлбөрийг илүүтэй барьсан. Ингээд энэ мөрийн хөтөлбөр дээр хэн суусан юм бэ гэсэн чинь гадаад дотоодод сургууль соёл төгссөн мэргэжилтнүүд суусан гэхээр тэр хүмүүсийг авчраад ажиллуулъя гэхээр төрийн албаны шаардлагыг чинь хангахгүй ээ. Энэ чинь олон улсад ажиллаж байсан эксперт хийж байсан хүмүүс. Тэгэхээр ингээд Үндэсний хороонд татан оролцуулж бодлого боловсруулах чиглэлээр нь ажиллуулж байгаа. Энэ утгаараа Үндэсний хороо.

Д.Амарбаясгалан: Санал хураалт.

Дэмжсэн 2 дэмжээгүй 2 байр суурь илэрхийлчихсэн учраас санал хураалт явуулъя.

45.3 хувиар Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал, дэмжигдсэнгүй ээ.

4.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

1.Төслийн 1 дэх заалтын “-Ургамал хамгааллын газар” гэсний дараа “, Зам тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” хэсэгт “-Төмөр замын газар” гэж нэмэх.

Санал уу? Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Их Хурлын дарга, Их Хурлын гишүүдийн энэ оройн амар амгаланг айлтгая.

Бид мэдээжээр их чухал чухал зүйлүүдийг ярьж байна хэлэлцэж байна.

Нэг зүйлийг бас сайтар ойлгоосой гэж бас бодож байна аа. Бид нар та бүхэн ойлгож байгаа ч гэхэд эргэлзэхгүй байна. Энэ аливаа улс орон бол зорилгодоо нийцсэн бүтцийг бол Засгийн газрын түвшинд тодорхойлдог. Тэгээд энийгээ бас хуульчлаад баталчихсан л байдаг л даа. Тэгэхлээр энэ миний оруулсан санал бол Монгол Улсын Их Хурлаас 2023 онд Төмөр замын тээврийн тухай хуулийг баталсан. Энэ хуулийн 10 дугаар зүйл энэ хуулийг дагалдан гарсан Улсын Их Хурлын 2023 оны 7 сарын 7-ны 72 дугаар тогтоол байгаа юм. Төмөр замын агентлагтай байхаар ингээд тусгачихсан юм. Тэгээд энэ хүртэл байгуулагдаагүй байж байгаа хуулиар байгуулагдах ёстой л агентлаг л даа.

Нөгөөтээгүүр Монгол Улсын хөгжлийн томоохон зорилтуудын нэг бол төмөр зам өөрөө яах аргагүй мөн. Тэгээд бид яах вэ төрийн захиргааны төв байгууллагад энэ ажлыг даатгачихсан тэнд бодлого гарч байгаа. Тэр нь ойлгомжтой бодлогыг

тодорхойлж байгаа нь ойлгомжтой байгаа. Шийдвэр нь эндээс гарч байгаа. Гэхдээ энэ шийдвэрийн хэрэгжилтийг хангадаг нь угаасаа төрийн захиргааны байгууллага байдаг энэ агентлаг байдаг л даа.

Тэгэхээр бид 250 ААН-тэй 14 мянган хүн ажиллаж байгаа энэ төмөр замын салбар буюу манай томоохон бүтээн байгуулалтыг цааш нь авч явах энэ асуудал дээр энэ агентлагийг нь байгуулах ёстой юм байна гэдэг ийм чиглэл ийм ойлголттой болсон. Тэгээд яах вэ энийг судалсан. Тэгээд одоо байгаа байдлаар бид мэдээж хэрэг бүтцээ нэмж болохгүй шинээр төсвөө жишээ нь нэмж болохгүй нь ойлгомжтой. Тэгээд одоо байгаагаар галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах газар дээр бол 25 хүний орон тоо байгаа. Энэ улсууд нь ТҮ боловч ТЗ байхаар бэлтгэгдэж байгаа юм байна. Нөгөөтээгүүр яамнаас бол яг энэнтэй холбоотой 13 хүний бүтэц байгаа юм байна. Тэгээд энүүгээр энэ агентлаг байгуулагдах бүрэн боломжтой гэсэн ийм тайлбар өгсөн учраас эрхэм гишүүд та бүхэн Монгол Улсын энэ хөгжлийн томоохон зорилт болсон энэ ажлыг зохицуулалтыг нь хангах төрийн захиргааны төв байгууллагыг байгуулж өгөх нь зөв шүү гэдэг энэ дээр та бүхэн бас саналаа бодоорой.

Өөрөөр хэлбэл энийг дэмжихгүй байх өөрөөр хэлбэл Байнгын хорооны жишээ нь дэмжээгүй саналыг жишээ нь дэмжихгүй байхаар та бүхэн кнопдоо гар хүрэхгүйгээр эндээс санал өгөөч ээ гэж хүсэж байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Энэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг шинээр өөрчлөх, байгуулах асуудал бол Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын Ерөнхий сайдын Үндсэн хууль дээр олгосон онцгой бүрэн эрхийн асуудал байгаа.

Тийм учраас Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ гэж хүн байгаа. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд ийм санал Улсын Их Хуралд оруулж ирээгүй. Зулпхар гэж Ерөнхий сайд бол байхгүй байгаа. Тийм учраас энэ бол Үндсэн хууль зөрчигдөх байдал руу энэ санал хураалт түлхэх гээд байгаа учраас Зулпхар гишүүн бараг саналаа татаж авч Улсын Их Хурлыг хүнд байдалд оруулахаас сэргийлээч ээ гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Ж.Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье. Дараад нь Баатаржавын Мөнхсоёл гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Зулпхар гишүүний ярьж байгааг үндсэндээ дэмжиж байгаа юм аа. Тэгээд одоо Энхбаяр маань бас хэтэрхий их юм болгоныг аваачаад зогсоож байдаг байж болохгүй шүү. Бид хамтдаа сууж байгаад Төмөр замын тухай хууль баталсан. Энэ Төмөр замын хууль дотор төмөр зам агентлагтай байна гээд заачихсан байгаа. Өнөөдөр энэ хүртэл хэрэгжээгүй явж байгаа. Өнөөдөр төмөр замын салбар маань урьд өмнө нь байснаасаа хамаагүй өргөжчихсэн шүү дээ. Маш олон ААН-үүдтэй болсон, хувийн хэвшилтэй болсон. Урьд нь УБТЗ гээд ганцхан төмөр замтай байсан бол Монголын төмөр зам, тэгээд цаана нь хувийн хэвшлийн маш олон төмөр замуудтай болчихсон. Энэ төмөр замуудыг хооронд нь зохицуулах үнэ ханшийг нь зохицуулах, тээвэрлэлтийг зохицуулах, бие биедээ дарамт өгдөггүй байх гэсэн маш том зохион байгуулалтыг бол энэ агентлаг хийх ёстой юм. Энэ агентлаг хийх ёстой юм. Тийм болохоор би Зулпхар гишүүний хэлсэнчлэн кнопдоо хүрэхгүйгээр энийг дэмжиж өгөөч ээ.

Нэгдүгээрт, бол Төмөр замын тухай хуульд энэ чинь өөрөө суучихсан байгаа.

Хоёрдугаарт бол Монгол Улсын төмөр замын энэ том салбарыг цааш нь авч явахад энэ заалт чухал юм биш үү чухал юм биш үү. Бид ААН-үүдээ дэмжинэ гэж байгаа. Өнөөдөр бид нар ААН-үүдээ дэмжээд үндсэндээ хувийн хэвшил рүү хандсан ийм төмөр замтай болчихсон шүү дээ. Тэгэхээр бид одоо зохицуулалтыг нь маш өргөн хэмжээнд хийхгүй бол болохгүй болчихсон ийм зохицуулалттай. Урьд нь зөвхөн төрөөс нэг л төмөр замын асуудлуудыг зохицуулаад явдаг байсан.

Дээрээс нь хараад УБТЗ-ын хувь нийлүүлэгч гэдгээр нь бүх асуудлуудыг бариад явдаг байсан бол одоо тэр барьж болохоо больсон. Хувийн хэвшил рүү бид нар шилжсэн. Тэгээд тийм болохоор энэ зохицуулалтыг үндсэндээ хийх зайлшгүй шаардлага гарч байгаа юм шүү гэдгийг гишүүд минь та бүхэн бас болгооно уу гэж.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр байна шүү дээ ахиад бид бас хуулиа л ярих ёстой шүү дээ. Улсын Их Хурал ч гэсэн Улсын Их Хурлын ч гэсэн бас аливаа санал гаргахдаа хуулийн зөрчилгүй санал гаргаж байх ёстой. Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиараа агентлагийг шинээр байгуулах бол Засгийн газар л санал гаргах эрхтэй. Засгийн газраас гаргаад ирчихсэн санал дээр нь нэмэх нь Төмөр замын агентлаг гэдэг нэмэх эрх бол өнөөдөр хуулиар нээлттэй биш байна.

Хоёрдугаарт сүүлийн жилүүдэд Монголын төр салбар болгон хуулиар агентлаг байгуулдаг бүтэц орон тоо нэмдэг энэ байдал бол бүх салбарт бий болчихсон. Зарим салбар нь хуулиа шинэчлэн батлуулахдаа тийм агентлагтай байна гээд л батлуулчихдаг юм. Нэг жишээ нь өнөөдөр бас энэ төмөр замын агентлагийн асуудал явж байна. Агентлагийн тоо нэмэгдсэнээрээ улс хөгждөг бол манайх хөгжихийн дээдээр хөгжихсэн. Сүүлийн 12, 13-хан жилийн хугацаанд 20 хүрэхгүй агентлагтай байсан. Одоо 40 гаруй агентлагтай болчихсон явж байна. Ахиад энэ яамдын чиг үүргүүд давхцаж байгаа.

Өнөөдөр маш олон яамд дээр энэ процессын дахин инженерчлэлийн ажлыг зайлшгүй хийх шаардлага байгаа байхгүй юу. Яам нь бодлогын газартай бодлогын газар нь дотроо хэр хэлтэстэй яам дэргэдээ яг тэр чиглэлийг хариуцсан агентлагтай. Агентлаг нь дотроо бас ахиад газар хэлтэс албадаар үйл ажиллагааг дамжуулж явуулж байгаа юм. Нэг шийдвэр гаргахын тулд төр 6-аас 7 шат дамжлага дамжаад байгаа энэ процесс өнөөдрийн энэ олон агентлагууд бий болж байгаагаас үүдэлтэй шүү. Одоо хуулиар агентлаг байгуулдаг байсан бол өнөөдөр Улсын Их Хурлын тогтоолын заалтаар агентлаг байгуулдаг энэ хэлбэр рүү орох гэж байна. Тэгээд энэ бол бидний хариуцлагын асуудал юм гэж ингэж бас хэлэхийг хүсэж байна. Энэ дээр бас бодолтой хандах ёстой. Хуулийн зөрчилтэй юм уу сэтгэл хөөрөлтэй ямар нэгэн байдлаар хэдүүлээ бас энэ Засгийн газрын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөл үзүүлж байгаа байдал бас сөрөг талтай шүү. Сая одоо тэр үндэсний хороодыг татан буулгах ёстой л гээд үзээд л явж байна.

Өндөр хөгжилтэй улс оронд магадгүй цөөхөн тооны бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулдаг байж магадгүй. Манай улсад нэн шаардлагатай, хөгжүүлэх шаардлагатай салбарууд байж байх жишээтэй? Тийм ээ. Жишээ нь энэ барилгын орон сууцын салбарын хөгжлийг бодитой дэмжих, эрчим хүчний салбарын хөгжлийг бодитой дэмжих салбар хоорондын уялдааг сайжруулах чиглэл дээр тодорхой богино хугацаанд үндэсний хороодыг байгуулаад салбар дундын бодлогын

зохицуулалтыг хийж явах нь өөрөө ач холбогдолтой гэдэг юм. Үндэсний хороо байгуулагдахгүй болохоор Засгийн газар дээр салбарын сайд зөвхөн салбарынхаа асуудлыг л хариуцаад байдаг. Олон салбарын оролцоотойгоор шийдэгдэх асуудал дандаа хойно хаягддаг. Тэгэхээр Ерөнхий сайд Засгийн газрын зүгээс энэ үндэсний хороодыг тодорхой хугацаатайгаар байгуулж ажиллаж байгаа гэж ойлгож байгаа шүү дээ. Тэгэхээр бид бол ингээд Засгийн газрынхаа ажиллах боломжийг нь хязгаарлаад л тэгсэн мөртөө араас нь ташуурдаад л суугаад байдаг ийм парламент бас байж болохгүй ээ.

Тэгэхээр зарим зүйл дээр бас олон талаас нь гишүүд маань хандах ёстой шүү гэдгийг бас хэлье ээ. Баатаржавын Мөнхсоёл гишүүн үг хэлье.

Б.Мөнхсоёл: Уучлаарай. Миний энэ төхөөрөмж ажиллахгүй маш удлаа. Миний саналаар дутаад байх юу байх вэ гээд хараад оролцохгүй суугаад байлаа. Тэгээд чухал үе дээр бас саналаа оруулж чадахгүй харамсалтай явдлууд болоод байна. Энэ хүнийг нь дуудаад авчирлаа үнэхээрийн болохгүй байна. Өглөө Төсвийн байнгын хороон дээр байсан эхний 85 хувийн саналаа өгсөн. Сүүлийн 10-аас 15 хувьд төхөөрөмж ажиллаагүй бас. Тэгэхээр энэ нэг асуудал байна шүү. Төхөөрөмжтэй яаж ажиллахаа би бол үнэхээрийн л сайн мэднэ. Одоо бүх хуруугаа орууллаа. Тийм үнэхээрийн ажиллахгүй энэ хүн ирж туслах гэж байна тийм. Тэгэхээр нөгөө түрүүн жишээлбэл манай Сайнзориг гишүүний гаргасан санал дээр би.

Д.Амарбаясгалан: Мөнхсоёл гишүүн төхөөрөмж чинь зүгээр байна гээд хажууд чинь зогсож байгаа техникийн албаны хүн хэлж байх юм. Таны микрофоноор энэ хүн техникийн албаны ажилтныг үг хэлүүлэх боломжгүй учраас би өмнөөс нь энэ танхимд хэлсэн үгийг нь хэлчихье ээ гэж бодож байгаа юм. Тэгээд гишүүд маань хуруугаа уншуулаад санал хураалтдаа хариуцлагатай орчихоо.

Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн байр сууриа илэрхийлж үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ер нь бол маш их төр данхайж байгаа. Данхайж байгаа нэг хэлбэр бол өнөөдрийн байдлаар 18 яамтай сайд байна. Дээрээс нь 3 үндэсний хороотой сайд байж байна. Ингээд 21 яам гэсэн үг л дээ. Энэ 21 яамтай ажиллаж байна. Тэгээд дээрээс нь би нэг энэ 7 сараар би мэдээ авахад нийтдээ 38 агентлаг байсан. Засгийн газрын харьяа агентлаг 38. Гэтэл 2012-2016 онд АН засаг барьж байхад 16 яамтай байсан. 28 агентлагтай байсан.

Гэтэл эндээс хэтэрхий ингээд данхайгаад тэр хэрээрээ төрийн үйлчилгээ нь бүгдээрээ ерөөсөө ямар ч хүртээмжгүй ийм нөхцөл байдал руу очиж байгаа юм.

Тийм учраас ингээд сайд нар ирэх болгондоо тэр тухайн байгууллагадаа өөрийнхөө нэг тийм юугаар асуудлаар тийм агентлаг байгуулдаг, агентлаг байгуулангуутаа тэнд баахан орон тоо нэмдэг. Тэр хэрээр нь зардал нэмэгддэг ийм л зүйл замбараагүй болчихоод байгаа юм л даа. Тэгээд дээрээс нь тэр Сайнзориг гишүүний хэлээд байгаа тэр Үндэсний хороо бүр тамтгаа алдсан. Тэнд замбараагүй өндөр цалинтай, тэнд төрийн албаны шаардлага хангахгүй бүх хүмүүсээ аваачаад бүгдийг нь байрлуулчихсан ийм л нөхцөл байдалтай байгаа шүү дээ. Энэ болгоныг чинь бүгдийг нь тэгээд тэр чинь доошоо тэгээд бүгдээрээ сум хүртлээ бүгдээрээ, албан хаагч бүгдийг нь нэмээд ингээд явчхаж байгаа юм. Тэгээд энэ хэрээрээ төрийн алба данхайгаад өөрөөр хэлбэл 130-аад мянган төрийн албан хаагчтай

байсан бол өнөөдөр мянга билүү, 220 мянга ч билүү тийм болчхоод байна шүү дээ. Наймхан жилийн дотор ингэж замбараагүй өсгөж байна. Өөрөөр хэлбэл Их Хурлын гишүүд яамдын сайд нар өөрсдийнхөө сонгуульд явсан тэр бүх хүмүүсийг ажилтай албатай болгох тэр уралдаанд л бүгдээрээ оролцож байна шүү дээ.

Тийм учраас энэ тэгээд дээрээс нь Үндсэн хуулийн бус аргаар энэ гишүүн агентлаг байгуулах тухай санал оруулж ирж байна арай хэтэрч байна.

Тийм учраас энэ дээр анхааралтай байгаарай. Дээрээс нь манай энэ АН-ын гишүүд бол и сайд хийж байгаа хүмүүс агентлаг байгуулах тухай асуудал ер нь ярихгүй л байгаа шүү дээ. Ер нь төрийн албыг цомхон байлгах тухай л яриад байгаа. Гэтэл одоо Ардын намаас сонгогдсон нөхдүүд тэгээд л янз янзын гишүүдээр дамжуулаад агентлаг байгуулах тухай асуудлыг оруулж ирээд л төр данхайлгаад л түмний мөнгийг үргүй зарцуулах тухай яриад л явах юм даа.

Д.Амарбаясгалан: Баярмаа гишүүн горимын санал гаргах юм байна тиймээ.

Горимын санал. Улсын Их Хурлын гишүүнээс зөвхөн хэлэлцэж байгаа асуудлаар болон тухайн асуудлыг хэлэлцэх дараалал, журмын талаар гаргана гэж байгаа. Тэрийг анхаарч хандъя. Жудгийн Баярмаа гишүүнд микрофон өгье. Горимын санал.

Ж.Баярмаа: Тухайн хэлэлцэж байгаа асуудал их чухал учраас саналаа алдахгүйн тулд горимын санал юу гэж гаргаж байна гэвэл юу гэх вэ гараа өргөж өгмөөр байна. Тэгээд манай гишүүд ажилладаггүй шүү дээ. Бүгд мэдэж байгаа шүү дээ. Ажиллахгүй шалтгаан яах вэ 2, 3 байж болно. Эсвэл зарим нь яараад түрүүлж өгөх эсвэл хоцрох эсвэл энэ төхөөрөмж үнэхээр зөв дараад байхад ажилладаггүй. Тэр хуруу нь буруу дутуу орсон эсэхийг мэдэхгүй. Энүүгээр бид нар бүгд ажилласангүй гээд л яриад сууж байна. Тэгээд дараа нь эндээс чинь болж ямар асуудал үүсэж байна гэхээр зарим нь санаа зовоод айгаад тэр болгон гараа өргөөд л горимын санал гаргаад байхаасаа ч эвгүйцэх юм. Тэр болгон өө би дэмжиж байгаа шүү гээд ингээд байхаасаа сүүлдээ айгаад эхэлж байгаа байхгүй юу. Бөөн хэл ам нэмэх татлахын нэмэр гээд юу болж байна гэвэл сүүлдээ ингээд саналаа яг үнэн сэтгэлээсээ өгөх боломж нь хаагдчихаж байгаа байхгүй юу. Айж байна, ичиж байна хэл ам татлахын нэмэр гээд. Тэгээд л сая яг Мөнхсоёл гишүүн хэллээ шүү дээ. Тэрэн дээр нэгэнт дэмжигдэж байгаа учир одоо яах вэ гээд өнгөрөөх нэг үе байна. Яг ингээд 50, 50 болж байгаа үед бол хариуцлагатай ингэх үе байна. Энэ чинь аягүй тийм олон нюансны зүйлүүд байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ингээд битгий төхөөрөмжөө ажиллуулж чадаагүйгээс болоод элдэв асуудал гаргаад бай гэж дарамталмааргүй байна гишүүдийг. Ингээд дарамтлаад байхаар чинь гишүүд айж эхэлж байгаа байхгүй юу ичиж эхэлж байгаа байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Баярмаа гишүүн 1 дүгээрт Улсын Их Хурлын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа. Төхөөрөмжөөр олгож өгч байгаа санал гишүүн өөрөө хариуцлагатай тохиолдолд хэвийн ажиллаж байна гэдгийг тагнуулын байгууллага болон холбогдох мэргэжлийн байгууллага дүгнэлт гаргаад бас ирүүлсэн байгаа.

Тэгэхээр хувь гишүүний асуудлыг Улсын Их Хурлын нийт үйл ажиллагаатай холбохгүй байхыг танаас хүсье. Би таныг бас ойлгож байна. Та ихэнх санал дээр дандаа эсрэг байр суурь илэрхийлдэг буюу санал өгөх үйл ажиллагаанд идэвхтэй

оролцдоггүй гишүүдийн нэг байхгүй юу. Тэгэхээр зарим нэг зүйл дээр дэмжих гээд санал өгөхдөө буруу зөрүү дараад байгаа болов уу гэж бодож байна.

Тэгэхээр эсрэг байр суурьтай байлаа гээд төхөөрөмжтэйгөө харьцахгүй суугаад байхаас илүүтэйгээр төхөөрөмжтэйгөө харьцаад үгүй зөвшөөрөөгүй гэдэг зүйлийг нь дараад байх бүрэн боломжтой байдаг юм шүү. Тэгэхээр ер нь энэ төхөөрөмжтэй харьцах зүйл дадлын л асуудал байна. Зарим гишүүд нь ерөөсөө 2 гуравхан секундийн дотор төхөөрөмжтэйгөө харьцаж байна. Зарим гишүүд нь 15 секундийн хугацаанд санал өгөхдөө 2-оос 3 удаа алдаа гарчхаад эргэж дараад саналаа өгчхөж байгаа тэр боломж байна. Би бас өөрөө эндээ туршиж үзээд л суугаад байна. Тэгэхээр бүгдээрээ өөрсдөөс хамаарах алдааг бусдад буюу Улсын Их Хурлын нийт үйл ажиллагаатай холбохгүй байхыг хүсье ээ.

Ингээд санал хураалт явуулна.

Санал хураалт.

67.8 хувиар буюу 78 гишүүн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжлээ. Юу

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

17.36 цагт

Дараагийн асуудалд оръё. [Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хийнэ ээ.](#)

Төслүүдийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн танилцуулна.

Индэрт урьж байна.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 1 дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр бүх Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 10, 11-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын даргын 2024 оны 303 дугаар захирамжаар дээрх хуулийн төслүүдийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэнгээр ахлуулан Улсын Их Хурлын нэр бүхий 26 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд ажлын хэсэг нь Хөрөнгө оруулалт, урсгал зардал Засгийн газрын тусгай сан, төрийн өмчит ААН, гадаад зээл тусламж болон төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийг судалж санал гаргах үүрэг бүхий дэд ажлын хэсгүүдэд хуваагдан ажиллаж дараах саналуудыг нэгтгэн гаргасан байна аа.

1.Гадаад зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг эрэмбэлж эдийн засгийн үр ашигтай дэд бүтцийн хөгжлийг дэмжих төслүүдийг санхүүжүүлэх нь зүйтэй бөгөөд санхүүжиж байгаа төслүүдийн нэр, хөрөнгийн дүн хэрэгжих хугацаа зэрэг мэдээллийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн хавсралтад тусгаж байх.

Мөн төрийн албаны бүтэц болон төрийн албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл урамшилтай холбоотой асуудлыг судалж төрийн албан хаагчдын орон тоог нэмэгдүүлэхгүй байх.

2.Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл арга хэмжээнүүдийн төсөвт өртөг нэмэгдэж байгаа шалтгааныг тодруулах, хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлаас байгуулах.

Хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгагдсан 2025, 2026 онд ашиглалтад орох барилга байгууламжуудын ашиглалтын зардал, үйлчлүүлэгчийн тоо, үр дүнгээс хамааран хувьчлах, төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах, түрээслэх гэр бүлийн хөгжлийн төв, Хүний хөгжлийн ордон, Хүүхэд, залуучуудын хөгжлийн ордон, Хүүхэд хамгааллын хөгжлийн төв, Ахмадын өргөө, Ахмадын хөгжлийн төв зэрэг барилга байгууламжуудын хэрэгцээ, шаардлага, давхардлыг судалж, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах.

3. 2025 оны төсвийн төсөлд Засгийн газрын тусгай сангийн хуулиар улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тусгаагүй зарим сангуудад санхүүжилт төлөвлөсөн. Мөн өмнөх онуудад зарим тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлсэн, хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан, зарцуулсан асуудлаар Үндэсний аудитын тайланд тусгагдаж хязгаарлалттай дүгнэлт гаргасан байгааг анхаарч Улсын Их Хурлын хурлаас Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн биелэлт хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх санал, дүгнэлтийг танилцуулах эсхүл холбогдох сонсголыг зохион байгуулах.

4.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага 2.7 их наяд төгрөгт хүрснээс 92.7 хувийг төрийн өмчит, 7.3 хувийг хур орон нутгийн өмчит ААН-

үүдийн авлага эзэлж байгааг бууруулах арга хэмжээ авч төрийн өмчийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн хооронд зээл олгож буй үйл ажиллагааг таслан зогсоож, үүссэн өр авлагын асуудлыг цэгцлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх нь зүйтэй зэрэг саналуудыг ажлын хэсгээс гаргасан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг бүх Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо 2025 оны ар 12 дугаар сарын 9, 10-ны өдрүүдэд эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж хуулийн төслүүдийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо Төсвийн байнгын хороонд ирүүлсэн.

Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.6 дахь хэсэгт заасны дагуу ажлын хэсэг, бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, Төсвийн байнгын хорооны гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж санал хураалт явуулан, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн санал дүгнэлтийг бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Ирэх оны төсвийн хуулийг иргэд илтэд эсэргүүцэн Ерөнхийлөгч бүхэлд нь хориг тавьсан явдал нь Засгийн газар иргэдийнхээ үг, Улсын Их Хурлын гишүүдийнхээ санал сайжруулалтыг үл тоож, төсвөө задлуулахгүй, гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг тусгахгүй гэж хэтэрхий мугуйд хүч түрсэн байдлаар 2025 оны төсвийн хэлэлцүүлэгт хандсаны үр дагавар юм аа. Ийм ч учраас Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн зүгээс Ерөнхийлөгчийн хоригийг дэмжин хүлээн авсан бөгөөд цаг хугацаа тулсан энэ өдрүүдэд төсвийн хэлэлцүүлгийг аль болох үр дүнтэй явуулахад бүхий л талаар анхааран ажиллаж байна аа. Гэвч зайлшгүй анхаарах шаардлагатай асуудлууд олон байгааг дурдахаас бас аргагүй ээ. 2025 оны батлагдсан төсвийг тодорхой хэмжээнд зардлыг бууруулна. Тэнцлийг сайжруулна.

Засгийн газраас өргөн барьсан боловч өмнөх дүгнэлтэд бидний дурдаж байсанчлан ирэх оны төсөв Монголын түүхэн дэх хамгийн өндөр зардалтай түүнийг дагаад төрийн хамгийн том бүтэцтэй хамгийн олон яам, нэгжтэй хамгийн олон төрийн албан хаагчтай байх нөхцөлийг бүрдүүлсэн төсөв болж байна аа. Энэ зөвхөн энэ удаагийн та бидний асуудал биш ээ. Ирэх жилүүдэд ч ийм том данхар байх нь Засгийн газар, Улсын Их Хурлын, Монгол Улсын асуудал хэвээр байх болно. Энэ Монголын төрийн төр сүүлийн 8 жилд хэмнэлт үр ашиг гэх ойлголтыг мартан халамж руу чиглэсэн урсгал зардлыг хэт тэлсний гор юм аа. Ингэж бодлогогүйгээр сонгуулийн санал авах зорилгоор замбараагүй нэмэгдсэн урсгал зардал хяналтаас гарч дэд бүтцийн болон хөгжлийн хөрөнгө оруулалт хийх боломжгүй хавханд Монгол Улсыг оруулсан. Батлагдсан төсвийн нийт зардлын 73 хувь нь урсгал зардал, 27 хувь нь хөрөнгө оруулалтын зардал байхад төсвийн хөрөнгө оруулалтын бууралтын 30 хувийг урсгал зардлаас, эсрэгээр нь 70 хувийг хөрөнгө оруулалтын зардлаас хассан нь төсөв үр ашигтай байх зарчимтай нийцэхгүй байгааг харуулж байна аа. Ийм учраас Засгийн газрын нэн яаралтай төрийн бүтцийг нь оновчилъё гэж төр хэрэгцээгүй чиг үүргээсээ татгалзаж, бүтэц зардлын иж бүрэн реформ хийх ёстойг Улсын Их Хурал дахь АН-ын зүгээс бас сануулж байна аа.

Төсвийн тухай хуульд төсвийг боловсруулахдаа тухайн жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх шаардлагыг тусгайлан заасан байдаг. Гэтэл энэ онд 4 дэх удаагаа төсвийн хязгаарыг төсвийн төсөлд тодотголд нийцүүлэн өөрчлөхөөр оруулж ирж байгаа нь төсвийн төлөвлөлт маш хариуцлагагүй байгааг харуулж байна аа. Ирэх онд эдийн засгийн өсөлтийг 8 хувь, инфляцын таамаглалыг 7.2 байхаар тооцсон ч нэрлэсэн дүнгээрх ДНБ-ний өсөлтийг 20 гаруй хувиар гэх мэтээр уялдаа, тоо, уялдаа төсөөлөл, уялдаа муутай төсөөлөл тооцоолол байгааг анхаарахыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлтдээ ч бас тун тодорхой дурджээ. Ингэхээр батлагдсан төсөв хэрэгжээд эхэлсний дараа ч 2025 оны төсвийн хүрээг хэд дахин хэлэлцэхийг бид бас таашгүй ээ. Энэ бол хүрээ хязгаар таамаглалаа эхэлж тавих ёстой байтал түүнийгээ төлөвлөсөн төсөвтөө тохируулан өөрчилдөг болсны үр дагавар.

2018 онд татварын орлого 8.2 их наяд байсан ирэх жил 31.5 их наяд хүрч бараг 4 дахин өсөж төсвийн орлогын 95 хувийг татварын орлогоор бүрдүүлэхээр төсөөлжээ. Ингэхдээ 2018 оны орлогын татвар 2018 оноос орлогын татвар 5 дахин, НДШ 4 дахин, нэмэгдсэн өртгийн албан татвар 3.5 дахин нэмэгдэхээр байна аа. Цар тахал цаг үеийн хямралт байдлыг арайхийн туулсан бизнесийнхэн хаанаа л торгуулийн суманд зүтгэж ачааны хүндийг үүрсээр байгааг энэхүү тоо баримтууд та бидэнд харуулж байна аа. Гэтэл энэ цаг үеүдэд төсөв дэх татварын бус орлогын эзлэх жин тасралтгүй буурсаар 2018 оны төсвийн орлогын 10 хувийг бүрдүүлж байсан нь одоо 2 дахин буурчээ. Энэ 7 жилийн татварын орлого 100 их наядаар хэмжигдэж байхад ТӨХК-удын төсөвт төвлөрүүлсэн ноогдол ашиг үүнээс 100 дахин бага буюу дөнгөж 1 их наядаар хэмжигдэж буйг анхаарахгүй байх аргагүй өнцөг юм аа.

Иймд төрийн өмчийн талаарх баримтлах ТӨК-удын засаглалыг сайжруулах, нээлттэй болгох, хувьчлах зэрэг ажлуудыг Засгийн газраас цаг алдалгүй оруулж ирж хувийн хэвшлийнхний үүрч буй ачаанаас хөнгөлөх шаардлага байгааг өнгөрсөн төсвийн тоо баримтууд бидэнд харуулж байна аа. Энэ парламентын тэргүүлэх зорилтуудын нэг нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. Гэтэл уг хандлага руу чиглэсэн хөрөнгө оруулалт тун бага туссан төдийгүй орон нутгийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтыг тодотголоор үлэмж хэмжээгээр бууруулсан атлаа

Улаанбаатар хотын төсөв асар их хэмжээгээр нэмэгдсэн хэвээр үлджээ. Нийслэл хотод тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэхэд хөрөнгө оруулалтууд шаардлагатай нь үнэн хэдий ч аймаг, нийслэлүүдэд эрх тэгш, шударга хандах зарчмыг эргэн сануулахад бас хүргэж байна аа. Хотод ч амьдрал бий гэх хандлага бодлого хойшид ч үргэлжлэн хөдөө орон нутаг, аймаг сумд ХАА-н асуудлууд хөгжлөөс жийгдсэн хандлага цаашид цаашид ч үргэлжлэхээр байгааг Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс сануулж байна аа.

Төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлыг нөхөх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан АМНАТ-ийн орлогын 65 хүртэл хувийг ирээдүйн өв санд хуримтлуулах ёстойг 2025 онд 40 хувь болгон бууруулах санал оруулж ирсэн нь ирээдүйгээсээ хулгайлан өнөөдөр зарцуулах гэсэн тун хариуцлагагүй сэдэл бас болзошгүй алдагдлыг нууж байгаа тал еэвэнгийн үл үлгэр шиг арга заль гэж бас үзэхээс өөр аргагүй ээ. Мөн экспортын гол бүтээгдэхүүний үнэ тэр тусмаа нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ 105 ам.доллар байгаа нь ирэх оны төсвийн төсөөлөл өөдрөг, орлого хэт өндөр байгааг харуулж байна аа. Энэ нь аман дээрээ алдагдалгүй гэж байж ачир дээрээ нуусан алдагдлууд буйг бас илэрхийлнэ ээ. Төсвийн төслийг дагуулан дагалдах хуулиуд нэрээр хуудуутай хууль өөрчлөлт оруулж ирдэг жишиг энэ удаад ч бас давтагдаж байна. Засгийн газар 4 их наяд хүртэлх өр тавих өндөр төсөвтэй агентлаг байгуулах, ирээдүйн өв сангийн хөрөнгийг ашиглах гэх мэт эрсдэлтэй анхаарууштай хуулийн төсөл дагалдуулан шургуулж байгааг АН-ын бүлэг бас энэ дээр буруушаан хандаж байна аа. Ерөнхийлөгчийн хоригтоо дурдсан үндэслэлүүд иргэд олон нийтийн шаардаж буй шаардлагыг анхааран 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд амласан амлалт тэр тусмаа ДНБ-д эзлэх төсвийн хэмжээг 25 хувьд хүргэхийн тулд дахиад ч зардлын бууралт төсвийн өгөөж үр ашиг руу анхаарна гэх мэт олон ажлууд та бидний өмнө байгааг Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн бүлгийн зүгээс бас дахин анхааруулан сануулж байна аа.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн санал нь энэ хуулийн 71.7.2, 71.7.3-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний асуудал хариуцсан нэгжийн дүгнэлтийг хэлтсийн дарга Даваасүрэнгийн Эрдэнэсамбуу танилцуулна аа. Ажлын хэсгийн 1 дүгээр индэрт урьж байна.

Я.Эрдэнэсамбуу: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж олонхын дэмжлэг авсан саналууд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.13 дахь заалтын дагуу тус хуулийн 71.7.2, 71.7.3-д заасан шаардлагыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж дүгнэлтийг хүргүүлж байна аа. Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийн үеэр хөрөнгө оруулалтын 11 төсөл арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 46000000008.4 сая төгрөгөөр бууруулж харин хөрөнгө оруулалтын

12 төсөл арга хэмжээний 25 онд санхүүжих дүнг 55000000771.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хөрөнгийн зардал 9000000763.1 сая төгрөгөөр өсөхөөр байна аа.

Урсгал зардлыг 63 тэрбум 400 сая төгрөгөөр нэмэгдүүлж мөн зардлыг 73000000163.3 сая төгрөгөөр бууруулах замаар урсгал зардлыг 9000000763.3 сая төгрөгөөр бууруулах зохицуулалтын саналууд гарсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6-д заасан зарчимд нийцэж төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг нэмэгдүүлэхгүй байх нөхцөлийг хангасан байна аа. Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед олонхын дэмжлэг авсан саналууд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.7.2-т заасан Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх шаардлагыг хангасан байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Дэлэгийн Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Ядамын Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний Аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүй Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга, Лувсандоржийн Соноор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга.

Д.Амарбаясгалан: Төсвийн 2 дугаар хэлэлцүүлэг явагдаж байгаа зарчмын зөрүүтэй 55 санал гарсан байгаа. Тэгэхээр гишүүд зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулж л дэмжсэн, дэмжээгүй байр суурь, санал гаргасан гишүүн ажлын хэсэг тайлбар хийх байдлаар үг хэлэх боломжтой гэдгийг бас та бүхэндээ сануулж хэлье.

Хоёрт нь би түрүүн бас нэг зүйлийг дутуу хэлчхэж гишүүд ээ одоо түрүүн Баярмаа гишүүн төхөөрөмж ажиллахгүй байна гэсэн мөртөө ажиллахгүй байгаа төхөөрөмжөөрөө өөрөө яриад суугаад байна шүү дээ. Тэгэхээр чинь тэр чинь нөгөө хурууныхаа хээг уншуулаад ярих боломж олдож байна гэдэг талаас нь бас харах ёстой. Төхөөрөмж ажиллахгүй бол ярьж ч болохгүй гэсэн үг шүү дээ. Тэгэхээр санал өгөх процесс дээрээ бас тийм байдлаар төхөөрөмж рүүгээ буруу өгч ярих зохимжгүй байна шүү. Би бас сая техникийн албаныхнаас мэдээлэл авлаа.

Тэгэхээр төхөөрөмжтэйгөө зөв харьцаж сурцгаая. Уриалга дэвшүүлье. Жоохон шүүмжлээд хэлэхээр загналаа, дарамталлаа гээд болохгүй юм шиг байна. Уриалга гаргаж хэлж байгаа шүү. Ингээд Төсвийн байнгын хорооноос нэгтгэн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана.

Нийт 55 санал байгаа. Гаргасан саналаа тайлбарлан үг хэлж болно. 18 цаг болж байгаа юм байна.

Тэгэхээр өнөөдрийн хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дуустал өнөөдрийн чуулганыг үргэлжлүүлэе гэсэн саналтай байна аа. Татгалзаж байгаа гишүүн байна уу? Алга байна. Чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүллээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.9-д Төсвийн байнгын хороо энэ хуулийн 71.6-д заасан болон Төсвийн байнгын хорооны гишүүд түүнчлэн төсөвтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Төрийн аудитын төв байгууллага, нам, эвслийн бүлгээс гаргасан санал нэг бүрийг хэлэлцэж ил санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан аваагүйгээр нь бүлэглэн томьёолж энэ хуулийн 71.13-д заасан дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэсэн байгаа. Ингээд зарчмын зөрүүтэй 55 санал орж ирсэн байна. Мөн хуулийн 71.10-д төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийн шатанд гаргасан төсвийн санал энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй эс үгүй бол хууль, тогтоомж зөрчсөн гэж үзвэл энэ талаар Засгийн газар нэгдсэн хуралдаанд мэдэгдэл хийж болно гэж байгаа юм. Мөн хуулийн 71.11-д нэгдсэн хуралдаанаар төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлэг явуулах үед Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага гаргасан саналаа тайлбарлан үг хэлж болно. Мөн хуулийн 71.12-т нэгдсэн хуралдаан энэ хуулийн 71-ийн есөд заасан санал төсөл бүрээр ил санал хураалт явуулна гэж тус тус заасан.

Ингээд зарчмын зөрүүтэй саналаар санал хураалтыг явуулж эхэлнэ. Гишүүд танхимд цугларахыг хүсэж байна.

Нэгдсэн хуралдааны 2 дахь хэлэлцүүлэгт.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал

Нэг.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр зохицуулалт хийх санал:

1.Урсгал зардал бууруулах санал:

Д.Амарбаясгалан: 1.1.Дараах байгууллагын 2025 оны төсвийн жилд нэмэгдэхээр тооцсон шинэ орон тоог тодорхой хувиар бууруулахтай холбоотойгоор тухайн байгууллагуудын урсгал зардлыг доор дурдсан хэмжээгээр бууруулах. Үүнд:

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 23 орон тоог хасаж, урсгал зардлыг **1,484.1 сая** төгрөгөөр;

- Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 277 орон тоог хасаж, урсгал зардлыг **7,738.1 сая** төгрөгөөр;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 224 орон тоог хасаж, урсгал зардлыг **5,901.9 сая** төгрөгөөр;
- Дотоодын цэргийн байгууллагын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 245 орон тоог хасаж, урсгал зардлыг **5,899.9 сая** төгрөгөөр;
- Дотоод хэргийн их сургуулийн 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 107 орон тоог хасаж, урсгал зардлыг **2,720.5 сая** төгрөгөөр;
- Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 17 орон тоог хасаж, урсгал зардлыг **1,238.1 сая** төгрөгөөр;
- Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 29 орон тоог хасаж, урсгал зардлыг **1,603.5 сая** төгрөгөөр;
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 185 орон тоог хасаж, урсгал зардлын ангилал дахь цалин хөлс, шимтгэлийн зардлыг **8,250.1 сая** төгрөгөөр, тавилга, багаж, техник хэрэгслийн зардлыг **948.8 сая** төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг **650.0 сая** төгрөгөөр, нийт **9,848.9 сая** төгрөгөөр;
- Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 29 орон тоог хасаж, урсгал зардлыг **1,095.2 сая** төгрөгөөр;
- МОНЦАМЭ агентлагийн 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 3 орон тоог хасаж, урсгал зардлыг **82.9 сая** төгрөгөөр;
- Улсын Их Хурлын Тамгын газрын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 25 орон тоог хасаж, урсгал зардлыг **2,142.3 сая** төгрөгөөр;
- Шүүхийн сахилгын хорооны даргын 2025 оны төсвийн жилд шинээр нэмэгдэх 9 орон тоог хасаж, урсгал зардлыг **309.4 сая** төгрөгөөр, нийт **40,064.7 сая** төгрөгөөр бууруулах.

1.2. Дараах байгууллагын 2025 оны төсвийн жилд зарим урсгал зардлыг доор дурдсан хэмжээгээр бууруулах. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь татаасыг **3,000.0 сая** төгрөгөөр;
- “Эрчим хүчний реформын үндэсний хороо”-ны мэдээлэл, сурталчилгааны зардлыг **9,000.0 сая** төгрөгөөр;
- Бүх төсөвт байгууллагын түлш халаалтын зардлыг **11,500.0 сая** төгрөгөөр;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцад тусгагдсан Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх хөтөлбөрийн зардлыг **2,000.0 сая** төгрөгөөр тус тус бууруулах.

1.3. Засгийн газрын тусгай сангийн зардал бууруулах санал:

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад тусгагдсан Архидан согтууруулахтай тэмцэх сангийн санхүүжилтийг **6,900.0 сая** төгрөгөөр бууруулах;
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцад тусгагдсан Байгаль орчин, уур амьсгалын сангийн санхүүжилтийг **698.5 сая** төгрөгөөр тус тус бууруулах.

2.Зардал нэмэгдүүлэх санал.

2.1.Хавдрын эмнэлгийн зориулалтаар ашиглах объектыг лизингээр авах эхний удаагийн төлбөрт **17,000.0 сая** төгрөг, тус эмнэлгийн тоног төхөөрөмжийн зардалд **6,881.7 сая** төгрөг, нийт **23,881.7 сая** төгрөгөөр Эрүүл мэндийн сайдын төсвийн зардлыг нэмэгдүүлэх;

2.2.Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд зориулж **31,400.0 сая** төгрөгөөр Боловсролын сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх;

2.3.Цэцэрлэг, 3 ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн байрны түрээсийн зардалд зориулж **10,000.0 сая** төгрөгөөр Боловсролын сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх;

2.4.Төслийн 2 дугаар хавсралтын XXII.2.3.Хавдар судлалын үндэсний төвийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 5,762.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,881.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **2,881.4 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.5.Эрчим хүчний бодлогын шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх зориулалтаар Засгийн газрын Хэрэг эрхлэх сайдын төсвийн багцад **5,000.0 сая** төгрөг нэмж тусгах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Золжаргал, Р.Сэддорж, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Т.Аубакир, Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ, Ж.Баярмаа, Д.Ганмаа, Х.Ганхуяг, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан, Б.Заяабал, М.Мандхай, Ц.Мөнхбат, Л.Мөнхтулга, М.Нарантуяа-Нара, Р.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, Л.Соронзонболд, Б.Түвшин, Г.Уянгахишиг, С.Цэнгүүн, Б.Энхбаяр, Л.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/

Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналаар. Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн Горимын санал гэсэн үү? Горимын санал.

Ч.Лодойсамбуу: Энийг дахиад дэгийн хуулийн 71.14-ийг үндэслээд дахиж боловсруулах гүйцээн боловсруулах чиглэл өгөхийг хүсэж байна. Яагаад гэхээр энэ ингээд нэг санал хураалтаар 22 асуудлыг багцлаад шийдэх гээд байгаа байхгүй юу. Энэ дотор чинь дэмжиж болох санал дэмжмээргүй саналууд бас байна. Энийг тус тусад нь бас хэлэлцэж, ярилцаж санал хураалтыг явуулах хэрэгтэй байна.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлье.

П.Сайнзориг: Ингээд бөөндөө байгаа ингээд хууль сахиулах байгууллагаас нэлээн хасаж байна аа. Яах вэ зүгээр Дотоодын цэргийн 2025 онд шинээр нэмэгдэх

орон тоо гээд зүгээр жишээ авч ярья л даа. Энэ аймгуудын ундны усны аюулгүй байдлын чинь хамгаалалтын асуудал ингээд сулраад л явчхаж байгаа юм. Зүүн аймаг тэр чигтээ аймгаараа ундны ус нь асуудалд орж байсан. Кэйстэй шүү бид нар. Тэгээд ингээд хүн амынхаа эрүүл аюулгүй амьдралын яг энэ баталгаа болсон зарим юмнууд дээрээсээ ерөнхийдөө асчхаж байна л даа. Мэдээж ойлгож байгаа. Тэгээд уг нь хууль сахиулах салбар, эрүүл мэнд, боловсролтойгоо нэг их оролцохгүйгээр бусад танаж, хэмнэж, тэвчиж болох зардлуудтайгаа л уг нь ярих байсан юм аа. Гэтэл энэ дунд бас хөндлөн юм орж ирж байгаа байхгүй юу.

Хавдрын эмнэлэг авна аа. Эхний жилийн түрээс нь 17 тэрбум гэж байгаа юм. Яаж тооцоолол гаргасан юм хэдэн тэрбумын барилгыг ингэж 5 жил та нар хувааж авах гэж байгаа юм. Энэ үнэлгээ энэ тэрийг хэн тогтоочихсон юм, ямар ашиг сонирхол яваад байгаа юм? Ингэж иргэдийн хавдрын асуудал хүндэрчихсэн байгаа гэдэг энэ шалтгаанаар төсвийн ийм зүйлүүд дээр буруу жишиг тогтоож болох юм уу? Тэгээд 1 их сүрхий юм ярьж байсан хүмүүс чинь эргээд л бид нар чинь зарчмаа алдах гээд байна шүү дээ. Тэгэхээр энийгээ бас анхаармаар байгаа юм уг нь. Тэгээд энэ ХЗДХ-ийн сайдын төсвийн багцад байгаа архидан согтууруулах энэ сангаас 6.9 тэрбум энэ чинь хуультай байхгүй юу. Бүх нийтийн үүргийн сан гэдэг шиг архи үйлдвэрлэж байгаа компаниуд нь өөрөө мөнгөө өгөөд энэ хууль бус архидан согтууруулах үйлдвэрлэлтэй тэмцэх, архидалттай тэмцэх, архины донтой хүмүүсийг эмчлэх, мансууруулах донтой хүмүүсийг эмчлэх дэлгэцийн донтой хүүхдүүдийг залуучуудыг эмчлэх зүйлд л зөвхөн зориулъя гээд өөрөө архи үйлдвэрлэж байгаа компаниуд нийгмийн хариуцлагын хүрээндээ оруулдаг мөнгийг танаж байгаа байхгүй юу. Энэ чинь болохгүй шүү дээ. Тэгээд бүх нийтийн үүргийн сантай яг ялгаа байхгүй. Яг ялгаа байхгүй. Хувийн хэвшил нь өөрөө мөнгөө өгөөд бид хэдийн энэ өгч байгаа 300 литр тутамд өгч байгаа 300 төгрөг ийм зүйлд зарцуулаач ээ. Тэр мансууруулах бодистой архины донтой тэр дэлгэцийн донтой хүмүүсийг эмчлэх эмнэлгээ барь гэдэг зүйлийг шийдэж өгсөн байхгүй юу. Тэгээд эндээс нь бүгдийг нь ингээд танах гэж байна.

Ингээд цаашилбал ерөнхийдөө бүх төсөвт байгууллагын түлш, халаалтын зардал, түлш гэхэд ингээд Цагдаагийн байгууллага дуудлагадаа дарагдаад очиж чадахгүй. Тэгээд энэ салбар гэмт хэргийн зөрчил эргээд хүний эрх зөрчигдөх байдал ер нь зүгээр шал дээр унана, харамсалтай байна. Одоо энэ төрийн хэмнэлтийн хуулиар энэ шатахууны зардал нь хүрэхгүй, дуудлагадаа очиж чадахгүй, шүүх шинжилгээний байгууллага, цагдаагийн байгууллага нэг машиндаа суугаад сүүлдээ.

Д.Амарбаясгалан: Уучлаарай гишүүд ийм байгаа шүү. Дэгийн тухай хуулийн 71.10-д нэгдсэн хуралдаан төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлэг явуулах үед Байнгын хороо, нам, эвслийн бүлэг гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага гаргасан саналаа тайлбарлан үг хэлж болно гэдэг ганц заалттай байгаа Дэгийн тухай хууль. Бусад гишүүд үг хэлэх боломжгүй юм байна. Тэгэхээр Байнгын хороо, санал гаргасан гишүүд тайлбарлаж үг хэлнэ ээ л гэсэн үг.

Лодойсамбуу гишүүний гаргасан горимын саналд Их хурлын ЕНБД мэдээлэл өгье.

Б.Баасандорж: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Баасандорж Лодойсамбуу гишүүний асуултад хариулъя аа. Энэ Лодойсамбуу гишүүнээ ийм байгаа юм аа. Дэгийн тухай хуулийн 71.8 дээр нам, эвслийн бүлэг гишүүн, Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага тодорхой төсөл хөтөлбөр арга

хэмжээний зардал нэмэгдүүлэх санал гаргасан бол бусад төсөл хөтөлбөр арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулах, түүнчлэн татвар бууруулах санал гаргасан бол мөн хэмжээгээр зардал бууруулах саналыг хамтад нь гэж байгаа шүү. Хамтад нь гаргаж нэг санал болгон санал хураалт явуулах бөгөөд саналуудыг багцлан хурааж болно гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл шинэ төсвийн хууль, шинэ Дэгийн хуулиар нэмэгдүүлсэн бол бууруулах санал нь хамтдаа явах ёстой, бууруулсан нэмэгдүүлэх санал нь хамтдаа явах ёстой юм. Яг энэ зарчмынхаа дагуу чуулганы нэгдсэн хуралдаанд ингээд багцлаад хамтад нь оруулж ирж байгаа шүү.

Д.Амарбаясгалан: Баасанжаргал гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн горимын санал уу?

Х.Баасанжаргал: Горимын санал. Би Лодойсамбуу гишүүнтэй санал нэг байна. Сая Баасандорж даргын хэлсэн тайлбарыг сонсохоор багцалж санал хурааж болно гэхээр бас салгаж болохоор байгаа байхгүй юу. Нэг дэх горимын санал.

Хоёр дахь горимын санал одоо жишээ нь Төсвийн байнгын хороогоор дан энэ хуулийн байгууллагуудын төсвийг ингээд танаад ороод ирж байгаа. Энэ ХЗБХ-оор бас ордоггүй юм уу тэгж байж ийшээ ордоггүй юм уу? Ийм 2 горимын санал.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Гишүүддээ бас энэ 2025 оны шинэ төсөвтэй холбогдуулаад бас товчхон нэг мэдээллийг өгье гэж бодож байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригтой уялдуулж Засгийн газар өнгөрсөн 7 хоногт шинэ төсвөө өргөн барьсан. Бид бүхний хувьд энэ 5 дахь өдөр өнгөрсөн чуулганаар энэ төсвийн талаарх хэлэлцүүлгийг хийсний дараа бол ажлын хэсгийг байгуулсан. Ингээд өнгөрсөн 4 хоногийн хугацаанд үндсэндээ 26 гишүүнтэй ажлын хэсэг бол 6 чиглэлээр ажиллалаа. 6 чиглэлээр ажиллалаа. Манай 5 намын төлөөлөл болсон бүх гишүүд маань орсон. Үндсэндээ энэ 4 хоногийн хугацаанд бид нар бараг л ерөнхийдөө өглөө 10-аас орой 10 хүртэл доод тал нь л ингэж ажиллаж байсан. Тэгэхээр би та бүхэнд нэг зүйлийг хэлэх гэж байгаа нь бас бид нарын энэ гол орсон зүйл маань энэ үрэлгэн юу гэдэг юм төсвийн энэ зардал тэлж байгаа энэ нөхцөл суурь шалтгааныг нь яах юм бэ бид нар цаашид бодлогын том шийдлийг хэрхэн хийх юм бэ, гарц гаргалгааг нь хэрхэн хийх юм бэ гэдэг дээр энэ хууль тогтоолуудтай холбоотой асуудлууд дээр нэлээн сайн шигтгэж өгч ингээд Засгийн газартайгаа хамтарч ажиллаад ингээд явж байгаа гэдэг зүйл байна. Саяын тэр бүтэцтэй тэр бүтэцтэй холбоотой асуудлууд дээр та бүхэн зөвөөр ойлгоорой энэ бүгдийг нь 100 хувь хасчихсан юм шигээр ингэж яах вэ ойлгож байж магадгүй. Энэ бол зөвхөн одоо байгаа бүтцэд нөлөөлөх асуудлууд биш. Ирэх жил 2025 оны төсөв дээр нэмэгдүүлэх гэж орж ирсэн 3600 гаран төрийн албан хаагч нар байгаад байгаа юм.

Өнөөдөр Монгол Улсад үндсэндээ бараг 230 мянган төрийн албан хаагч нар байна. Тэгэхээр энэн дээр бид нар юу гэдэг юм нэг жилийн дотор 3 мянгаар буюу бараг юу гэдэг юм. Ийм их олон мянгаар нэмэх нь учир дутагдалтай юм аа. Тэр дундаа төсвийг юу гэдэг юм алдагдалгүй батлах үр ашиггүй зардлуудаа хэмнэх, зарим чиг үүргийн давхардлыг арилгах гэж байгаа энэ цаг үе дээр бид нар энэ бүтцээ нэмэгдүүлэх, орон тоогоо нэмэгдүүлэх санал ирүүлсэн энэ байгууллагуудын саналыг бол нэг бүрчлэн судалж үзээд эндээс энэ 13 байгууллагын зөвхөн хууль болон шүүхтэй холбоотой байгууллагуудыг нь бол 50 хувиар нэмэгдүүлж өгч байгаа

шүү бууруулж байна гэж уншигдаж байгаа байж магадгүй. 50 хувиар нэмэгдүүлж өгч байгаа байгаа.

Одоо энэ 2024 оныхоос нь бусдыг нь 2024 оныхоо төсөвт орон тоонд нь хэвээр хадгалж байгаа зүйл байгаад байгаа юм. Ингэсний үндсэн дээр бид нар 1200 гаруй төрийн албан хаагч нарыг нэмэгдүүлэх энэ санал энүүгээр гарч ирж байгаа юм аа. Энэ нэг талдаа бид нарын хамгийн хэрэгцээтэй газар нь эрэмбэлж энэ орон тооны асуудлыг тавьж байгаа гэдгийг та бүхэн бас ойлгож үзээрэй.

Хоёрдугаарт энэ бид бүхний хувьд хавдрын эмнэлэгтэй асуудлыг бас Сайнзориг гишүүн бас ярьж байна. Үндсэндээ би бас түрүүн бас хэлсэн жилдээ 16 мянган хүн оношлогдоод байна. Тэгээд бид нар энэ удаагийнхаа төсвөөр байгаа ХӨСҮТ дээрээ их засварынх нь мөнгийг нь бүтэн тавьж өгч байгаа. Мөн дээрээс нь энэ эмнэлэг ачааллаа дийлэхгүй байгаад байгаа учраас ор хүртээмжийнх нь хүндрэлтэй асуудлыг нь шийдэх энэ тодорхой хэмжээний санхүүжилтийг нь түр хугацаанд ч гэсэн шийдүүлж өгье гэдэг асуудал тавьж гаргаж байгаа. Тэгэхээр энэ цаашдаа Засгийн газар энийг ямар байдлаар шийдэх вэ гэдэг асуудал дараагийн асуудал. Ямар объект байх вэ гэдэг нь дараагийн асуудлууд байгаад байгаа юм. Нэг талдаа бид нар энэ хүнийхээ.

Д.Амарбаясгалан: Мэдээж гишүүд горимын санал гаргах эрхтэй. Гэхдээ сая Тэмүүлэн гишүүн бас чухал тайлбар хийж байгаа. Засгийн газраас төсвийн төслийг өргөн барихдаа бас Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хориг Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороо, намын бүлгүүдээс гарч байсан санал зэргийг харгалзан үзээд 2.4 их наяд төгрөгөөр бууруулж орж ирсэн. Эргээд энд ажлын хэсэг байгуулагдаад энэ төсвөөс тодорхой хэмжээний зардал багасгах асуудал дээр нэлээдгүй ажилласан. Сүүлийн 4 хоног бол өдөр шөнөгүй ажлын хэсэг ажилласан. Бас энэ дашрамд энэ ажлын хэсэгт орж ажилласан гишүүддээ талархал дэвшүүлье.

Маш ажил хэрэгчээр маш хариуцлагатай олон талын улс төр, нийгэм, эдийн засаг бүх талынх нь ач холбогдлыг бас харгалзан үзэж томоохон шийдвэрүүдийг гаргажээ гэж ингэж үзсэн. Мэдээж өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд бол байр сууриудыг илэрхийлж байгаа юм. Гэхдээ ажлын хэсэг удаа дараа Засгийн газар холбогдох салбарын сайд холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр бууруулах зардал, эргээд буурсан зардлыг нэмэгдүүлэх зориулалтыг нь тодорхой болгоод ороод ирчихсэн. Тэгэхээр би энэ ажлын хэсэг энэ Төсвийн байнгын хороогоор дамжаад багцалсан санал оруулж ирж байгаа байдал нь өөрөө бууралт нэмэгдүүлэх 2 асуудлаа нэгтгэсэн байр суурь учраас ингэж багцалж оруулж ирж санал хураалгаж байна гэж ингэж ойлгож байгаа юм.

Тэгэхээр би энэ ажлын хэсгийг Төсвийн байнгын хорооноос оруулж ирсэн саналаар нь буюу багцалсан хэлбэрээр нь санал хураалт явуулах нь зөв өө гэсэн ийм байр суурьтай байна. Гишүүд маань дэмжиж байна уу?

Тэгэхээр Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нэг дэх санал хураалтыг явуулъя санал.

Санал хураалт.

82 гишүүн буюу 71.9 хувиар санал дэмжигдлээ

Хоёр.Засгийн газрын тусгай сангийн нийт зардлыг нэмэгдүүлэхгүйгээр зохицуулалт хийх санал:

1.Боловсролын сайдын төсвийн багцад тусгагдсан Боловсролын зээлийн сангийн өмнө олгосон зээлийн эргэн төлөлтийг 33,604.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, тус сангийн нийт зардлыг нэмэгдүүлэлгүйгээр сангаас олгох зээл, тэтгэлгийн зардлыг зээлийн эргэн төлөлтөөс төвлөрүүлсэн дүнгээр санхүүжүүлэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн буюу 78.9 хувиар санал дэмжигдлээ.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцад тусгагдсан Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн өмнө олгосон зээлийн эргэн төлөлтийг 40,700.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Гурав.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулах санал:

Саяын санал 86 гишүүн буюу 75.4 хувиар дэмжигдсэн байна.

Төслийн 2 дугаар хавсралтын XII.1.2.1.Батлан хамгаалах салбарын их засвар /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 27,975.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 5,938.2 сая төгрөгөөр бууруулж, Батлан хамгаалах салбарын тоног төхөөрөмжийн зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91 гишүүн буюу 79.8 хувиар санал дэмжигдлээ.

2.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцад тусгагдсан Ойжуулалт хөтөлбөрийн зардлыг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, мөн сайдын их засварын зардлыг **1,500.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

81 гишүүн буюу 71.1 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.52.Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 46,659.1 сая төгрөг, санхүүжих дүн 8,909.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,260.7 сая төгрөгөөр бууруулж, XVI.1.1.22.Баруун тойруугийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Увс, Улаангом сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 3,599.0 сая төгрөг, санхүүжих дүн 1,257.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,260.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн. Ажлын хэсгийн гишүүн биш учраас үг хэлэх боломжгүй.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

83 гишүүн буюу 72.8 хувиар санал дэмжигдлээ.

Лувсанн्याмын Гантөмөр гишүүний дэмжиж санал өгснийг протоколд тэмдэглэе.

4.Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.7.Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62.56 км /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 118,449.5 сая төгрөг, санхүүжих дүн 33,534.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,940.2 сая төгрөгөөр, XVI.1.1.5.Баруунбүрэн-Амарбаясгалант хийд чиглэлийн хатуу хучилттай авто зам, 33.4 км /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 41,089.4 сая төгрөг, санхүүжих дүн 16,435.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, энэ эх үүсвэрээр “Хушаат сумын улсын чанартай авто замтай холбох хатуу хучилттай авто замын дуусгал /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2026 он, төсөвт өртөг 13,880.4 сая төгрөг, санхүүжих дүн 6,940.2 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

81 гишүүн буюу 71.1 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.1.130.Цэцэрлэгийн барилга худалдан авах, 300 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 24 дүгээр хороо/, хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 4,800.0 сая төгрөг, санхүүжих дүн 2,500.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Цэцэрлэгийн барилга, 300 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 5,969.6 сая төгрөг, санхүүжих дүн 2,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

88 гишүүн буюу 77.2 хувиар санал дэмжигдлээ.

Дөрөв.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр өөрчлөх санал:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын XXIV.3.2.Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 165.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Шүүхийн сургалт судалгаа, мэдээллийн академийн тоног төхөөрөмж” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

87 гишүүн буюу 76.3 хувиар санал дэмжигдлээ.

Тав.Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан санал:

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 6.1.1.1 дэх дэд заалтын “Шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой өргөдөл мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн хувь” гэснийг “Шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой өргөдөл мэдээллийг шалгаж хуулийн хугацаанд шийдвэрлэсэн хувь”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар. Микрофон өгье.

Да.Цогтбаатар: Та бүхэнд оройн мэнд хүргэе ээ. 1 дүгээр санал, 2 дугаар санал, 3 дугаар санал гурвуулаа ямар нэгэн төсөв хөрөнгөтэй холбоогүй. Утга найруулгын хувьд илүү нарийвчилж оруулж ирж байгаа санал байгаа учраас та бүгдийг дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна аа.

Санал хураалт.

80 гишүүн буюу 70.2 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын 70.1.8 дахь заалтын зөвлөмжийн хэрэгжилт гэснийг зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар.

Санал хураалт.

73 гишүүн буюу 64 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 11.1.1.1 дэх дэд заалтын “суурь он 2022” гэснийг “суурь он 2023” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар.

Санал хураалт.

80 гишүүн буюу 70.2 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар хавсралтын XVIII.1.31.“Сервис центр-2” дэд бүтцийн төв /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг 14, 16, 18 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2024-2025 он, төсөвт өртөг 6,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 3,039.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, XVIII.1.19. Ногоон гудамж, дэд бүтэц /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 2,898.3 сая төгрөг, санхүүжих дүн 898.3 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тилеуханы Аубакир.

Санал хураалт.

80 гишүүн буюу 70.2 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар хавсралтын XVII.1.1.3.Соёлын төвийн барилга /Архангай, Өгийнуур сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 4,231.9 сая төгрөг, санхүүжих дүн 1,481.2 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 481.2 сая төгрөгөөр бууруулж, Таравчамбуулин хийдийн Авга дуганыг сэргээн засварлах /Архангай, Батцэнгэл сум/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 1,845.0 сая төгрөг, санхүүжих дүн 481.2 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга. Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёолол.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга гишүүн. Мөнхтулга гишүүнд микрофон өгье.

П.Мөнхтулга: Бид нар 35 их наядын төсөв баталж байгаа юм. Тэгээд эндээс нэг ч нөгөө соёлын өвийг сэргээн засварлах ажил байхгүй байгаа юм. Тэгээд энэ маань болохлоор 1700 оны үед баригдсан Тунгалаг Тамир кинон дээр гардаг Луу гүний хошууны хүрээ юм байгаа юм. Тэгээд одоо сэргээн засахгүй бол дахиж үр хүүхдүүд маань энийг үзэхгүй юм. Тэгэхээр энэ яг түүхийн өвийг авч үлдэх яг торгон мөч нь энэ байгаад байгаа юм. Тэгээд 35 их наядын төсөл баталж байгаа юм. Тэгээд энэ нэг 400 сая төгрөг л байгаа юм. Тэгээд нийт төсвийн 0,001 л хувь. Тэгээд энүүгээрээ үр хүүхдүүддээ үлдээх 1700 оны энэ төсөв дээрээ ядаж нэг ганц сэргээн засварласан өв соёлоо аваад үлдсэн ийм зүйл байсан дээр гэж оруулсан юм. Тэгээд аймаг дотроо Архангай дотроо, бүр тойрог дотроо, аймаг дотроо соёлынхоо, багц дотроо тэгээд салбарынхаа сайдтай зөвшилцөөд Төсвийн байнгын хороо дэмжихсэн санал байгаа юм шүү. Тэгээд та бүхэн маань дэмжиж өгөөрэй гэж хүсэж байна аа.

Д.Амарбаясгалан: Санал хураалт 5 дахь асуудал явж байгаа.

Санал хураалт.

64 гишүүн буюу 56.11 хувиар санал дэмжигдлээ.

Одоо тэгээд хэдүүлээ ер нь Улсын Их Хурал дээр бас мэргэжлийн Байнгын хорооныхоо дэмжсэн саналыг дэмжээд дэмжээгүй саналыг нь бас дэмжээд явах ёстой шүү. Гишүүд маань зарим зүйл дээр бас танхимд бусад гишүүдийн санал өгөх үйл ажиллагаанд нөлөөлж зарим зүйл дээр бас эмоциор асуудалд хандаад байгаа шүү. Энд бас төрийн ажил явж байгаа учраас бүх талдаа анхааралтай хандаж асуудалдаа зарчимтай хандаарай гэдгийг бас энэ дашрамд сануулж хэлье ээ.

6.Төслийн 2 дугаар хавсралтын XVIII.1.1.Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 213,199.2 сая төгрөг, санхүүжих дүн 52,959.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 9,816.6 сая төгрөгөөр бууруулж, Сургуулийн барилга 960 суудал /Өмнөговь, Цогтцэций сум/, хэрэгжих хугацаа 2019-2025 он, төсөвт өртөг 6,713.6 сая төгрөг болон санхүүжих дүнг 9,816.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар. Санал

Санал гаргасан гишүүн Гомбын Ганбаатар үг хэлье гэсэн үү? Батсуурь гишүүн гишүүний гаргасан санал нь өөрөө Засгийн газрын бодлого юутайгаа зөрчилдөж байвал Засгийн газраас бас үг хэлж мэдэгдэл хийх боломжтой. Үгүй бол Гомбын Ганбаатар гишүүн тайлбар хийнэ.

Санал хураалт.

28.1 хувиар санал дэмжигдсэнгүй.

Зургаа.Бусад байнгын хорооны санал:

1.Төслийн 1 дүгээр хавсралтын “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцад “22.6.2.4-т тусгасан “Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлого боловсруулж, хэрэгжүүлэх” гэж, хэмжих нэгжийг “тоо” гэж, Суурь оныг “2023” гэж, Суурь түвшнийг “0” гэж, Зорилтот түвшнийг “1” гэсэн арга хэмжээ нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. БОХХАА-н байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Лувсанжамц гишүүн санал гаргасан гишүүн.

Г.Лувсанжамц; Эрхэм гишүүдэд оройн мэнд хүргэе. Энэ нөгөө манай төсвийн хавсралт нэгийн хүснэгтүүд бид нарын энэ зарцуулж байгаа хөрөнгө мөнгө яг юунд зарцуулагдаад ямар үр дүнд хүрэх гэж байгаа энэ зорилт зорилго нь ямар зүйл вэ гэдгийг тодорхойлсон хамгийн чухал хавсралт бичиг баримт байгаа. Тэгээд энэн дээр нөгөө хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн дээрээ ийм дэвшилтэт байгальд ээлтэй технологийг дэмжинэ гэсэн мөртөө шалгуур үзүүлэлт дээр нь ийм дэмжинэ гэсэн ийм зүйл нь байхгүй байгаад байгаа учраас энийг ирэх жилийн төсөв дээрээс эхлээд нэмж аваад цаашдаа ийм хувийн хэвшлийн компаниудын сайн байгальд ээлтэй технологийг дэмжиж явдаг жишгийг тогтооё гэсэн зорилготой санал юм

байгаа юм. Ямар нэгэн мөнгө төгрөг нэмсэн тийм зүйл байхгүй. Дэмжиж өгөхийг хүсэж байна аа.

Д.Амарбаясгалан: Санал хураалт.

63.2 хувиар 72 гишүүн дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.1.1 дэх дэд заалтын 2025 оны зорилтот түвшин “5” гэснийг “3” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сулпхард микрофон өгье.

С.Зулпхар: Оройн мэнд гишүүдээ. Сая Лувсанжамц гишүүний хэлсэнчлэн бас энэ нөгөө суурь шалгуур үзүүлэлттэй холбоотой зарим зүйлүүдийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхнаас тодруулж байж бас энийг асуусан юм аа. Яагаад гэхээр зэрэг одоо бид энэ зүйлүүдийг зөв оруулахгүй бол дараа нь жилийн дараа энэ гүйцэтгэл нь өөрөө бас зарим нь буруу гарах ийм нөхцөлүүд гарч байгаа юм. Энэтэй холбоотой миний энэ 3 санал байгаа шүү гэж байгаа юм. Дэмжигдсэн санал байгаа. Ямар нэгэн төсөв мөнгөний энд асуудал үүсэхгүй. Цэвэр нөгөө тоонуудаа зөв болгож байгаа ийм санал байгаа. Та бүхэнд бас дэмжиж санал өгөөрэй. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Санал хураалт

3.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.1.2 дахь дэд заалтын 2025 оны зорилтот түвшин “16” гэснийг “12” гэж өөрчлөх.

Санал хураалт.

4.Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.2.1 дэх дэд заалтын суурь түвшин “9386” гэснийг “1126” гэж, 2025 оны зорилтот түвшин “10500” гэснийг “1200” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар.

Санал хураалт.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, 61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.3.2 дахь дэд заалтын суурь түвшин “36” гэснийг “16.7” гэж, 2025 оны зорилтот түвшин “40” гэснийг “20” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар.

Санал хураалт.

60 гишүүн дэмжиж, 52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар хавсралтын XXI.1.8.Налайх Дулааны шинэ эх үүсвэр 79МВт-ын эхний ээлжийн ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг/, төсөвт өртөг 56,354.9 сая төгрөг, санхүүжих дүн 16,906.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Нэгдсэн эмнэлгийн барилга /Улаанбаатар, Налайх дүүрэг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал байна. Дэмжээгүй байр суурь хэлэх боломжгүй. Санал гаргасан гишүүн тайлбар хэлэх боломжгүй.

Санал хураалт.

43.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гишүүн горимын санал.

С.Амарсайхан: Дэмжсэн санал өгсөн. Санал дэмжсэнээ ороогүй учраас горимын санал гаргаж, саяын санал хураалтыг хүчингүй болсонд тооцож, дахин санал хураалгая.

Д.Амарбаясгалан: Амарсайхан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

49 гишүүн зөвшөөрч, 43.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

7.Төслийн 1 дүгээр хавсралтын 38.1.2 дахь дэд заалтад “зам тээврийн осолд өртсөн хүүхдийн тоог бууруулах” гэсэн агуулгатай 38.1.2.3 дахь дэд заалт шинээр нэмж, Хэмжих нэгж “тоо” гэж, Суурь он “2023” гэж, Суурь түвшин “780” гэж, Зорилтот түвшин “300” гэсэн арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн, Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг Төсвийн байнгын хороо дэмжсэн байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Сая өгсөнтэй бас адилхан. Яг хавсралт нэг ийм шалгуур үзүүлэлттэй гэдгийг л засаад байгаа. Мөнгө төгрөг оруулж байгаа юм байхгүй. Энэ 38.1.2-ын зорилго нь болохоор зам тээврийн осолд өртөж байгаа хүүхдийн тоог бууруулна гэсэн мөртөө шалгуур үзүүлэлт нь төхөөрөмж хэрэглүүр нийлүүлэлтийн биелэлт гэсэн ийм логикийн алдаатай зүйл байгаад байгаа юм. Тэгэхлээр хүүхдийн ослын тоог бууруулъя гэж байгаа юм чинь тэрийгээ л хэмжье ээ гэж байгаа юм. Тэгээд өнгөрсөн онд 780 байсныг нь ирэх жил бол 300 болтол 2-оос илүү дахин бага буулгая гэсэн тийм санаатай засвар байгаа юм. Дэмжиж өгөхийг хүсэж байна аа.

Д.Амарбаясгалан: Санал хураалт.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр хавсралтын 17.1.1 дэх дэд заалтад “төрийн өмчит компаниудын хөрөнгийн өгөөжийн дундаж үзүүлэлт” гэсэн агуулгатай 17.1.1.3 дахь дэд заалт шинээр нэмж, Хэмжих нэгж “хувь” гэж, Суурь он “2023” гэж, Суурь түвшин “-” гэж, Зорилтот түвшин “20” гэсэн арга хэмжээг нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц. Лувсанжамц гишүүнд микрофон өгье.

Г.Лувсанжамц: Уучлаарай. Байн байн ингээд тайлбар хэлээд байгаад. Энэ дээр бас нөгөө ТӨК-удын үр ашгийг нэмэгдүүлнэ гэсэн мөртөө шалгуур үзүүлэлт нь болохоор ТӨК-ийн засаглалын үнэлгээ ч байдаг юм уу эсвэл олон нийтийн шууд хяналтад оруулсан ТӨК гэсэн хоёрхон шалгуур үзүүлэлт байгаад байгаа юм. Байгууллага чинь уг нь нөгөө хөрөнгийн өгөөжөөрөө тухайн байгууллага ашигтай ажиллаж байна уу үгүйг хэмждэг болохлоор энэ зөв шалгуур үзүүлэлтээ ашиглая л гэсэн тийм санал байгаа юм. Дэмжиж өгөхийг хүсэж байна аа.

Д.Амарбаясгалан: Санал хураалт.

55 гишүүн буюу 48.2 хувиар санал дэмжигдсэнгүй.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал. Нийт 28 санал байгаа.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналаар зарчмын зөрүүтэй санал хураалт цааш үргэлжилнэ ээ.

Нэг.Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан санал:

Төслийн 1 дүгээр хавсралтын 7.1.5.1 дэх дэд заалтын “Хууль тогтоомжийн хэрэгжилт” гэснийг “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар.

Санал гаргасан гишүүнд микрофон өгье. Даваагийн Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Би Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын энэ хууль тогтоомжийн хэрэгжилт гэснийг хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан гэж нарийвчилж өгч байгаа. Төсөл мөнгөтэй холбоотой асуудал байхгүй учраас та бүхэн төхөөрөмждөө хүрэхгүйгээр эсрэг санал өгөхөд энэ санал дэмжигдэх юм.

Д.Амарбаясгалан: Санал хураалт.

24.6 хувиар санал дэмжигдсэнгүй.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн горимын санал гаргая.

Х.Баасанжаргал: Төхөөрөмж ажилласангүй. Тэгэхээр энэ саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулж өгөөч. Минийх. Ганхуяг гишүүнийх гээд бид нар бүгд яг алдаа заачихсан байна. Яг алдаа ингээд дараалаад заачихлаа.

Д.Амарбаясгалан: Та хэд маань тогтвортой суудалдаа сууж байгаад санал өг за юу.

Санал хураалт дундуур босож гүйгээд харайж ирж хоцроод байна шүү дээ. Тэгээд тэрийгээ ахиад л төхөөрөмжид өгөөд байх юм.

Горимын саналаар санал хураалт. Санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт.

43.9 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 2 дугаар хавсралтын XIV.1.4.1.Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Мал аж ахуй, био технологийн сургуулийг Дархан, Сэлэнгийн бүс рүү нүүлгэхтэй холбоотой зураг төсөв /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 800.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг болон XIV.1.4.2.Шинжлэх Ухаан, Технологийн Их сургуулийн Механик, тээврийн сургуулийг Хөшигийн хөндий рүү нүүлгэхтэй холбоотой зураг төсөв /Хөшигийн хөндий/ хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 800.0 сая төгрөг гэсэн 2 төсөл, арга хэмжээг хасаж төслийн XIV.1.3.1.Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ хэрэгжих хугацаа 2025-2025 он, төсөвт өртөг 32,474.5 сая төгрөг, санхүүжих дүн 31,474.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Даваагийн Цогтбаатар. Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилын Даваасүрэн гишүүн горимын санал.

Ц.Даваасүрэн: Гишүүдээ одоогийн энэ хураагдах саналууд болохоор бас ингээд бас нэг нэгийгээ 2 сайдын төсвийг хооронд нь дур мэдээд шилжүүлчихсэн ч юм уу нэг иймэрхүү зарчимгүй саналууд байгаад байгаа юм шүү. Нөгөө талаар энэ саналууд босоод байх юм бол энэ төсөв эвдэгдэнэ. Бид нар боломжтой бас гишүүдийн болноо гэсэн саналуудыг үндсэнд нь дэмжээд өгчихсөн хэдэн санал сая та бүхэн хураачихсан.

Тийм учраас энэ саналыг гар өргөж тоолохгүй бол энэ төхөөрөмжтэй холбогдолтой янз бүрийн асуудал гаргаад байна. Энэ хэрвээ одоо дэмжигдээд явчих юм бол төсөв ахиад задрах хүндрэлтэй нөхцөл байдал руу орох гээд байна.

Д.Амарбаясгалан: Санал гаргасан гишүүн Даваагийн Цогтбаатар. Микрофон өгье.

Да.Цогтбаатар: Гишүүдэд дахиад оройн мэнд хүргэе ээ. Энэ ХАА-н сургууль болон шинжлэх ухаан технологийн сургуулийн механик инженерийн сургуулиудын холбогдох сургуулиуд нь өөрсдөө 1 дүгээрт зөвшөөрөөгүй байгаа. Тэгээд энэ салбар яам хооронд ерөөсөө шилжсэн асуудал байхгүй. Энэ ТЭЗҮ хийлгэх 2 сургуулийн 800, 800, 1 тэрбум 600 сая төгрөгийг аваад Боловсролын яаман дотор нь сургуулиудад шаардлагатай шинээр ашиглалтад орж байгаа сургуулиудад шаардлагатай тоног төхөөрөмж ширээ сандалд нь зарцуулъя л гэдэг санал. Тэгээд энийг дэмжихгүй байхад энэ бол Боловсролын яамандаа зориулалт нь өөрчлөгдөөд л үлдэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Гишүүд танхимд хангалттай байна.

Хангалттай байгаа. Гишүүд маань өөрсдөө санал хураалтдаа идэвхтэй, анхааралтай, оролцье. Гараар, санал хураахгүй, төхөөрөмжөөр саналаа хураана.

2 дахь хэлэлцүүлэг явж байна. Энд чинь бараг ер гаруй гишүүн байна шүү дээ.

Ирцэд орчхоод байхгүй байгаа гишүүн Норовын Алтанхуяг, Очирбатын Амгаланбаатар. Одоо тэгэхээр энэ яг танхимдаа ер гаруй гишүүн байна. Тэгэхээр бүгдээрээ санал хураалтдаа хариуцлагатай оролцье. Тэгээд төхөөрөмжөөрөө саналаа хураагаад явъя аа. Ингээд 2 дахь асуудал дээр явж байна. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

Сангийн сайд Болдын Жавхлан горимын санал. Энхбаяр сайд та сууж байгаад саналаа өг. Босож байгаад хазгай дарахаараа төхөөрөмж чинь.

Б.Жавхлан: Энүүгээр ч бараг арваад гишүүдийн юмнууд нь үнэхээр яг болохгүй байгаад байна дарга аа. Ёстой яаж ч үзээд болохгүй байгаад байна. Нэлээн олон саналууд дээр бас болчихож байгаа учраас чимээгүй яваад байгаа юм. Тэгээд чухал ийм заалтууд дээр уг нь саналаа бодитойгоор нь өгчихмөөр байдаг. Тэгээд болж өгөхгүй байгаад байна. Энэ саяын саналыг хүчингүй болгох юм уу, эсвэл санал гар өргөсөн гишүүдийг дэмжсэнээр шилжүүлж явах юм уу, хүчингүй болгож байж явах уу? Тэгвэл 1 тийм санал гаргая. Уучлаарай.

Д.Амарбаясгалан: Алив техникийн хүмүүс эс үгүй бол хажууд нь очоод яг дүгнэлт хэлээдэх дээ. Та хэд маань нэг хэдхэн санал хураалт дээр жоохон төвлөрч байгаад саналаа өгчихөд ямар ч проблемгүйгээр явж болж байгаа шүү дээ уг нь. Хуруугаа уншуулчих. Үгүй ээ үгүй рестарт хийгээд байх юм байхгүй л дээ. Энэ төхөөрөмж чинь та биднээс хэд дахин ухаалгаар ажиллаж байгаа төхөөрөмж шүү дээ. Тэгээд Жавхлан сайд ямар санал гаргачхав. Сая уншив уу төхөөрөмж чинь.

Сангийн сайд Болдын Жавхлангийн гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр дахь санал хураалтыг дахиж хураана. Энэ төхөөрөмж дээр ийм байгаа шүү дээ. Тэр Лодой гишүүн бас тайлбар хийчихсэн байсан та хэд маань бас анхаарчих хэрэгтэй. Одоо 15 секундийн хугацаанд бид санал өгч байгаа. Яг хурууныхаа хээг уншуулахад гуравхан секунд орж байгаа. Хэрвээ 3 секунддээ алдаа гаргачихвал хуруугаа аваад ахиад уншуулахад 15 секундийн хугацаанд 3 удаа санал өгчих боломж гарч байгаа байхгүй юу. Тэгэхээр та хэд маань энэ дээрээ л анхааралтай хандаад л явчих.

3 удаа амжиж байна лээ. Ингээд 2 дахь санал хураалт. Даваагийн Цогтбаатар гишүүний гаргасан саналаар Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

59.6 хувиар 68 гишүүн дэмжигдлээ. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.2.Мандал сумын Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр хүртэлх хатуу хучилттай авто зам /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 52,425.4 сая төгрөг, санхүүжих дүн 15,727.7 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр, XVI.1.1.7.Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62.56 км /Төвийн бүс/ хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 118,449.5 сая төгрөг, санхүүжих дүн 33,534.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 7,950.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, Налайх-Чойр чиглэлийн авто замаас Баянцагаан сум хүртэлх хатуу хучилттай 64.4 км авто замын эхлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 33,017.9 сая төгрөг, санхүүжих дүн 9,950.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаяр.

Санал гаргасан гишүүн алга байна.

Санал хураалт.

71 гишүүн буюу 62.3 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.75.Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 124.5 км /Дорнод/, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг 185,514.9 сая төгрөг, санхүүжих дүн 45,632.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын Биеийн тамир, спортын хөтөлбөр, арга хэмжээний Үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа.

Санал гаргасан гишүүний микрофоныг өгье. Булгантуяа гишүүнд микрофон өгье.

Х.Булгантуяа: Биеийн тамир спортын Үндэсний шигшээ багийн төсөв 2024 онд бол олимпын жил байсан учраас 26 орчим тэрбум төгрөгийн төсөвтэй байсан. Энэ бол угаасаа олимпын жилийн хувьд өндөр байдгийг ойлгож байгаа. Гэхдээ 2023 онд жишээлбэл 13 орчим тэрбум төгрөг байсан. Ингэж байж нөгөө тив дэлхийн олон чансаа тогтоох, дээрээс нь нэмээд олимпод орох энэ эрхүүдээ авдаг тэмцээн уралдаанд ордог байгаа. Одоо ингээд 9 тэрбум төгрөг гэдэг бол ер нь бусад үед энэ олимпын үед хүртэл тавьж байсан төсвөөсөө хамаагүй багаар тавигдаж орж ирж байгаа шүү. Энэ бол яах вэ нэг сайдын асуудал биш ээ. Тэгээд энэ үндэсний шигшээ баг үйл ажиллагаа явуулахад бол хэцүү болно л гэсэн үг. Тэгээд энийг Улсын Их Хурлын гишүүдийн хувьд аль нэг сайдын асуудал гэж харах биш. Энэ бол дэлхийн тэмцээн уралдаанд үндэсний шигшээ баг амжилт гаргах уу үгүй юу гэдгийг нэг 2, 3 жилийн хугацаанд л үйл ажиллагаагаар нь хараад л тэгээд л 2026 онд өвлийн олимптой байгаа. 2028 оны дараагийн олимпын бэлтгэл ажлууд л эхэлдэг. Ийм л төсөв юм. Тэгээд дэмжээгүйг дэмжихгүй байж.

Д.Амарбаясгалан: Санал хураалт.

Санал хураалт явуулъя. 42 гишүүн буюу 36.8 хувиар санал дэмжигдсэнгүй. Гишүүний гаргасан санал босож байна гэсэн үг. Тийм ээ.

5.Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.7.Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62.56 км /Төвийн бүс/ хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 118,449.5 сая төгрөг, санхүүжих дүн 33,534.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 33,533.9 сая төгрөгөөр бууруулж, Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай автозамын дуусгал /Говийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 160,140.6 сая төгрөг, санхүүжих 33,533.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар.

Санал хураалт.

69 гишүүн буюу, 60.5 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.Бусад Байнгын хорооны санал:

Бусад Байнгын хорооноос орж ирсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал.

1.Төслийн 2 дугаар хавсралтын XIX.1.2.Дархан арьс ширний цогцолбор"-ын бүтээн байгуулалтын арьс ширний үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Дархан-Уул, Хонгор сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 23,814.7 сая төгрөг, санхүүжих дүн 7,144.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Төвийн бүсийн хөнгөн хүнсний үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц /Дархан-Уул, Хонгор сум/” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор. Санал гаргасан нь Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан гэж байна шүү дээ. Боломжгүй.

Санал хураалт.

40.4 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцын 22.6.1.1 дэх дэд заалтыг “Монгол Улсын бүх хот суурин буюу хүн ам төвлөрсөн газруудад озон, PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл, хүхрийн давхар исэл, азотын давхар исэл зэрэг агаар дахь түгээмэл тархалттай үндсэн бохирдуулах бодис тус бүрийн хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг хэмжих” гэж, суурь оныг “2023” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц.

Г.Лувсанжамц: Энэ 2 болон дараагийн энэ 3 дугаар саналыг оруулж байгаа шалтгаан нь энэ хавсралт нэг дээр бид нар Улаанбаатар хотын л агаарын бохирдлоос РМ 2.5-ыг нь л хэмжээд байгаа. Тэгээд тэрийгээ бууруулъя л гэсэн зорилт тавиад байгаа. Гэхдээ энэ агаарын бохирдол гэдэг чинь РМ10 хүхэр, азот гэсэн бусад бохирдуулагч бодисууд байгаа. Тэрийгээ бүрэн хэмждэг болъё гэсэн зорилт. Тэгэхлээр энийгээ бүрэн хэмждэг болоод яг бууруулах арга хэмжээнийхээ үр дүнгээ дэмжээд явъя гэж байгаа.

Тэгээд дараагийн 3 дугаар санал нь болохоор Улаанбаатар дангаараа биш 21 аймгийн төвүүд бүгдээрээ агаарын бохирдолтой болчихсон байгаа. Тэгэхлээр бүх аймгуудыг бас агаарын бохирдлыг нь хэмждэг болъё гэсэн шалгуур үзүүлэлтийг нэмж оруулж өгөөч гэсэн ийм хавсралт нэг дээр үр дүн, шалгуур үзүүлэлтийг зөв болгох санал байгаа юм аа. Та бүхэн төхөөрөмждөө хүрэхгүй байж дэмжиж өгөхийг хүсэж байна аа.

Д.Амарбаясгалан: Энэ төсөв нь яах юм Лувсанжамц гишүүн. Айн БОХХАА-н Байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

Санал дэмжигдсэнгүй.

4 төслийн 1 дүгээр хавсралтын ХХААХҮ-ийн сайдын төсвийн багцын Лувсанжамц гишүүний гаргасан санал сая 2 дахь санал тийм ээ 57 гишүүн буюу 50 хувиар санал дэмжигдээгүй.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцын “22.6.1.2. дахь дэд заалтыг “Улаанбаатар хот болон 21 аймгийн төвүүдэд агаарын чанарын иж бүрэн автомат суурин харуул суурилуулах” гэж өөрчлөх. Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжээгүй. Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

61 гишүүн буюу, 53.5 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр хавсралтын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын “30.8.1.2.Санхүүжилт авсан хоршоодын орлогын өсөлтийн хувь” гэж, хэмжих нэгжийг “хувь” гэж, суурь оныг “-” гэж, Суурь түвшинг “-” гэж, Зорилтот түвшинг “10” гэсэн арга хэмжээг нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц.

Лувсанжамц гишүүнд микрофон өгье.

Г.Лувсанжамц: Оройн мэнд тэгээд энэ 30.8.1 дээр хоршоодод шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ ээ гээд Шинэ хоршоо хөдөлгөөнийхөө зээл болон хувийн банкнаас зээл олгож байгаа мөнгөн дээр хувийг нь багасгах буюу төрөөс татаас өгч байгаад малчдын энэ орлогыг дэмжье гэж байгаа. Гэхдээ шалгуур

үзүүлэлт нь өөрөө зээл авсан хоршооны тоо, иргэдийн тоо, ААН-ийн тоогоороо хэмжинэ гээд байгаа юм. Энэ нөгөө зээл өгөөд л байх юм бол ингээд л үр дүн гарна гэсэн байдалтай. Энэ шалгуур үзүүлэлт нь өөрөө алдаатай байгаа учраас яг энэ зээл авсан иргэд малчид, аж ахуйн нэгж хоршоодын орлого нь ихсэж байгаа юм уу, буурч байгаа юм уу гэдгийг нь судалгааг нь хийдэг болоод яг энэ бодит үр дүнгээ хэмждэг болъё гэсэн тийм санал юм байгаа юм. Энэ чигээрээ яваад байх юм бол ингээд л зээл аваад л энэ аваад л байна, өгөөд л байна, өгөөд л байна. Тэгээд л ихсэх тусмаа ингээд үр дүн гараад байгаа юм шиг харагдах ийм алдаатай, логикийн алдаатай, ийм шалгуур үзүүлэлт байгаад байгаа энийгээ засъя л гэж байгаа юм. Дэмжиж өгөхийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: БОХХАА-н байнгын хорооны дэмжээгүй санал, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтыг цуцалъя. Цуцалчихсан байгаа санал хураалтыг.

4 дэх санал хураалтыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

43.9 хувиар санал дэмжигдсэнгүй.

5.Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор Улаанбаатар хотод байрлаж байгаа хувийн сургуулиудын хувьсах зардлыг 38,500.0 сая төгрөгөөр бууруулж, Хөдөө орон нутгийн дотуур байрны хангамжийг сайжруулах, нийслэл дэх сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг 38,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

П.Сайнзориг: Дарга би яах вэ энэ саналаа энэ удаадаа ингээд татъя аа. Тэгээд цаашдаа бид хэд бас нэг Наранбаяр сайд бас нэг бодлогын өөрчлөлт хийгээч ээ. Үнэндээ хэлэхэд энэ Улаанбаатар хотод уг нь сургууль барихыг дэмжих гэхээсээ илүүтэй тэр бүсчилсэн хөгжлийнхөө зарчмын дагуу яг энэ Улаанбаатар хотоос гараад явж байгаа тэр тэнд орон нутагт хөрөнгө оруулалт хийж хувийн сургууль барьж байгаа ийм зүйл дээр нь нэг дэмждэг баймаар байна.

Хоёрдугаарт, 10 сая төгрөгөөс дээшээ төлбөртэй сургуулиудад хувьсах зардал өгдөггүй гэж байгаа боловч, яг 9 сая 900 мянга, 10 саяын хооронд ялгаа байхгүй байхгүй юу. Ерөөсөө л 176 хувийн сургууль байж байгаа. Яг л ийм зарчмаар явж байгаа. Тэгэхээр өнөөдөр тэрийг юу гэдэг юм Монгол хүний өрхийн дундаж орлого байдаг юм уу эсвэл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг жилд нь үржүүлээд тэрнээсээ нэг 50 хувиас дээшээ гарч байгаа сургуулиуд өгөхгүй байх ч гэдэг юм уу, ингэж явна уу гэхээс биш хэл амнаас айгаад гээд зарим өндөр төлбөртэй сургуулиуд эндээс гарчихсан. Тэгэхдээ яг энэ 10 саяын босго дээр тулгаж

авчирчхаад ингээд бас ээж ааваас нь төлбөр мөнгийг нь аваад ингээд явж байдаг сургуулиуд нэлээдгүй байна аа. Тэгээд яах вэ нэг 70 мянган хүүхдийн эрх ашиг яригдаж байгаа юм байна. Тэгээд би энийг энэ удаад бас нэг төсөв нэлээн оройтож байна. Боловсролын жил эхэлчихсэн байна. Тэгээд энэ төвлөрлийг сааруулах болон дараа нь энэ бүс нутаг гэдэг юм уу, орон нутаг дахь энэ чанартай боловсрол эзэмших энэ чиглэл рүү бас Боловсролын яам нэг анхаарал хандуулж бас оруулж ирээсэй. Бас бодлогыг нэг анхаараач гэдэг зүйл дээр л байж байгаа.

Би ингээд саналаа татъя.

Д.Амарбаясгалан: Санал гаргасан гишүүн тайлбар хийх боломжтой дэгээрээ. Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн нэмэлт тайлбар хэлье.

Ц.Даваасүрэн: Энэ дээр нэг Үндсэн хуулийн зөрчил яваад байгаа. Наранбаяр сайд энийг зохицуулах хэрэгтэй. Үндсэн хуулиараа ерөнхий боловсролын бага сургууль, дунд сургуулиуд төлбөргүй байх ёстой байхгүй юу. Ингээд төлбөртэй яваад байдаг. Уг нь энэ энэний дагуу хувьсах зардал аваад л явах ёстой. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн зөрчлийг та ер нь арилгах хэрэгтэй.

Д.Амарбаясгалан: Санал гаргасан гишүүн саналаа татлаа.

6.Төслийн 1 дүгээр хавсралтын “Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийн 13.1.4 дэх заалтад “Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн”-гийн нэршлийг “Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарсан маргааныг хянан шийдвэрлэнэ” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн. Микрофон өгье.

Б.Хэрлэн: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Тэгэхээр төрийн албаны тухай хуулийн 22 дугаар бүлэгт төрийн жинхэнэ албан хаагч удирдах албан томилогдох албан тушаалаас түр чөлөөлөгдөх, халагдах тохиолдолд маргааныг энэтэй холбоотой гарсан маргааныг ТАЗ-д гаргах, тэгээд ТАЗ нь гагцхүү энэ маргааныг хянаж шийдвэрлэх ийм хуулиар хүлээсэн үүрэгтэй байдаг. Тэгээд энэ үүргийнх нь тухай бас энэ чиг үүргээ хэрэгжүүлэх тухай санаа энэ хөтөлбөрт нь тусгагдаагүй учраас хөтөлбөрийнх нь нэршлийг нь өөрчилж, одоо санал болгож оруулж ирж байгаа юм аа. Тэгэхээр та бүхэн төхөөрөмждөө хүрэхгүй байж энэ саналыг босгож ирнэ үү.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

39.5 хувиар санал дэмжигдсэнгүй.

7.Цахим, хөгжил инновац, харилцаа холбооны сайдын багцын урсгал зардал дахь Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн Бусдаар гүйцэтгүүлэх үйлчилгээний

зардлыг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын сайдын урсгал зардал дахь сургуулийн өмнөх боловсролын гүйцэтгэл үр дүнгээр олгох санхүүжилтийг 1.500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм. Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэмд микрофон өгье.

Ч.Ундрэм: Энэ өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан гээд Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар ийм сан байгуулагдаад тэгээд энэ нь олон нийтийн нэлээн шүүмжлэлд өртдөг. Зориулалт нь болохоор энэ телевизээр энэ хувийн телевизүүд ч гэсэн хүүхдүүдийг соён гэгээрүүлэх ийм нэвтрүүлэг хийж цацахад нь зориулагддаг ийм сан байгаад байгаа юм аа.

Тэгэхээр энэ мөнгийг зүгээр одоо ийм байдлаар зарцуулж байхаар энэ Боловсролын яаманд бид нар энэ цэцэрлэгийн гүйцэтгэлийн санхүүжилтээр яг 1.5 тэрбум төгрөг дутчихаад байгаа юм. Ийшээ зарцуулчихаасай гэж бодоод энэ саналыг Байнгын хороон дээр гаргаад дэмжүүлсэн юм аа. Тэгээд энд Төсвийн байнгын хороон дээр нөгөө салбар хооронд гээд дэмжигдээгүй байгаа юм. Гэхдээ бид нар өнөөдөр яг тулгамдаж байгаа асуудлаа эрэмбэлэх юм бол энэ цэцэрлэгийн асуудал шүү дээ. Энийг манай гишүүд бүгд ойлгож байгаа байх.

Тийм учраас энэ саналыг унагааж одоо босгож өгөөч ээ гэж гишүүдээсээ чин сэтгэлээсээ хүсэж байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ундрэм гишүүн энэ өргөн нэвтрүүлгийн тухай хуультай зөрчилдөнө гэж яриад байх юм.

Санал хураалт.

40.4 хувиар санал дэмжигдсэнгүй.

8.Төслийн 1 дүгээр хавсралтын 31.4.4.2 дахь дэд заалтын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдаж ажилтай болсон хүнсний тусламж, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг иргэн” гэснийг “Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо” гэж, суурь түвшин “35281” гэснийг “172963” гэж, 2025 оны зорилтот түвшин “35633” гэснийг “183778” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Зулпхарын микрофоныг өгье.

С.Зулпхар: Энэ бас мөн адил төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоон үзүүлэлттэй холбоотой энэ засаж байсан санал юм аа. Байнгын хороон дээр энийг бас зөв тайлбарлаж чадаагүйгээс болоод уначих шиг болсон. Яамныхнаас авсан бас мэдээлэл. Гэхдээ энэ урьд нь бид бол энийг хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамрагдсан хүнийхээ тоогоор суурь түвшин болон хүрэх үр дүнгээ тооцдог байсан юм. Тэгсэн энийг өөрөөр тооцчихсон. Тэгээд бүр багасгаад ороод ирсэн байгаа юм.

Тэгэхээр энэ бол одоо байгаа суурь түвшин бол 172963 мянга байхгүй юу. Тэгэхээр бидэнд ирэх жил хөдөлмөр эрхлэлтийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт ажиллах хүчний эрэлттэйгээ холбосон байдлаар тооцоолол хийдэг юм. Ирэх жилийн тооцоолол бол 183778 байх ёстой юм байна лээ. Тэгэхээр бид энийгээ

зөв тооцохгүй бол дараа нь бас буруу болчхож байгаа учраас энийг та бүхэн кнопдоо гараа үрэхгүйгээр бас дэмжээд өгөөч ээ гэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Бодвол одоо Засгийн газраас энийг нийцэхгүй байна гэвэл тайлбар мэдэгдэл хийх дэгийн заалттай, хийхгүй байхаар болж байна гэж үзээд байгаа юм болов уу?

Санал хураалт.

Төсвийн байнгын хороон дарга Даваасүрэн гишүүн микрофон өгье.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ би энэ Ундрам гишүүнийг саналаа татчих юм болов уу гэж бодсон байхгүй юу. Энэ бас жоохон зөрчилтэй санал болчихоод байгаа юм. Үгүй ээ, үгүй. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцын төсвийг аваачаад л сайд нартай нь ярилцахгүйгээр нөгөө нэг гишүүн оруулаад л нөгөө сайдын төсвийн багц руу нэмчхэж байгаа байхгүй юу. Энэ чинь зарчмын хувьд болохгүй шүү дээ. Тийм учраас нөгөө өргөн нэвтрүүлгийн тухай хуулиараа тэр зардал чинь хуулиараа авагдаж байгаа зардал. Хуулиараа зарцуулагдах ёстой мөнгө. Тэрийг нь аваачаад өөр юм руу хийчхэж байгаа байхгүй юу. Энэ чинь хуулийн зөрчилтэй болчихоод байна гишүүд ээ.

Тийм учраас бид нар энэ саналыг унагасан юм аа. Тэгээд сайд нь саналаа хэлэхгүй юм уу?

Д.Амарбаясгалан: Дараачийн асуудал руу явъя. Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Баатархүү горимын санал.

Ц.Баатархүү: Гишүүдийнхээ бүх саналд хүндэтгэлтэй хандаж байна аа. Тэгээд хамгийн гол нь ажлын хэсэг Төсвийн байнгын хороо маш олон хоног ажиллаад тэгээд ажлын хэсэг маань маш амжилттай ажиллаад өнөөдөр Төсвийн байнгын хороон дээр бүх саналуудаа санал хураагаад шийдээд зөвшилцөөд ороод ирсэн. Тэгээд Боловсролын сайд өөрөө Төсвийн байнгын хорооны хурал дээр хэлсэн. 2024 онтой харьцуулах юм бол 2025 онд цэцэрлэгийн багш нарын үр дүнгийн гүйцэтгэлийн мөнгө нэмэгдсэн. Энэ одоо Өргөн нэвтрүүлгийн сангийн хуулиар зохицуулагддаг, Тусгай сангийн хуулиар зохицуулагддаг мөнгийг манай багцад нийлүүлж болохгүй ээ.

Нэгдүгээрт, хууль зөрчинө өө.

Хоёрдугаарт бол манай төсөв нэмэгдсэн гээд. Тэгээд Ундрам гишүүн бас энэ Монгол хүүхдүүдийн төлөө санаа зовж байгаад нь сайн байна. Тэгээд би саналаа татчих байх гэж бодсон. Гишүүд бас сайн ойлголт байхгүй байсан учраас энэ санал бол ингээд ийм ойлгомжгүй байдалтай болж байна. Энэ бол ингээд хууль зөрчигдөж байна гэдгийг дахин хэлье ээ. Би бол горимын санал гаргаж байна аа. Дахин санал хураалт явуулъя.

Д.Амарбаясгалан: Түрүүн бас санал хураалт хийхээс өмнө энэ Өргөн нэвтрүүлгийн тухай хуультайгаа зөрчилдөж байгаа юм биш үү гээд бас зарим гишүүд хэлээд байсан. Тэгээд санал хураалтаар 50 хувиар дүн гарсан. 50 хувьтай гэдэг чинь санал унаж байна гэсэн үг л дээ. Тэгээд салбарын сайд Улсын Их Хурлын гишүүн Баатархүүгийн гаргасан горимын саналаар ямар ч байсан санал хураалгая.

Баатархүү гишүүн чинь түрүүн дэмжиж санал өгсөн. Тэгэхдээ энэ зөв л дөө нөгөө дэмжсэн нь цөөнх болчихсон. Салбарын сайд нь энэ санал болохгүй ээ гээд Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжиж саналаа өгсөн байна. Тэгээд цөөнх болчхож.

Тэгэхээр горимын санал гаргах эрх бүхий этгээд нь Жуковын Алдаржавхлан гишүүн.

Г.Алдаржавхлан: Миний хурууны хээ уншигдаагүй юм. Тэгээд дахиж санал хураахыг хүсэж байна.

Хоёрдугаарт нь нэг юм хэлэхэд яг тухайн үед нь салбарын сайд нь хэлсэн. Энэ олон хүмүүсийн санаа бодол эргэнэ шүү дээ. Чив чимээгүй өнгөрчих юм. Тохирчихсон юм шиг л чимээгүй өнгөрөөд байна шүү дээ.

Д.Амарбаясгалан: Тэгвэл 7 дугаар саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулна. Гэхдээ Ундрэм гишүүн бас зөв ойлгоорой. Бид бас сая өмнөх төсвийн хэлэлцүүлгийн цаг үе дээр бас 2, 3 зүйлийг ярьсан шүү дээ.

Нэгдүгээрт, энэ Засгийн газар өргөн барьсан төсөв, Улсын Их Хурал дээр ялангуяа ажлын хэсэг, Байнгын хорооны түвшинд шийдэгдээгүй, дэмжигдээгүй салбар хооронд төсөвт шилжүүлж байгаа зүйлийг Улсын Их Хурал дээр мэргэжлийн Байнгын хороо ажлын хэсгийн дэмжээгүй саналыг нь дэмжих нь зүйтэй гэсэн ийм байр сууриар хандаад явж байгаа. Энэ салбарын сайд нар хооронд ингээд шууд гүйлгээд байж бас болохгүй. Зөрчил бас байх шиг байна. Санал хураалтын дараа горимоор санал хураадаг. Баярмаа гишүүн. Та ерөөсөө ийм юм тохиолдсон биш бүх процесс өнгөрөөд явчихсаны дараа араас нь. Үгүй ээ санал хураалт цохигдсоны дараа горимын санал гаргаж болно шүү дээ. Цөөнх болсон хүн учир шалтгаанаа тайлбарлаад дахин санал хураалт явалгүй яах вэ.

Санал хураалт.

Санал хураалтыг хүчингүй болгох горимын саналаар санал хураалт явуулъя. 77 гишүүн буюу 67.5 хувиар санал дэмжигдлээ.

Тэгэхээр энэ 7 дугаар санал. Энэ 7 дугаар санал түрүүн нь Ундрэм гишүүн тайлбараа хийчихсэн байж байгаа. 7 дугаар саналыг Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье э гэсэн санал хураалт.

Энэ Инновац, цахим бодлогын байнгын хороо дэмжсэн санал байгаа байхгүй юу.

Тэгээд өмнөх төсвийн хэлэлцүүлэг дээр бас яг ийм процесс үүсэж байсныг та бүхэн маань бас эрхээ биш одоо уул нь бас сурмаар л байгаа юм даа. Ядаж энэ салбар хоорондын асуудал, энэ гишүүдээс юм уу Байнгын хорооноос гарч байгаа саналууд чинь дотоод нь зохицуулалтуудыг хийх тийм арга замуудаар л асуудал яригдаж санал болж орж ирж яваад байгаа шүү дээ гишүүд ээ. Бас хэдүүлээ бас мэдээж аливаа асуудал дээр нухацтай л хандах ёстой байх. Энэ бас ингээд Баатархүү сайдыг эс үгүй бол элэг бариад байдаг юм уу.

Хоёр ч удаа ингээд л өөрийнх нь багцад байгаа төсвийг нь өөр тийш нь шилжүүлэх гээд явж байдаг ийм зүйл гараад байна шүү дээ. Энэ бас болохгүй ээ. Салбарын сайдын саналыг сонсчих ёстой. Тэгэхээр энэ Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

80 гишүүн буюу 70.2 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр хавсралтын 31.4.4.2 дахь дэд заалтын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдаж ажилтай болсон хүнсний тусламж, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг иргэн” гэснийг “Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо” гэж, суурь түвшин “35281” гэснийг “172963” гэж, 2025 оны зорилтот түвшин “35633” гэснийг “183778” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

54 гишүүн буюу 47.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

9.Төслийн 1 дүгээр хавсралтын 31.6.1.1 дэх дэд заалтын Шалгуур үзүүлэлт “Нийт гэр бүлд гэрлэлт цуцлалтын эзлэх хувь хэмжээ” гэснийг “Нийт гэр бүлд гэр бүлийн талаарх сургалтад тэнхим, цахимаар хамрагдсан гэр бүлийн эзлэх хувь”, суурь түвшин “2.2” гэснийг “0” гэж, 2025 оны зорилтот түвшин “<2.2 буурна” гэснийг “20” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар. Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сулпхар.

С.Зулпхар: Энэ нөгөө чанарын шалгуур үзүүлэлт нь бас асуудалтай учраас энийг бас яамныхантай өөрсдөө ярьсан санал солилцсон. Гэр бүлийн цуцлалтыг л ер нь багасгана гэдэг тоо шууд тоо тавьчихаж байгаа байхгүй юу. Энэ бол ер нь боломжгүй. Ийм хэмжилт хаана ч хийгддэггүй. Харин эсрэгээрээ нөгөө одоо байж байгаа агентлагийн гол чиг үүрэг яамны голлосон чиг үүрэг энэ гэр бүлийн чиглэлээр сургалтад хамруулахаар байгаа юм. Хуулиараа ч тийм. Тэгэхээр ийм шалгуур үзүүлэлттэй болгоё гээд суурь үзүүлэлт нь угаасаа тэг байгаа. Тэгээд энэ 20 хувь гэсэн байдлаар оруулъя гэсэн энэ зөвлөлдөж гарсан санал шүү. Яамныхан бас энийгээ дэмжсэн.

Д.Амарбаясгалан: Санал хураалт.

28.1 хувиар санал дэмжигдсэнгүй

10.Төрийн албан хаагчийн цалинг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 6 хувиар нэмэгдүүлж, холбогдох санхүүжилтийг хэмнэсэн 219.0 тэрбум төгрөгийг Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх дараах мега төслийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд зарцуулах. Үүнд:

- 1/Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл
- 2/Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл
- 3/Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх төсөл

4/Улаанбаатар хотын төвийн дулаан хангамжийн төсөл

5/Улаанбаатар хотын ногоон орон сууц төсөл. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг. Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хороодын дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал гаргасан гишүүн Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлье.

Би яах вэ бас энэ саналыг хэлэлцэх эсэх дээр ярьж байсан. Цаашдаа цалин хөлсөө жил болгон тогтвортойгоор авч явах тэр суурь, дэд бүтэц тэр хөгжилгүйгээр энэ цалин хөлсний нэмэгдлийг яриад байж чадахгүй. Тэгэхээр уг нь энэ хамтарсан Засгийн газрын үе дээр энэ мега төслүүдийг эхлүүлж бас нэг хугацаандаа ашиглалтад орж цаашдаа энэ улс орны эдийн засгийг тогтвортой тэлэлттэй энэ нь үр өгөөж нь буцаад цалин тэтгэвэр, хүүхдийн мөнгөн дээрээ очдог байх тэр зүйл рүү явмаар байна аа. Би өөрөө төрийн албан хаагч л даа байсан, одоо ч байна. Тэгэхдээ энийг ойлгоно гэж би бодож байгаа. Сая 4 сарын 1-нд бас цалин нэмсэн. Энэ зөвхөн энэ жилийн цалингийн зардал дээр 438 тэрбумыг зарцуулах гэж байна. Тэгээд энийг 1 сарын 1-ээс хэрэгжихийг 6 сарын 1 болгоё. Энэнээс хэмнэлт үүсгэе. Ер нь зүгээр бас энэ төрийн албаны цалинг бас нэмээд байх нь хувийн хэвшлээ ч гэсэн бид нар чирч гүйх гэж байгаатай ерөөсөө ялгаа байхгүй. Тэгэхээр энийг бас яах вэ би зарчмын хувьд энэ саналаа хураалгана. Гишүүд маань бас кнопдоо хүрэхгүй дэмжээд өгвөл би бас тодорхой энэ мега төслүүдийг шийдье ээ л гэж байгаа юм.

Энэ Улаанбаатар хотын утаа хөрсний бохирдлыг шийдье гэхээр энэ дэд бүтцийн асуудал хэрэгтэй байгаад байгаа юм. Энэ ажил хойшлох тусам орон сууцын бодлого явахгүй ээ. Энэ ажил хойшлох тусам ерөөсөө л иргэдийн энэ амьдралын чанарт өөрчлөлт гарахгүй. Тийм учраас бас би энэ зарчмыг нь бодож энэ саналыг гаргаж байгаа юм. Түүнээс биш төрийн албан хаагчдаа дургүйдээ биш. Ажил амьдралыг нь ойлгохгүйдээ биш ээ. Тэгээд энэ зүйлүүдээ том зургаараа бас зарчмын хувьд ер нь мега төслүүдээ явуулъя аа. Ерөнхийлөгчийн хориг дээр байгаа шүү дээ. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ анхаараарай гэсэн.

Бид энэ мега төслүүд энэ маягаараа удаашрах юм бол 2028 онд иргэд сонгогчдоо юу хэлж орох юм бэ? Хамтарчхаад нэг ч гэсэн мега төслөө дуусгаж чадахгүй бол бид юу хэлэх юм бэ? Ийм л зүйл байна. Тэгээд дэмжиж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Төрийн албан хаагчийн цалинг 2025 оны 6 сарын 1-ний өдрөөс эхлэн 6 хувиар нэмэгдүүлж, холбогдох санхүүжилтийг хэмнэсэн 219 тэрбум төгрөгийг гадаад зээлийн тусламжаар хэрэгжүүлэх дараах мега төслийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд зарцуулах гэсэн саналыг Пүрэвжавын Сайнзориг гишүүн гаргасан.

Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Ц.Даваасүрэн: Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн үг хэлье. Энэ яах вэ цагаан сараар цалинг нь нэмэхгүй л гэсэн үг шүү дээ. Энгийн ойлголтоор тайлбарлавал, эхний 6 сарын цалин нэмэхгүй л гэсэн үг. Ингээд саналаа хураацгаая.

Д.Амарбаясгалан: Төсөвтэй холбоотой ер нь Улсын Их Хурал, Засгийн газраас хамаарах үйл ажиллагаа өнгөрсөн 2 сар гарны хугацаанд явагдсан. Үүний үр дүнгээр ямар ч байсан төрийн албан хаагчид маань хохирч үлдэж болохгүй ээ гэдэг ийм байр суурь Улсын Их Хуралд байгаа шүү. Мэдээж өөр эх үүсвэрүүдийг гаргаж энэ гадаадын зээл тусламж наана цаана зүйлийг зохицуулах боломж нөхцөл нь мэдээж өнөөдөр зохицуулаад явж байгаа Засгийн газарт байгаа гэж бас бодож байгаа.

Санал хураалт явуулна. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. Санал хураалтыг хүчингүй болгочихёе. Энд буруу дарагдчихаж. Санал хураалт цуцлагдсан байна.

Санал хураалт.

84 гишүүн буюу 73.7 хувиар Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэбат: Дэмжиж санал өгсөн шүү ёстой болохгүй юман дээрээ эсээгээрээ орчхож.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе ээ.

11.Төслийн 1 дүгээр хавсралтын 31.4.4.1 дэх дэд заалтын Шалгуур үзүүлэлт “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан иргэдээс 3 ба түүнээс дээш сарын хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэн” гэснийг “Байнгын ажлын байранд зуучлагдсан хүний тоо” гэж, 2025 оны зорилтот түвшин “14564” гэснийг “15154” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Зулпхар, Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарт микрофон өгье.

С.Зулпхар: Зүгээр тоо засаж байгаа. Шалгуурыг нь устгаж байгаа юм. Шалгуур нь байнга ажлын байранд зуучилсан хүний тоогоор хэмждэг юм. Энэ 4, 5 орж ирчихсэн байна лээ л дээ. Тэгээд энийг бол байснаар нь өнгөрсөн 5 жил болон ирэх 5 жилд хэмжихээр хэрэгжих ёстой. Тэрүүгээр нь оруулчихъя гэсэн саналтай байна. Энэ тоо бол бас нэг тооцоолол байдаг. Тооцоог бас яамныхнаар хийлгүүлсэн. 14564 биш 15154 байх юм байна лээ. Энийг бол яамныхан нь өөрөө зөвшөөрсөн санал байгаа шүү. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

43.9 хувиар санал дэмжигдсэнгүй.

12 дахь санал чинь Тэмүүлэн даргаа түрүүчийн ажлын хэсгийн саналаар хураагдсан санал байх юм.

12.Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Дотоод хэргийн их сургуулийн 2025 онд шинээр нэмэгдэх орон тоог 30 хувиар бууруулж, буурсан орон тоотой холбоотой урсгал зардлыг бууруулах замаар Төслийн 2 дугаар хавсралтын XI.1.Барилга байгууламж, XI.2., XI.3, XI.4, XI.5, XI.6 дахь хэсгийн “тоног төхөөрөмж”-ийн төсөвт өртөг болон санхүүжих дүнг нийт 21,200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара, Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал байна.

Санал гаргасан гишүүн алга байна.

Санал хураалт.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

76 гишүүн дэмжиж, 66.7 хувиар дэмжигдлээ.

13.Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын хөрөнгө оруулалт, их засварын зардлыг 9,800.0 сая төгрөгөөр бууруулж, ХЗДХЯ-ны норматив зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал.

П.Сайнзориг: Би энэ саналаа татчихъя аа. Илүү дутуу тайлбар байхгүй. Бас сайдаас сайдын хооронд гүйж байгаа нь зохимжгүй гээд түрүүнээс хойш ярьж байгаа учраас татаж байна.

Д.Амарбаясгалан: Санал татагдлаа. Энэ оруулж ирсэн материал дээр анхаарахгүй Эдийн засгийн хөгжлийн сайд биш шүү Эдийн засаг, хөгжлийн сайд шүү. Редакц дээрээ анхаараарай 13 дахь санал татагдлаа

14.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтийг 991.0 сая төгрөгөөр бууруулж, Авлигатай тэмцэх газрын даргын томилолтын зардлыг 533.2 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 112.6 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 345.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал.

Санал гаргасан Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүнд микрофон өгье.

Х.Баасанжаргал: Энэ хууль зөрчихгүй сайдаа. Тэгээд дээрээс нь бас нөгөө дээрэлхээд энэ тэр гээд тэгээд авч байгаа мөнгө ерөөсөө биш ээ. Манай хуулийн салбарыг харин ч дээрэлхээд мянга гаруй орон тоогоор та нар хасаад орж ирээд сая батлуулаад явсан. Тэрний чинь хажууд энэ 4 зуугаад сая төгрөгийн хүмүүсийн томилолтын мөнгийг яагаад хасаад байгаа юм. Цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэл гээд. Тэгээд энэ бүх нийтийн үүргийн сангийн тухай хуулийг нь би гаргачихсан байна, журмыг нь гаргачихсан байна. Ерөөсөө хууль зөрчөөгүй. Улсын төсвөөс санхүүждэг мөнгө. 13, 14, 15.

Д.Амарбаясгалан: Энэ одоо тэгээд л нөгөө муу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын. Энэ Баатархүү сайдын энэ багц руу ч хамаагүй дайрдаг болсон байна даа. Баатархүү сайд энд бас өөрийнхөө байр суурийг Засгийн газрыг төлөөлж мэдэгдлээ хийсэн нь дээр байх аа. Дэгээрээ мэдэгдэл хийнэ гэж байгаа шүү.

Ц.Баатархүү: Монгол Улсын Ерөнхийлөгч Төсвийн тухай хуульд хориг тавиад бид нар ингээд ажлын хэсэг ажиллаад санал оруулж ирж байгаа. Энэ удаагийн төсөв Эрүүл мэндийн салбарыг дэмжсэн, боловсролын салбарыг дэмжсэн, урсгал зардлыг бууруулсан, гадаад, дотоод томилолтыг бууруулсан. Тэр дундаа төсөв ерөнхийлөн захирч байгаа том том дарга нарын гадаад, дотоод томилолтыг бууруулж, хүүхдүүдэд, эрүүл мэндийн салбарт, Хавдрын эмнэлэгт хүмүүстээ чиглэсэн ийм төсвийг ажлын хэсэг Төсвийн байнгын хороо оруулж ирж байна.

Хоёрдугаарт нь нэг зүйлийг хэлье ээ. Энэ үүргийн сан бол харилцаа холбооны чиг үүргээр ажилладаг компаниудын ашгийн 3 хувиар бүрдүүлдэг. Улсын төсвөөс нэг ч төгрөг авдаггүй ийм сан байгаа юм аа. Энэ санг яаж зарцуулах вэ гэдгийг харилцаа холбооны компаниудын хяналтын зөвлөл нь шийддэг.

Өнөөдөр Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 23 хувьд нь л харилцаа холбооны сүлжээ нэвтэрсэн байна аа. Энэ өргөн уудам нутагт хөдөлгөөнт холбоо тавьж өгөөч ээ, сайжруулаач ээ гэж маш олон Улсын Их Хурлын гишүүд ханддаг аа. Бид нар 2025 онд малчдадаа аялал жуулчлалд зориулсан боомтуудад зориулсан 160 цэгт сүлжээ тавих гэж байгаа юм аа. Энэ мөнгийг ингээд дарга нарын томилолт руу тавина гэдэг 1 дүгээрт энэ боломжгүй зүйл ээ. Тийм учраас би таныг бас саналаа татаасай гэж бодож байна баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баасанжаргал гишүүн санал татах санал юм уу, үг хэлэх гэж байгаа бол горим. Татах санал байвал байгаа. Сая үгээ хэлчихсэн учраас. Гишүүд ээ чимээгүй. Энэ бас сая Баатархүү сайдын хэлдэг бас зарчмын хувьд бүх нийтийн үүргийн сан гэдэг чинь өөрөө хуультай, өөрөө зарцуулалт нь чиглэл нь маш тодорхой. Тэгэхээр энэ бол яг бодит байдал дээр хууль зөрчсөн санал хураалт болох гээд байна шүү дээ. Тэгээд би нөгөө өмнө нь хэлээд байгаа яг хуулийн зөрчилтэй саналыг ингээд Байнгын хороон дээр хураалгаад тэгээд нөгөө дэмжигдээгүй санал гэж орж ирж Улсын Их Хурал дээр зарим талаар дэмжигдэж байгаа ийм байдлууд гараад байгаа юм аа. Тэгээд энэ бас Дэгийн тухай хуультай холбоотой бас жаахан тодорхой зөрчлүүд бас байна. Тэгэхээр яах юм Баасанжаргал гишүүн саналаа хураалгах уу?

Санал хураалт.

14 дэх санал хураалт.

89 гишүүн буюу 78.1 хувиар санал дэмжигдлээ.

15.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтийг 620.5 сая төгрөгөөр бууруулж, Монгол Улсын Ерөнхий Прокурорын томилолт, зочны зардлыг 420.5 сая төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 200.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал. ХЗБХ-ны дэмжсэн санал байна аа. Баасанжаргал гишүүнд микрофон өгье.

Х.Баасанжаргал: Энэ хар манайх энэ АТГ-ын дарга эсвэл Ерөнхий прокурорын дарга энэ тэрийн томилолтын зардал гэж ойлгоод байх юм. Энд чинь өчнөөн орон нутагт ажиллаж байгаа хуулийн байгууллагын салбарын тэр чигээрээ томилолтын зардал энэ бичиг хэргийн зардал 200 сая төгрөгөөр нэмэгдэж байж өмнөх жилийнхээ бичиг хэргийн зар талтай тэнцэх гээд байгаа юм аа. Би тэрийг тайлбарлаж хэлэх гээд байна. Тэгээд дандаа хуулийн байгууллагын бүх орон тоо хамаг юмнудаас та нар хасаад элэг бариад байгаа биз дээ. Би тэгэхдээ энэ саналыг буцааж татъя. Гэхдээ цаашид ингэж хуулийн байгууллагыг ерөөсөө тэр чигээр нь дандаа дарга нар гэж ойлгоод байх юм. Та нар сая мянга гаруй орон тоог нь сая хасаад ороод ирлээ шүү дээ.

Д.Амарбаясгалан: 15 дахь санал татагдлаа. Энэ хуулийн байгууллагын урсгал зардалтай холбоотой бууруулах асуудал бас энэ удаагийн төсөв дээр маш их өргөн хүрээгээр яригдаад нэмэгдэж байгаа орон тоог багасгах тийм шийдвэрүүд бас гарч орж ирсэн. Гишүүд бас энэ дээр зарим талаар шүүмжлэлтэй хандаж байгаа зүйлүүд бас байгаа. Зарим талаар санал нийлнэ. Гэхдээ энэ төсвийг хооронд нь зохицуулж байгаа санал маань өөрөө зарчим алдаж байна л гэж байгаа шүү дээ Баасанжаргал гишүүн ээ тийм ээ.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцыг татаж авангуутаа өөр салбар луу аваачиж хийж байгаа зарчим нь алдагдаж байгаа учраас энэ дээр мэргэжлийн Байнгын хороо дэмжээгүй байна аа. Ингээд 15 дахь саналыг санал гаргасан гишүүн татлаа.

16.Сангийн сайдын төсвийн багцын Сангийн яамны хөрөнгө оруулалт, их засварын зардлыг 5,065.0 сая төгрөгөөр бууруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын урсгал зардлыг доор дурдсан дүнгээр нэмэгдүүлэх. Үүнд:

1.Цагдаагийн ерөнхий газрын томилолт, бичиг хэргийн зардлыг 2,900.0 сая төгрөгөөр;

2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын томилолт, бичиг хэргийн зардлыг 245.0 сая төгрөгөөр;

3.Хил хамгаалах ерөнхий газрын байр ашиглалтын зардал 1,000.0 сая төгрөгөөр;

4.Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн татаас санхүүжилтийг 920.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд, Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. Уучлаарай санал хураалтыг цуцалъя. Сангийн сайд Болдын Жавхлан мэдэгдэл хийе.

Б.Жавхлан: Манай Алтангэрэл сайд бол ингээгүй байх аа. Тэгээд Эрдэнэболд ч гэсэн бас гаргаж байсан саналаа бас уншиж амжаагүй юм шиг байна. Эрдэнэболд гишүүн. Энд нэг юм хар аа, 3 санал байгаа юм. Түрүүний 13 дээр Гантөмөр сайдынхаас хассан, хөрөнгө оруулалт, их засвар. Одоо минийхээс хасаж байгаа хөрөнгө оруулалт их засвар. 17 дээр дахиад Гантөмөр сайдынхаас хөрөнгө оруулалт их засвар гэж байгаа юм. Бид 2 дээр энэ 2 яаман дээр хөрөнгө оруулалт их засвар гэдэг зардал байхгүй. 0 юмнаас хасах ч боломж байхгүй. Тэгэхээрээ 3 гишүүнд яасан юм шиг байгаа юм. Үүрэг өгсөн юм шиг байгаа юм. Энэ 2 сайд ийм том сайд нар юм чинь ийм засвар зардал байж л таараа эндээс нь хас гээд л өгсөн юм шиг байгаа юм. Тэгээд дэмжигдээгүй юм шиг байгаа юм. Тэгэхдээ яах вэ хэдүүлээ алдагдалгүй төсөв баталцгаая гээд бүх нийтийн уриатай явж байгаа шүү дээ. Тэгээд тэрүүгээрээ Засгийн газар нь ингээд ороод ирсэн. Энэ дээр манай бүх яамдууд ижил хүчин зүтгэцгээсэн. Том төсөвтэй яамдууд том л хасагдаж байгаа. Яг ижил зарчмаар. Тэр энийг нь сугалж, илүү хассан, танасан тийм зүйл огтоос байхгүй.

Тэгэхээр манай Хууль зүйн яамныхан салбарынхан бол бас яг ижилхэн л байгаа. Сангийн яам ч гэсэн яг ижилхэн л зүтгэж байгаа. Тэгэхээр ингэж сайд нарыг хооронд нь ингээд ч дэмий байх. Энэ 3 заалт өөрөө хууль зүйн хувьд ингээд алдаатай. Ийм эдийн засгийн ангиллын төрөл зардал байхгүй юмнаас хасна гэхчхэн байна лээ.

Дараагийнх нь 17 Эдийн засгийн хөгжлийн сайдаас хасна гэхчхэн байгаа бас ижилхэн ийм зардал байхгүй. Сангийн яамнаас хасах хөрөнгө оруулалт хийх шаардлага одоогоор байхгүй. Эдийн засгийн хөгжлийн яам маань өөрөө яамны байр байхгүй түрээсийн байранд байдаг, тэр түрээсийн байрыг засах хэрэггүй, хөрөнгө оруулалт хийх шаардлагагүй, ийм зардлууд байхгүй юм байгаа юм шүү.

Д.Амарбаясгалан: Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболдод микрофон өгье.

С.Эрдэнэболд: Энэ ийм учиртай юм. Ямар үйл явдал болж байна гэхээрээ ХЗБХ-н дээр энэ асуудлууд яригдсан. Үнэнээ хэлэхэд бид нар чинь ярьж байгаа л даа энэ хууль зүйн хэдэн салбарынхаа байгууллагууд агентлагуудын төсвийг бас аль болохоор энэ хууль сахиулах, шударга ёсыг сахиулах чиглэлд нь доголдол алдаагүй гаргачих юмсан гээд л 6, 7 зарчмын зөрүүтэй санал гаргаад л тэгээд Их Хурлын гишүүд нь түүнийгээ жигд аваад зарчмын зөрүүтэй санал гаргаад байгаа юм.

Хоёрдугаарт бол энэ Төсвийн байнгын хорооны томилогдсон ажилтан манай ХЗБХ-ны ахлах зөвлөх, олон шинжээч нар сууж байгаад тэр цаасан дотроос энэ хөрөнгө оруулалт их засвар гэдэг үг үсэгтэй зардлыг байсан учраас 2 нүдээрээ биш 20 нүдээр хараад ингээд 4 зүйлийг хэлсэн байхгүй юу. Тэгэхээр энийг та нар бас нэг зөв ойлгоорой ядаж би протоколд энийг зөв ойлголттой үлдээмээр байна. Битгий маазраад инээлдээд байгаарай.

Нэгдүгээрх нь болохлоор энэ ЦЕГ-ын томилолт гэдэг даргын томилолт биш бөгөөд хууль сахиулах энэ үйл ажиллагаанд энэ олон мянган цагдаа нар чинь нааш цаашаага хөдөлгөөн хийх дээрээс нь бичиг хэргийн зардал гээд. Тэгээд энэ чинь бичиг хэргийн зардлыг таначихлаар тэр олон мэдүүлэг цаасыг чинь хаанаас гаргах юм? Хувиасаа гаргах юм уу?

Хоёрдугаарт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар дээр яг ижилхэн. Энэ томилолтын зардал гэдэг бол аялж зугаалах гээд гадаад, дотоод явж галуу шувууны мах идэх гээд байгаа зүйл биш. Энэ ажил хийх процессын зардал нэмээд бичиг хэргийн зардал. Дахиад энд чинь баахан бичиг цаас хэрэгтэй болдог.

Гуравдугаарт нь ХХЕГ-ын байр.

Дөрөвдүгээрт нь Төрийн тусгай албан хаагчдын эмнэлгийг 920 сая төгрөгөөр ингээд бууруулчихсан байгаад байгаа юм аа. Тэгээд энд чинь 3 жилийн статистикийг нь харахад 2023 он гэхэд бол 180 мянган хүн, 90 мянган хүн одоо 200 мянган хүн жилдээ эргэлттэй үйлчлүүлж байгаа ийм том юм байхгүй юу. Тэгээд нөгөө эмнэлгийн төсөв хасахгүй гээд байсан. Ингээд хасчихсан тохиолдол гарч байгаа юм. Энэ алдаа нь юу байна гэхлээр хөрөнгө оруулалтыг 20 хувь гэж байгаад тэгшитгэж хассанаас болж байгаа.

Тэр Тэргүүн Шадар сайд юм уу тэр Сангийн сайдуудын төсөв нэг нь 107, нэг нь 127 тэрбум төгрөгийн төсөв байсан байхгүй юу. Тэгээд энэ тэрбум 127-той, 107-тойгоос энэ текстээрээ хөрөнгө оруулалт зардал, их засвар гэсэн энэ ангилал байсан учраас тэндээс нь энийг зохицуулалт хийчих болов уу гэж бодсон. Ер нь бол энэ Засгийн газрын гишүүд хоорондоо энийгээ бас уг нь ярих ёстой байхгүй юу. Тэгээд хоорондоо учраа олоогүй байж Байнгын хороод дээр өөр өөр зөрүүтэй мэдээллүүд өгөөд эцэст нь энэ шийдвэр гаргалтын цаана шударгаар ажлаа хийж байгаа төрийн албан хаагчид, жирийн нөгөө хөөрхий цагдаа, шүүхийнхэн, ял эдлүүлэхэд ажиллаж байгаа хүмүүс энэ хүмүүс хохирчхож байгаа байхгүй юу. Шударга ёсыг одоо тэр Баасанжаргал гишүүн эд нарыг ингээд тавлаад байх хэрэггүй байхгүй юу.

Тэр чинь яг нөгөө нэг даргын зардал биш байхгүй юу. Тэнд үйл ажиллагааны зардлууд яваад байгаа. Энэ ХЗБХ-ны хувьд бид нар энэ дээр намчирхаагүй юм аа. Намчирхаагүй ямар нэгэн байдлаар улс төржөөгүй, цэвэр энэ оперэйшн зардал шударга ёсыг сахиулахад шаардлагатай зардал учраас бид нар суулгаж өгсөн юм байгаа юм аа.

Ийм учраас саналаа хураалгая гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Ингээд Сүхбаатарын Эрдэнэболд гишүүний гаргасан ХЗБХ-ны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал байгаа. Санал хэлэх үү? Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Гишүүд ээ бид нар одоо ингээд төсвөө алдагдалгүй баталъя гээд 2.3, 2.4 их наядын зардал хассан бүх салбараас хасагдсан. Тэр дотроо эрүүл мэндийн салбар боловсролын салбар 2 хэдэн 100 тэрбумаар хасагдсан байгаа. Тийм учраас салбар салбар л зовлонтой байгаа. Салбар салбар л асуудалтай

байгаа. Тийм учраас нэгэнт ингээд жигд хассан юман дээр нэг салбараа ингээд одоо юу гэдэг юм элдэв шалтгаан тоочоод ингээд үлдээх гэдэг ч юм уу энэ нь зохисгүй.

Тийм учраас нэгэнт л хэдүүлээ зарчмаа бариад л бүх салбараас хассан тэр хэмжээгээрээ л явахаас өөр арга байхгүй.

Д.Амарбаясгалан: ХЗБХ-ны дэмжээгүй Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

78 гишүүн 68.4 хувиар санал дэмжигдлээ. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

17.Төслийн 2 дугаар хавсралтын Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын Хөрөнгө оруулалт, их засварын зардлыг 4,055.0 сая төгрөгөөр бууруулж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хөрөнгө оруулалтын зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

83 гишүүн буюу 72.8 хувиар дэмжлээ.

18.Төслийн 2 дугаар хавсралтын XVI.1.1.25.Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай авто зам, 54.18 км /Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 66,766.5 сая төгрөг, санхүүжих дүн 20,302.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр бууруулж, Дулааны цахилгаан станцын 2 дугаар хэлхээний гадна шугам сүлжээ /Баянхонгор/, санхүүжих дүн 3,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх.

Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн, Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг.

Санал гаргасан гишүүн Даваагийн Цогтбаатар гишүүн үг өгье.

Да.Цогтбаатар: Гишүүддээ энэ орой мэндийг дахин хүргэе ээ. Энэ Баянхонгор аймагт хэрэгжиж байгаа Дулааны станцын ажлын 2 дугаар хэлхээний ажил улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ёстой. Төсөв өргөн барьж байх үед буюу 8 сарын 30-нд зураг төсөл нь магадлангаар ороогүй байсан юм. Бусад аймгууд нь ороод дарааллаараа л явж байгаа юм шүү. Аймгаасаа өөрөө сонгогдсон гишүүн рүүгээ холбогдоод Шаргалжуут руу хийгдэж байгаа энэ замын дундын санхүүжилтээс 2025 онд оногдох 20 тэрбумаас нь 3 тэрбумыг нь хасаад 52 тэрбумаар энэ магадлал нь батлагдчихсан байгаа. Энэ магадлал нь энэ байна. Сангийн сайд Төсвийн байнгын хороон дээр магадлал нь ирээгүй байна гэсэн юм. Магадлал нь энэ байна 11 сарын 19-нд батлагдсан энэ ажлаа эхлүүлчих юм бол Баянхонгор аймагт хуримтлагдаад байгаа утааных нь асуудал нэг өдрийн өмнө ч гэсэндээ шийдэгдэх ийм боломжтой учраас та бүхэн төхөөрөмждөө гар хүрэхгүй байж энэ сандлыг босгож өгч нэг утааны эсрэг аянд бас нэгдээсэй гэж хүсэж байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

49 гишүүн буюу 43 хувиар санал дэмжигдсэнгүй.

Тилеуханы Аубакир гишүүн горимын санал.

Т.Аубакир: Энэ дарга аа би сая хуруугаа уншуулаад яг амжсангүй. Тийм учраас дахиж санал хураалт явуулж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Горимын санал. Горимын саналаар санал хураалгах л ёстой л болчхож байгаа юм л даа. Би чинь нэг хэсгийнх нь үздэгээр горимын саналаар санал хураалгахаар хууль зөрччихдөг. Нөгөө хэсгийг нь горимын санал гаргахаар хураалгахгүй бол бас хууль зөрчих гээд байдаг. Ингээд санал хураалттай холбоотой горимын санал гарсан учраас Тилеуханы Аубакир гишүүний саналаар санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалтыг явуулъя аа.

Санал хураалт.

Горимын санал дэмжигдсэнгүй.

Гишүүд ээ одоо есхөн санал байна. Та хэд маань 9 саналыг саад багатай явбал 10 минутын дотор хураана. Тэр одоо жоохон сууж байгаад хэдүүлээ санал хураалтаа дуусгачихъя. Үүд рүү гарсан гишүүд байвал орж ирэхийг хүсье. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүнийг суудалдаа сууж санал хураалтад оролцохыг хүсэж байна.

19.Төслийн 1 дүгээр хавсралтын 18.1.1.1 дэх дэд заалтын “бодлого, төлөвлөлтийн баримт бичиг” гэснийг “дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц, Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Лувсанжамц гишүүн тайлбар.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе. Хориг тавиулсан төсвийг маш сайн хэлэлцээд шүүсийг нь шахаад үр дүнтэй ажиллаж байгаа Засгийн газар болон ажлын хэсэг, Байнгын хороо өнөөдөр ингээд шөнө оройн цаг хүртэл ингээд суугаад төсвөө оноос өмнө багтаад баталъя гээд маш анхааралтай суугаад энэ асуудалд ач холбогдол өгөөд ажиллаж байгаад маш их баяртай байна аа. Татвар төлж байгаа иргэн ААН-ийн төгрөг бүр нэг төгрөг бүр үр дүнтэй зүйлд зарцуулагдах ёстой. Энэ төсөв батлаад энэ үр дүнгээ юугаар хэмжих юм бэ гэхээр энэ хавсралт нэг буюу төсөл, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулагдаж байгаа. Түүний зорьж байгаа зорилт, зорилго, хэрэгжүүлж байгаа арга хэмжээгээ ямар үр дүнд хүрч байгаа гэдгийг хэмжих шалгуур үзүүлэлтээрээ өнгөрсөн жил ямар суурь түвшинтэй байсан юм,

ирэх жил ямар зорилтот түвшинд очих гэж байгаа юм гэсэн ийм зүйлүүдээрээ л бид нарын хийсэн ажил үнэлэгдэнэ. Иргэд бол бодитой үр дүнг л хүсэж байгаа. Тэгэхээр яг үр дүнд хүрэх боломжтойгоор шалгуур үзүүлэлтээ зөв засаж залруулж болох ёстой.

Өмнөх төсөв дээр Анар гишүүн, Энхтүвшин гишүүн энэ шалгуур нэгийн шалгуур хавсралт үзүүлэлтийг засах санал оруулж байсан. Өнөөдөр бас Зулпхар гишүүн, Хэрлэн гишүүн бас маш олон саналуудыг ийм зөв засаж суурь түвшин зорилтот түвшнийг залруулж байгаад маш их баяртай байна. Миний хувьд бол нийтдээ 12 санал оруулж байгаа. Бүгд энэ шалгуур үзүүлэлтийг засах саналууд оруулсан. Одоо энэ 11, 12 дахь саналыг хэлэлцэх гэж байна. Өмнөх 10 саналын 8-ыг нь дэмжиж өгсөн та нартаа баярлалаа.

21 аймгийн төвүүдийн агаарын бохирдлыг хэмжье гэсэн ганц санал уначихсан байгаад бол бас жоохон сэтгэл дундуур байгаа ч гэсэн дараагийн энэ 2 санал дээр төхөөрөмждөө хүрэхгүй байж дэмжиж өгөхийг хүсэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: 19 дэх санал. Санал хураалт дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 47.4 хувиар санал дэмжигдсэнгүй. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдсэнгүй. Лувсанжамц гишүүний гаргасан санал дэмжигдсэн гэсэн үг.

20.Төслийн 1 дүгээр хавсралтын 38.1.2 дахь дэд заалтад “замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай урьдчилан сэргийлэх сургалтыг ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулах” гэсэн агуулга бүхий 38.1.2.2 дахь дэд заалт шинээр нэмж, тус заалтын харгалзах мөрөнд Хэмжих нэгж: Тоо гэж, Суурь он: 2023 гэж, Суурь түвшин: - гэж, Зорилтот түвшин: 200 гэж тус тус нэмэх гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

36 хувиар Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдсэнгүй.

21.Төслийн 13 дугаар хавсралтын Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багц дахь Эрчим хүчний реформын үндэсний хорооны төсвийг 400.0 сая төгрөгөөр бууруулж, цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд цохиулахаас урьдчилан сэргийлэх стандартыг шинэчлэх, хичээлийн хөтөлбөр боловсруулах, сургагч багш нарыг бэлтгэх, сургах, стандартыг ашиглаж хэвшүүлэх, бодит байдал нь стандартын дагуу байгаа эсэхэд үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгох төсөлд 400.0 сая төгрөгөөр Эрчим хүчний сайдын урсгал зардалд нэмж тусгах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Энхцэцэгт микрофон өгье.

М.Энхцэцэг: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Та бүхэн сүүлийн үед мэдэж байгаа маш их цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарч, ард иргэд ААН-үүд асар их хэмжээний хөрөнгө санхүүгийн хохирол амсаж байгаа. Шангила шатлаа л гэдэг, Алтжин шатлаа л гэдэг, их дэлгүүр шатлаа л гэдэг. Ямар их хэмжээний хохирол амсаж байгаа юм. Мөн хүүхдүүд болон хүн цахилгаанд цохиулж үхэж байгаа. Дарханд зүгээр л нэг айлын 3 хүүхэд тогонд цохиулаад л нас барсан. Улаанбаатар хотод есхөн настай хүүхэд зүгээр аптек орох гэж явж байгаад л бариулаас нь бариад

л тогонд цохиулаад нас барсан. Тэгээд ОБЕГ-аас авсан мэдээллээр сүүлийн 10 жилийн хугацаанд нийтдээ 8392 цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарсан байна. Үүнээс ард иргэд 90 тэрбум төгрөгийн санхүүгийн хохирол амссан байна. Онцгой байдлын газар болохоор 4.9 тэрбум төгрөгийн зардал гаргасан байна. 207 хүн нас барсан байна. 253 хүн түлэгдэж гэмтэж хөгжлийн бэрхшээлтэй болсон байна. Тэгэхээр бид нар ийм хүндээ ээлгүй нийгмийг бий болгочоод байна. Энийг өөрчлөхийн төлөө бүгдээрээ юм хийе ээ гэж би хаврынхаас хойш маш их ярьж байгаа. Энэ ажил тэгээд хамтарсан Засгийн газрын 2024-2028 оны хөтөлбөрт орсон. Мөн Монгол Улсын хөгжлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд орсон ийм ажил байгаа.

Тэгээд энэ ажлыг та бүхэн дэмжиж өгөөч ээ. Би өчигдөр Доржханд Шадартайгаа Эрчим хүчний зохицуулах хороонд хуралд сууж байхдаа бас хэлсэн байгаа. Ийм ажил байгаа ингээд хорооныхоо төсвөөс 400 саяыг ингээд энэ ажилд зарцуулахаар авсан байгаа шүү гэсэн. Шадар маань асуудалгүй ээ гэж ингэсэн байгаа. Тэгээд шадартаа баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд ээ ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал сайдад микрофон өгье.

Н.Учрал: Энэ эрчим хүчний реформын үндэсний хорооны төсвийг сая энэ ажлын хэсгийн үеэр танасан. Тэгээд дээрээс нь энэ Хэрэг эрхлэх газрын даргын багцаас 2023 орон тоо тэгээд бас ер нь танасан шүү дээ тийм. Тэгэхээр одоо 400 сая төгрөгөөр бууруулж гэхээр нэг хэдэн хүний цалин бууруулаад л тэр гал түймэр гарах цахилгаан цохиулахаас сэргийлэхэд нэг хичээлийн хөтөлбөр боловсруул гээд л байгаа юм шиг байгаа юм. Тэгэхээр Чойжоо сайд ч бас ийм юм хүсээгүй байх л даа. Би тэгэхээр 23 орон тоо хасаад цалингийн зардал буурчихсан. Эрчим хүчний реформын үндэсний хорооны төсөв багасчихсан. Төсөв нь ер нь байхгүй болчихсон шүү дээ. Тэгээд Чойжоо сайд хэрвээ үнэхээр 400 сая төгрөг үнэхээр сургалтын хөтөлбөрт хэрэгтэй байвал одоо ядаж цалингаас биш өөр зардлаас гаргаж өгөх юм бодох уу. Тэгэхгүй бол наана чинь нөгөө цалингаас авчихаар бас олон хүний цалингийн асуудал яригдана. Тэгэхээр ийм зарчимгүй юм байж болохгүй байх аа.

Д.Амарбаясгалан: Мөнхчулууны Энхцэцэг гишүүний гаргасан санал Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй. Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

70 гишүүн буюу 61.4 хувиар дэмжээгүй санал дэмжигдлээ.

22.Төслийн 13 дугаар хавсралтын Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багц дахь Эрчим хүчний реформын үндэсний хорооны төсвийн 11,986.1 сая төгрөгийг 9,000.0 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, Н.Б, Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй, Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал. Тэгээд санал гаргасан гишүүд хоёулаа алга байна шүү дээ. Бадамсүрэн, Батсүмбэрэл хоёр.

Тэгэхээр санал гаргасан гишүүд байхгүй юм чинь санал хурааж шийднэ ээ гэсэн үг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

85 гишүүн буюу 74.6 хувиар санал дэмжигдлээ. Гишүүдийн гаргасан санал дэмжигдсэнгүй.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 2 дугаар зүйлийн “батлагдсан өдрөөс” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, эсвэл Байнгын хороо үг хэлэх боломжтой. Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

88 гишүүн буюу 77.2 хувиар санал дэмжигдлээ.

2.Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогыг **1,556.7 сая** төгрөгөөр бууруулах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

89 гишүүн буюу 78.1 хувиар санал дэмжигдлээ

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 2 дугаар зүйлийн “батлагдсан өдрөөс” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

84 гишүүн буюу 73.7 хувиар санал дэмжигдлээ.

2.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогыг **694.0 сая** төгрөгөөр бууруулах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

89 гишүүн буюу 78.1 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёололд нийцүүлэн хуулийн төсөлд өөрчлөлт оруулах санал:

1.Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах зардалд өөрчлөлт оруулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, ангилал, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнтэй уялдуулж төсөвт өртгийг өөрчлөх, мөн төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томьёог жигдлэх засварыг хийх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

85 гишүүн буюу 74.6 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

21.35 цагт

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн тухай төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна аа.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хөхүүгийн Болормаа танилцуулна аа. Индэрт урьж байна.

Х.Болормаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар явуулж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 10, 11-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн.

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 303 дугаар захирамжаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэнгээр ахлуулан байгуулсан бөгөөд Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсэг болон гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээсээ хүсэж байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг нэрийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүй Анар, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүү бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга.

Одоо Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Алга байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Маргааш өглөө 9 цагаас Төсвийн байнгын хороо хуралдана. 10 цагаас нэгдсэн чуулган хуралдаж эхэлнэ ээ. Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*